



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2020

www.goviinoyu.mn



АГУУЛГА

Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ	2
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”	3
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн засаглал	4
Сангийн Удирдах зөвлөл	4
Харилцааны хороо	5
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д хүлээн авах төсөл, хөтөлбөрийн саналын чиглэл	6-8
Санхүүжилт олгох үндсэн чиглэл	6
Сангийн санхүүжилтийн гүйцэтгэл	7
Санхүүжилт олгох үйл явц	8
Ирээдүй хойч үеийн төлөө сан	9-13
“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөр	9
Ирээдүй хойч үеийнхэнд зориулсан хадгаламж	12
“Говийн оюу - Бизнес боломж” бизнесийн бичил зээл	12
Хандив, тусламж	13
Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	14-51
Сангийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрүүд	14
НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилтуудад ХДС-ийн оруулсан хувь нэмэр	17
Сангийн 2020 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт	18
Сангийн 2020 оны онцлох үйл явдал	19
Удирдах зөвлөлөөс баталсан сангийн 2020 оны санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт	20
Сангийн Удирдах зөвлөлөөс 2020 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл хөтөлбөрүүд	24
2020 онд батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	24
Он дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд	34
Санхүүжилтийн квот, 2020 оны квотын санхүүжилтээр хэрэгжих төсөл хөтөлбөр	52-170
Санхүүжилтийн квот, зорилго	52
Ханбогд суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	53
Манлай суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	72
Баян-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	83
Даланзадгад суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	88
Баяндалай суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	101
Мандал-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	106
Сэврэй суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	119
Булган суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	129
Цогт-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	140
Номгон суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	148
Хүрмэн суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, батлагдсан төсөл, хөтөлбөр	158
Сангийн ил тод байдал	171-172
Сангийн хяналт, шинжилгээ-үнэлгээ	173-178
Харилцагч байгууллагууд	179-181
Санхүүгийн тайлан	182-185

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН

МЭНДЧИЛГЭЭ



ТИМ ЭКЕРСЛИ

*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн дарга,
“Оюу толгой” компанийн Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал*

Та бүхэнд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

“Оюу толгой” компани нь “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай Хамтын ажиллагааны гэрээ, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ыг үүсгэн байгуулан ажиллаад 5 дахь жилээ үдлээ.

“Оюу толгой” компани Хамтын ажиллагааны гэрээний дагуу жил бүр таван сая ам.доллартай тэнцэх төгрөгийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аар дамжуулан олгож өнгөрсөн хугацаанд нийт 66 тэрбум төгрөгөөр 250 төсөл хөтөлбөрийг сангаас санхүүжүүлэн, амжилттай хэрэгжүүлээд байна.

2020 онд бид Даланзадгад сумын гэр хорооллын хэсэгт шинээр 1200 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэг, Гашуунсухайт боомтод камераар тоноглогдсон цамхагт харуулын байр мөн аймгийн төвд шинээр байгуулсан усан спортын төвд шаардлагатай хэрэглэл олгох зэрэг төслүүдийг санхүүжүүлэн орон нутгийн талуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Зорилтод сумдад олгодог санхүүжилтийн квотоор иргэд сумандаа нэн шаардлагатай төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлдэг үйл ажиллагаа маань амжилттай үргэлжилж 2020 оны хувьд Өмнөговь аймгийн арван нэгэн сумдад нийт 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн квот олгож 63 төслийг хэрэгжүүллээ.

“Говийн Оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн 2020-2021 оны хичээлийн жилд 47 оюутан хамрагдаж одоогийн байдлаар Өмнөговь аймгийн нийт 234 оюутанд 523.8 сая төгрөгийн тэтгэлэг олгосон байна. “Говийн Оюу - Бизнес боломж” бичил зээлийн хөтөлбөрийн хүрээнд 51 бизнес эрхлэгчдэд 1.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож шинэ ажлын байр бий болгох, орон нутагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр орууллаа.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, хорио цээрийн улмаас орлого нь багассан нийгмийн зорилтот бүлгийн айл өрхүүдийн хүүхдийг тэжээн тэтгэх зорилгоор Өмнөговь аймаг болон Ханбогд суманд нийт 250.0 сая гаруй төгрөгийн хандив тусламжийг олголоо.

2020 он та биднийг төдийгүй дэлхий нийтийг сорьсон хүндхэн жил байсан хэдий ч бид харилцан итгэлцэл, хамтын хүчээр “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийнхаа үйл ажиллагааг улам батжуулж, өнгөрсөн 5 жилийн хугацаанд хийж бүтээсэн амжилтаа тэмдэглэн цаашдын хамтын ажиллагаа маань илүү үр өгөөжтэй байж говь нутгийн тогтвортой хөгжилд түлхэц болно гэдэгт итгэлтэй байгаагаа сангийн Удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа илэрхийлье.

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



АЛСЫН ХАРАА

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



ЭРХЭМ ЗОРИЛГО

Өмнөговьчуудын сайн сайхан амьдралыг дэмжсэн хамтын хөгжлийн санаачилгыг санхүүжүүлэгч сан байна



ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- Авилгалаас ангид байх
- Хувийн ашиг сонирхлоос ангид байх
- Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
- Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
- Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх
- Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюу толгой” компанийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс “Оюу толгой” компани нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу толгой” компани нь жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д олгодог. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Хамтын ажиллагааны гэрээ, түүний сэдэвчилсэн хавсралтаар зохицуулсны дагуу эрүүл мэнд, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэргээр аймгийн болон Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах зохион байгуулах үүрэгтэй ажиллаж байна.

САНГИЙН ЗАСАГЛАЛ



САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сангийн эрх барих дээд байгууллага болох Удирдах зөвлөл нь Өмнөговь аймаг, Ханбогд сум болон “Оюу толгой” компанийн төлөөлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй.

Сангийн хяналтын зөвлөлийн үүргийг хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх хэрэгжүүлдэг бол Гүйцэтгэх захирлаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлдэг.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн хүрээнд байгуулсан дээрх бүтцээс гадна талууд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд харилцан ойлголцол хамтын ажиллагааг дэмжиж, зохицуулах үүрэг бүхий Харилцааны хороог байгуулсан ба Харилцааны хороо нь Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх үүрэгтэй. Харилцааны хороо нь нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй, “Оюу толгой” компанийн төлөөлөл 4 хүн, орон нутгийн төлөөлөл 9 хүн сонгогдон ажиллаж байна. “Оюу толгой” компанийн төлөөллийг Хангамж, хүний нөөц сургалт, байгаль орчин, орон нутгийн харилцаа гэсэн орон нутагтай илүү хамтран ажиллах шаардлагатай хэлтэс албадын төлөөлөл байдаг бол орон нутгийн зүгээс сумдын удирдлага, аймгийн салбар хариуцсан хэлтэс агентлагийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллаж байна.

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Удирдах зөвлөл нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөл 7 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран орон нутгийн төлөөлөл 3 гишүүнийг нэр дэвшүүлж, “Оюу толгой” компаниас 4 гишүүнийг нэр дэвшүүлэн Удирдах зөвлөлийг бүрдүүлдэг.

Сангийн удирдлагыг сайжруулах болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн Дүрмийн дагуу удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, сангийн дүрмийн хэрэгжилтийг сахиулах, хөндлөнгийн хяналт тавих эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх сонгогдон ажиллаж байгаа.

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД 2019-2020 ОН



ТИМ ЭКЕРСЛИ
Удирдах зөвлөлийн дарга



Б.БАЯР
Итгэмжлэгдсэн зөвлөх



Х.СУГИР
Удирдах зөвлөлийн гишүүн



Н.НАРАНБААТАР
Удирдах зөвлөлийн гишүүн



Б.ЭРДЭНЭ-ОЧИР
Удирдах зөвлөлийн гишүүн



ДЕРРИК ХАНСЕН
Удирдах зөвлөлийн гишүүн



Д.АМАРБАЯСГАЛАН
Удирдах зөвлөлийн гишүүн



Г.СУГАР
Удирдах зөвлөлийн гишүүн

ХАРИЛЦААНЫ ХОРОО

Сангийн Харилцааны хороо нь Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Өмнөговь аймаг, “Оюу толгой” компани болон сангаас хамтран ажиллах Түншлэгч сумдын харилцаа хамтын ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой бүтэц бүрэлдэхүүн юм. Харилцааны хороо 13 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж орон нутгийн 9 төлөөлөгчийг томилж ажиллуулдаг. “Оюу толгой” компанийн төлөөлөл 4 гишүүнийг “Оюу толгой” компаниас томилон ажиллаж байна.

САНГИЙН ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД-2019-2020 ОН



Х.БАТБОЛД
Харилцааны
Хорооны дарга



О.ЦЭРЭННАМИД
Харилцааны
Хорооны дарга



Ө.БАЯНМӨНХ
Харилцааны
Хорооны гишүүн



Г.БҮЯНХҮҮ
Харилцааны
Хорооны гишүүн



Д.АМАРТҮВШИН
Харилцааны
Хорооны гишүүн



Ж.СҮХ-ЭРДЭНЭ
Харилцааны
Хорооны гишүүн



Ш.ЭРДЭНЭЖАРГАЛ
Харилцааны
Хорооны гишүүн



Н.ЭРДЭНЭБАЯР
Харилцааны
Хорооны гишүүн



Ү.ЭНХЦАЦРАЛ
Харилцааны
Хорооны гишүүн



А.ОЮУНТУЯА
Харилцааны
Хорооны гишүүн



М.АРИУНТУНГАЛАГ
Харилцааны Хорооны
гишүүн



О.МАНДАХБАЯР
Харилцааны
Хорооны гишүүн



В.МӨНХБАТ
Харилцааны
Хорооны гишүүн


“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-Д ХҮЛЭЭН АВАХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН САНАЛЫН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР, САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь иргэд, байгууллагуудаас Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтууд болох нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ гэсэн чиглэлүүдээр Өмнөговь аймагт хэрэгжих төсөл хөтөлбөрийн санал хүлээн авч Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Өмнөговь аймагт нэн тэргүүний, хэрэгжүүлэх шаардлагатай төсөл хөтөлбөрийг шалгаруулж санхүүжилт олгодог.

Харин Орон нутгийн бизнес хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалтын чиглэлийн төслүүдэд санхүүжилт олгохдоо бид Хаан банктэй гэрээ байгуулж, бичил зээлийн үйлчилгээг хариуцуулснаар жил бүр бизнесээ шинээр эхлүүлэх болон өргөжүүлэх зорилготой Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдэд 50 сая хүртэлх төгрөгийн сарын 1%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгож байна.



САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХАРИЛЦААНЫ ХОРОО, ГОВИЙН ОЮУ ХДС, ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

ҮНДСЭН 7 СЭДЭВЧИЛСЭН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР
САНХҮҮЖҮҮЛЖ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛНА.



Орон нутгийн бизнес хөгжил & бараа үйлчилгээ худалдан авалт

“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИАС ХҮЛЭЭН АВСАН
САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ




- Түншлэгч сум - 4
- Уул уурхайгүй сум - 7
- Бусад сум - 4

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” үүсгэн байгуулагдсанаас хойш мөрдөж ажиллаж байсан санхүүжилтийн дүрэм журмуудад 2018 онд зохих өөрчлөлт оруулан сангийн санхүүжилтийн 3 жилийн стратеги, үндсэн чиглэлийг шинээр баталсны дагуу 2018 оны 2-р улирлаас эхлэн төслийг сонгон шалгаруулж, санхүүжүүлж эхлээд байна.

Сан нь төсөл зарлах үйл явцаа нийгмийн дэд бүтцийн төсөл болон тогтвортой хөгжлийн хөтөлбөр гэсэн 2 төрлөөр тодорхойлсон. Нийгмийн дэд бүтцийн шинж чанартай Өмнөговь аймагт бий болгох бүтээн байгуулалтын төслүүдийг сонгохдоо аймгийн ЗДТГ-аас зөвлөсний дагуу судалгаа шинжилгээ дээр үндэслэх бөгөөд Сангаас санхүүжүүлэх нийгмийн дэд бүтцийн төслүүд нь бүгд зураг төсөл, менежмент болон үйл ажиллагааны зардлыг бүрэн шийдсэн байхаар тодорхойлно. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхдээ 3 жилийн стратегид тусгагдсан чиглэлийн дагуу жил бүр төслийн уралдаан зарлаж шалгуурт нийцсэн төсөл хэрэгжүүлэгчийг сонгож хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бөгөөд Зорилтот сумдад олгодог Санхүүжилтийн квотын хүрээнд сумдын иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, нэн шаардлагатай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Хамтын ажиллагааны гэрээний зорилгод хүрч ажиллахын тулд Санхүүжилтийн удирдамжинд заасны дагуу жилийн нийт санхүүжилтийнхээ 6%-ийг ирээдүй хойч үедээ зориулдаг. Энэхүү хойч үедээ зориулсан сан нь эргэлтийн сангийн хэлбэртэй байх бөгөөд “Говийн оюу-Бизнес боломж” бизнесийн бичил зээлийн хөтөлбөр, Хадгаламж, “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” гэсэн үндсэн гурван хэлбэрээр хуваарилагдан зарцуулагдаж байна.


“ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨР

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2020 онд 5 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.



- ✓ Өмнөговь аймгийн ЗДТГ-аас тус аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсний дагуу аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн төлөөлөл болон хөтөлбөрийн удирдах байгууллагаар сонгогдсон “Говийн оюуны хөтөч” төрийн бус байгууллага болон Өмнөговь аймагт боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн сонгон шалгаруулах хороог байгуулж, 2020-2021 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.
- ✓ “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2020 онд улсын болон магадлан итгэмжлэгдсэн сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 47 оюутанд тэтгэлэг олгосон.

ТЭТГЭЛЭГ АВСАН ОЮУТНУУДЫГ СУМДААР АНГИЛСАН БАЙДАЛ



2020 ОНД “ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУД



А.БОЛОРОО
АШУУИС - Эх барихуй



А.БЯМБАБАЯР
ШУТИС - Уул
уурхайн ашиглалтын
технологи



А.НАНДИНЦЭЦЭГ
МУБИС -
Технологийн багш



А.ТЭГШЗАЯА
ХААИС - Малын эмч



Б.АЗЗАЯА
МУБИС - Англи
хэлний багш




Б.АРИУНЖАРГАЛ
МУБИС - Англи
хэлний багш



Б.ДОЛГОРСҮРЭН
СУИС - Соёлын
менежмент



Б.МИЧИДМАА
ХУИС - Аялал
жуулчлалын
менежмент




Б.МӨНХЗУЛ
Их засаг
ОУИС - Цахилгааны
инженер



Б.МӨНХТҮВШИН
ШУТИС - Агаар
сэлгэлтийн инженер



Б.НАСАНБАТ
ХААИС - Барилгын
инженер



Б.ОТГОНБААТАР
ХААИС - Архитектур
инженер



Б.ОТГОНЦЭЦЭГ
МУБИС - Бага ангийн
багш



Б.ПҮРЭВЖАЛ
Их засаг ОУИС - Эмч



Б.ТАЙВАНЖАРГАЛ
ХААИС - Малын эмч



Г.БАЯРМАА
ШУТИС - Цахилгааны
инженер



Г.ДАШЧИРЭВ
МУБИС -
Технологийн багш



Г.НАНДИНБОЛОР
АШУУИС - Эмч



Г.НЯМЖАРГАЛ
Улаанбаатар эрдэм
ИС - Сэтгэл судлаач



Д.НАНДИН-ЭРДЭНЭ
МУИС - Програм
хангамж



Д.ПҮРЭВ-ОЧИР
ҮБТДС - Биеийн
тамирын багш



Ж.УЛАМ-УНДРАХ
ХААИС - Цахилгааны
инженер



З.АРИУНЦЭЦЭГ
АШУУИС - Эмч



И.БУЯНБАДРАХ
ХААИС - Механикийн
инженер



И.САЙНЗАЯА
МУИС - Англи хэлний багш



Л.МӨНХБИЛГҮҮН
ШУТИС - Уул уурхайн ашиглалтын технологи



Л.ХҮСЭЛХҮҮХЭН
АШУУИС - Сувилагч



М.БУЯНЖАРГАЛ
ХААИС - Байгаль орчны нөхөн сэргээлт



М.ОТГОНЦЭЦЭГ
АШУУИС - Эмч



М.ЧАНЦАЛЛАХАЙ
МШУУИС - Дорноговь - Эмч



О.УУЛСАНАА
МУБИС - Нийгмийн ажилтан



О.ЭРДЭНЭЦЭЦЭГ
МУИС - Програм хангамж



С.АМИНЦЭЦЭГ
ШУТИС - Цахилгааны инженер



С.МӨНХТУЯА
ШУТИС - Мэдээллийн технологи



С.ЦЭНД-АЮУШ
ШУТИС - Архитектур



Т.ДОЛЖИДМАА
АШУУИС - Шүдний эмч



У.ЦЭДЭН-ИШ
Эм зүйн шинжлэх ухааны их сургууль - Уламжлалтын эмч



Х.БАТБОЛД
СУИС - Медиа Анимейшн



Х.ЖАРГАЛМАА
МУБИС - Монгол хэл, уран зохиолын багш



Ц.МЯГМАРНАРАН
АШУУИС - Дорноговь - Эмч



Э.БҮҮВЭЙ
ХААИС - Архитектур



Э.ГЭРЭЛМАА
АШУУИС - Сувилагч



Э.ДАЛАЙЖАРГАЛ
МУИС - Нийгмийн ухааны багш



Э.СОЛОНГО
Глобал удирдагч дээд сургууль - Аялал жуулчлалын менежмент



Э.СУГАРМАА
ШУТИС - Цахилгааны инженер



Э.СҮХБАТ
ХААИС - Барилгын инженер




Э.ЦЭРЭНЖАВ
ХААИС - Байгаль орчны хяналт үнэлгээ

“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт 2016 онд 30, 2017 онд 57, 2018 онд 55, 2019 онд 45, 2020 онд 47 оюутан тус тус хамарсан бөгөөд 2016-2020 онд давхардсан тоогоор Өмнөговь аймгийн 234 оюутанд 523.8 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

“ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

2016-2020 онд олгосон тэтгэлгийг мэргэжлээр ангилсан байдал, n=234



Тэтгэлэгт хамрагдан сургуулиа төгссөн оюутнуудын 87 хувь нь орон нутагтаа ирж эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байна.

“ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”-ИЙН ТУСГАЙ НӨХЦӨЛТ ХАДГАЛАМЖ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудад зориулан жил бүрийн нийт санхүүжилтийн 2%-ийг 10 жилийн хугацаатай хадгаламжинд байршуулж байна. Уг хадгаламжийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нээж одоогийн байдлаар 1.4 тэрбум төгрөг хуримтлуулаад байна.

“ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” БИЗНЕСИЙН БИЧИЛ ЗЭЭЛ ХӨТӨЛБӨР




“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2016 оноос хойш “Говийн оюу-Бизнес боломж” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2020 онд Өмнөговь аймгийн 51 бизнес эрхлэгч иргэдийг дэмжиж зээл олгоод байна. Одоогийн байдлаар бичил зээлийн хөтөлбөр нь 5 дахь жилдээ амжилттай хэрэгжиж нийт 1.4 тэрбум төгрөгийн зээл олгосон.

ЗЭЭЛ АВСАН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ХАРЬАЛАЛ

Сум	Зээлийн тоо	Олгосон зээл /өссөн дүнгээр/
Даланзадгад	36	1,049,000,000
Ханбогд	10	177,000,000
Манлай	2	45,020,000
Мандал-Овоо	1	28,000,000
Булган	1	37,500,000
Ханхонгор	1	48,824,300
Нийт	51	1,385,344,300

ОЛГОСОН БИЧИЛ ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ


Бизнесийн зээлийн төрөл, n=51



ХАНДИВ ТУСЛАМЖ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь сайн санааны үүднээс Өмнөговь аймгийн сумдад шаардлагатай зарим тулгамдсан асуудалд 2016-2020 онд 1.3 тэрбум төгрөгийг Хандив тусламжийн сангийн журмын дагуу олгосон байна.

ОЛГОСОН ХАНДИВЫН ЗОРИУЛАЛТ




САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь 2020 онд 10 төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн сангаас түншлэгч болон уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа сумд болох Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган, Номгон, Хүрмэн сумдад 150 төсөл хөтөлбөр, нийт 250 төсөл хөтөлбөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна.


2015-2020 оны хооронд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” Өмнөговь аймгийг нийтэд нь болон хэсэгчлэн хамарсан томоохон 100 төсөл хэрэгжүүлсэн бөгөөд Санхүүжилтийн квот олгож эхэлснээс хойш 2018-2020 онд Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган, Номгон, Хүрмэн сумдад 150 төсөл хөтөлбөр санхүүжүүлэн хэрэгжүүлж нийт 250 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлээд байна.

2020 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг хамтын ажиллагааны сэдэвчилсэн хавсралтаар ангилсан байдлыг харуулбал

2020 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР - СЭДЭВЧИЛСЭН ХАВСРАЛТ



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2015-2020 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн хавсралтын дагуу ангилвал:



№	Сэдэвчилсэн Хавсралт	Төслийн тоо	Санхүүжилт (₮)	Санхүүжилт (\$)
1	Нийгмийн дэд бүтэц	50	41,307,933,626	17,357,595
2	Байгаль орчны менежмент	13	2,434,361,360	967,608
3	Нийгмийн суурь үйлчилгээ	123	8,172,071,590	3,272,230
4	Орон нутгийн бизнес хөгжил	9	3,142,219,705	1,221,986
5	Уламжлалт мал аж ахуй	11	2,092,669,772	860,242
6	Усны менежмент	12	1,062,225,674	428,365
7	Үндэсний түүх соёл	32	1,412,196,794	628,560


“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2015-2020 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг сумдаар харуулбал



Сумын нэр	Санхүүжилтийн хуваарилалт (₮)	Санхүүжилтийн хуваарилалт (\$)
Бүх сумдыг хамарсан	9,691,792,349	3,891,488
Өмнөговь аймгийн сумдыг хэсэгчлэн хамарсан	1,872,347,858	807,732
Даланзадгад сум	26,931,558,681	11,000,484
Ханбогд	12,858,518,951	5,592,203
Манлай	3,270,596,924	1,378,786
Баян-Овоо	2,503,966,997	1,088,066
Булган	251,165,300	97,597
Мандал-Овоо	1,378,297,739	558,419
Сэврэй	238,743,000	93,156
Цогт-Овоо	231,165,300	90,000
Номгон	231,165,300	90,000
Баяндалай	231,165,300	90,000
Хүрмэн	81,089,700	30,000

САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Зорилтот үр шим хүртэгч



	Хүүхэд	Эмэгтэйчүүд	Залуучууд	Малчин	Ахмад настан	Эмзэг бүлгийн иргэд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
2020	26230	21560	4786		1288	260	
2019	32574	53475	959	10763	12074	90	4313
2018	10592	13,181	1920	3040	77	90	1995
2017	7504	173	11514	531	12375		300
2016	6486	1000	18450	6971	38		
2015	593						

НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ХДС-ИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР




ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 3

- Чадавхжуулах сургалт
- Тоног төхөөрөмж нийлүүлэх хөтөлбөр
- Иргэдэд мэдлэг, мэдээлэл өгөх сургалт



ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 4

- Сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмж
- Сургалт, сургалтын хэрэглэгдэхүүн



БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ - ЗОРИЛТ 6

- Гашуунсухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж
- Сумдад худаг гаргах ажил




ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 8

- Бизнес хөгжлийг дэмжих төсөл
- Хөдөлмөр эрхлэхэд шаардлагаар тоног төхөөрөмж нийлүүлэлт
- Иргэдэд мэдлэг, мэдээлэл өгөх сургалт



ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ - ЗОРИЛТ 9

- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, музей, спорт заалны барилга



ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 11

- Сургалт, нөлөөллийн ажил
- Иргэдийн ая тухтай амьдрах орчинг сайжруулах тохижилт, үйлчилгээний ажил




УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨГ БАГАСГАХ - ЗОРИЛТ 15

- Сумдад мод тарих



ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ - ЗОРИЛТ 16

- Хүний наймааны хохирогч, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлсэн



ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БИЙ БОЛГОХ - ЗОРИЛТ 17

- 66 тэрбум ₮ буюу 27.2 сая \$-ийн хөрөнгө оруулалт хийж 300 гаруй түнштэй болсон

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН 2015-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮН



САНГИЙН 2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ



Удирдах зөвлөлийн хурал

2020.07.08

Санхүүжилтийн квотоор 63 хөтөлбөр хэрэгжсэн

2020.04-12 сар - Санхүүжилтийн квот байгуулсан сумдад тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжсэн.



2019 оны санхүү үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэсэн.



2020.07

Олон улсын байгууллагуудтай хамтарсан хөтөлбөрүүд

- Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр - 2018-2021
- Орон нутгийн бизнес хөгжлийг дэмжих хамтарсан хөтөлбөр - 2018-2020



ХДС-ийн 2019 оны тайланг хэвлүүлж олон нийтэд танилцуулав

2020.02
3000 хувь хэвлүүлж олон нийтэд түгээв.



Зорилтот сумдад санхүүжилтийн квот олгож эхлэв

2020.03-04 сар - Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Номгон, Булган, Цогт-Овоо, Мандал-Овоо, Хүрмэн сумдын засаг дарга нартай санхүүжилтийн квотын гэрээ байгуулав.


Харилцааны хороо хурал

2020.07.01



Говийн Оюу-Оюутны тэтгэлэг

- 2020.09 - 47 оюутан тэтгэлэгт хамрагдаж өссөн дүнгээр 234 оюутанд тэтгэлэг олгосон.



УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНГИЙН 2020 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ХУВААРИЛАЛТ

№	ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР	САНХҮҮЖИЛТ (₮)	САНХҮҮЖИЛТ (\$)
НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ			
1	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын менежмент	145,000,000	53,644.30
2	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын нэмэлт ажил	135,799,518	50,240.48
3	Өмнөговь аймгийн музейн нэмэлт ажил	3,636,193,692	1,345,248.67
4	Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга	4,626,167,267	1,711,499.96
5	Өмнөговь аймгийн сайжруулсан түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж	1,330,800,000	492,343.66
6	Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга	450,000,000	166,482.30
7	Гашуунсухайт боомтын хяналтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр	188,880,300	69,878.28
Дэд дүн (А)		10,512,840,777	3,889,337.65
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР			
1	Орон нутгийн бизнес хөгжлийг дэмжих хөтөлбөр	756,416,000	279,844.17
2	Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	1,350,729,072	499,716.64
3	Усан спортоор биеэ чийрэгжүүлье	231,206,257	85,537.22
Дэд дүн (Б)		2,338,351,329	865,098.03
САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮД			
ХАНБОГД СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (В)	189,209,300	70,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	1,683,536	639.51
1	Элбэг чацаргана	17,335,000	6,413.27
2	Хүүхдийн төлөө за гэж хэлцгээе	12,000,000	4,439.53
3	Ханбогд хайрхан	15,000,000	5,549.41
4	Тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй	24,702,000	9,138.77
5	Тамхийг биш эрүүл мэндээ сонгоё	8,000,000	2,959.69
6	Шүдний кабинет	10,000,000	3,699.61
7	Түүхэн замнал	20,000,000	7,399.21
8	Ухаалаг худаг	22,000,000	8,139.13
9	Чавхдаст хөгжмөө тоглоё	6,470,000	2,393.65
10	Мянган мод	18,000,000	6,659.29
11	Эрүүл хүнс хадгалалт	27,000,000	9,988.94
Эрсдэлийн сангийн зарцуулалт		9,460,465	3,499.99



БАЯН-ОВОО СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Г)	135,149,500	50,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	20,195,325	7,671
1	Шуудан үйлчилгээ	41,700,000	15,427.36
2	Амжилт	41,700,000	15,427.36
3	Шинэ технологи, багшийн хөгжил, хүүхдийн хөгжил	42,000,000	15,538.35
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	13,179,600	4,875.93
МАНЛАЙ СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Д)	135,149,500	50,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	6,595,540	2505.41
1	Шинэ сургууль, шинэ орчин, шинэ санаачилга	32,350,000	11,968.23
2	Биеийн тамирын гадна талбай тохижуулах	56,711,500	20,981.02
3	Зан үйлийн өргөө	4,640,000	1,716.62
4	Эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлт	8,995,000	3,327.80
5	Дулаан байр тухтай орчин	22,504,000	8,325.59
6	Цэвэр орчин цэмцгэр байгууллага	9,604,500	3,553.29
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	6,757,475	2,500.00
ДАЛАНЗАДГАД СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Е)	135,149,500	50,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	21,860,500	8,304
1	Аюулгүй орчин-Амьдралын баталгаа	36,000,000	13,318.58
2	Монтессорын сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан хөгжүүлэх арга зүй хөтөлбөр	5,000,000	1,849.80
3	Шинэ зууны хот соёлтой иргэн	37,969,000	14,047.04
4	Эрүүл бие-Амжилтын үндэс	24,491,600	9,060.93
5	Эрүүл хүнс-Эрүүл бие	5,000,000	1,849.80
6	Ультмах	24,820,000	9,182.42
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	-	-
БАЯНДАЛАЙ СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ё)	81,089,700	30,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	625,517	237.61
1	Амгалан орчин	38,226,936	14,142.46
2	Соёлын төвийн дотор тохижилт	20,343,800	7,526.41
3	Ухаалаг худаг	22,500,000	8,324.12
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	-	-

СЭВРЭЙ СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ж)	81,089,700	30,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	375,100	142.49
1	Насан туршийн боловсрол Насан туршийн баталгаа	8,845,600	3,272.52
2	Англи хэлтэй Сэврэйн багачууд	2,750,000	1,017.39
3	Ёслол хүндэтгэлийн өргөө	38,990,000	14,424.77
4	Багийн хөгжлөөс сумын хөгжил	5,380,000	1,990.39
5	Сэврэй сумын бэлчээр усжуулалтын ажил	23,480,000	8,686.68
Эрсдэлийн сангийн зарцуулалт		-	-
МАНДАЛ-ОВОО СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (З)	81,089,700	30,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	474,420	180.22
1	Тоглоом-Хүүхдийн хөгжил	8,000,000	2,959.69
2	Цаг уурын мэдээг цагт нь	4,000,000	1,479.84
3	Иргэнээ дээдэлсэн ээлтэй үйлчилгээ	19,850,000	7,343.72
4	Өнөд дээдлэх өв соёл	9,870,000	3,651.51
5	Өөдлөх айлын өнгө	14,703,000	5,439.53
6	Амар тайван амьдралын орчин	6,578,000	2,433.60
7	Ногоон сургууль	12,700,000	4,698.50
Эрсдэлийн сангийн зарцуулалт		4,000,000	1,479.84
ЦОГТ-ОВОО СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (И)	81,089,700	30,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	16,045,415	6095.08
1	Түргэн тусламжийн автомашин нийлүүлэх	23,000,000	8,509.10
2	Хамтдаа сурч, хамтдаа хөгжье	15,000,000	5,549.41
3	Дотуур байрны хүүхдийн ор	9,990,000	3,695.91
4	Эко орчинг хамтдаа бүтээцгээе	45,088,000	16,680.79
Эрсдэлийн сангийн зарцуулалт		4,050,000	1,498.34
НОМГОН СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Й)	81,089,700	30,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	5,733,100	2177.80



1	Стандарт хаяг	19,393,000	7,174.65
2	Сургуулийн хашаа	28,945,000	10,708.51
3	Хүүхэд хөгжил	15,000,000	5,549.41
4	Малын эмч нарын цахим систем	4,870,000	1,801.71
5	Тоглоомын талбай	14,000,000	5,179.45
Эрсдэлийн сангийн зарцуулалт		4,000,000	1,479.84
БУЛГАН СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (К)	81,089,700	30,000
	2019 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	9,264,445	3519.23
1	ЭМТ-ийн гал тогооны тоног төхөөрөмж	10,000,000	3,699.61
2	Булган фитнес төхөөрөмж	7,000,000	2,589.72
3	Нэгдсэн гудамжны гэрэлтүүлэг	39,500,000	14,613.45
4	Монгол бичгийн кабинет тохижуулах	6,000,000	2,219.76
5	Арьс шир боловсруулах үйлдвэр	10,000,000	3,699.61
6	Дуу хөгжмийн кабинет	8,000,000	2,959.69
Эрсдэлийн сангийн зарцуулалт		9,166,000	3,391.06
ХҮРМЭН СУМ			
	2020 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Л)	81,089,700	30,000
1	Тусгай ротын хүүхдийн талбай	7,500,000	2,774.71
2	Хоггүй сум-Хүрмэн сум	9,700,000	3,588.62
3	Зөөлөн эдлэл	6,000,000	2,219.76
4	Хүрмэн гоёл	16,239,999	6,008.16
5	Дотуур байр-Бидний хөгжлийн орчин	20,000,000	7,399.21
6	Ногоон хүрмэн	1,500,000	554.94
7	Эрүүл мэндийн төвийн анализатор нийлүүлэх хөтөлбөр	16,000,000	5,919.37
Эрсдэлийн сангийн зарцуулалт		-	-
БУСАД			
1	Ирээдүй хойч үеийн төлөө сан	810,897,000	300,000.00
2	Хандив тусламж	335,149,500	124,000.00
3	ХДС-ийн үйл ажиллагаа	675,747,500	250,000.00
Дэд дүн (М)		1,821,794,000	674,000.00

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2020 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

2020 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

▶ “ДАЛАНЗАДГАД СУМЫН 1200 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:
БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:
2020 ОНД ГОХДС-С БАТЛАГДСАН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
“ХҮННҮГИЙН ГОВЬ” ХХК
10,211,387,025 ТӨГРӨГ
4,626,167,267 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сумын 6 сургуулийн 5 нь 2 ээлжээр хичээллэдэг, шинэ төлөвлөлтийн бүс дэх гэр хорооллуудад оршин сууж байгаа 3193 өрхийн хүүхдүүд сургууль цэцэрлэгтээ 4-6 км холоос явдаг. Энэ нь нийтийн тээвэр хөгжөөгүй тус суманд хүүхдүүд их холоос сургууль, цэцэрлэгтээ явахад бэрхшээлтэй байдаг. Даланзадгад суманд 2591 хүүхдийн суудал дутагдаж байгаа зэрэг нөхцөл байдалд үндэслэн төслийг санаачилсан.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Даланзадгад сумын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлэх, жил бүр хүрээгээ тэлж буй төвөөс алслагдсан гэр хорооллын хүүхдүүдийн сурах нөхцөлийг сайжруулах, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга барих төслийг 2020-2021 онд санхүүжүүлэхээр шийдвэрлэж үүнээс 2020 онд 4,626,167,267 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хүннүгийн говь” ХХК, санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- ✓ 2020 онд орон нутгийн зах зээлээс 1,2 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, орон нутгаас 125 түр болон байнгын ажлын байр бий болсон.
- ✓ Барилга угсралтын ажил 2020 оны эцсийн байдлаар 35 хувьд хүрэв.

ҮР ДҮН:

- ✓ Даланзадгад сумын сургуулийн хүртээмж нэмэгдэнэ.
- ✓ 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлнэ.
- ✓ Анги дүүргэлтийг багасгана.
- ✓ Алслагдсан гэр хорооллын сурагчид гэртээ ойрхон сургуульд явах нөхцөл бүрдэнэ.
- ✓ 100 орчим шинэ ажлын байр бий болно

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ 35%-Д ХҮРЭВ



▶ “УСАН СПОРТООР ХИЧЭЭЛЛЭЖ БИЕЭ ЧИЙРЭГЖҮҮЛЬЕ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
“ЦАМХАГ ӨРГӨӨ” ХХК
231,206,257 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад хотноо баригдсан Шинэ спорт цогцолборын барилга угсралт бүрэн дуусч ашиглалтанд орохтой холбоотойгоор тус усан бассейн болон дотор заалны тохижилтонд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах шаардлага хэрэгцээ байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Шинэ спорт цогцолборыг олон улсын стандартад нийцүүлэн тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Усан спортоор хичээллэж биеэ чийрэгжүүлье” төслийг санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Цамхаг өргөө” ХХК, санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар хөтөлбөрийн ажлыг эхлүүлэв.
- ✓ Өмнөговь аймгийн Соёл спорт цогцолборын усан бассейн, спорт зааланд 49 нэр төрлийн 472 ширхэг тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлсэн.

ҮР ДҮН:

- ✓ Тамирчдад бэлтгэл сургуулилт явуулах, хүүхэд залуучууд усан спортоор хичээллэх орчин бүрдсэн
- ✓ Стандартад нийцсэн усан бассейныг тохижуулснаар ард иргэдийн усан спортоор хичээллэх нөхцөл боломж сайжирсан.
- ✓ Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл мэндийг нь сайжруулах эерэг дэмжлэг болж байна.



► “ХАНБОГД СУМЫН СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГИЙН
ЦОГЦОЛБОРЫН НЭМЭЛТ АЖИЛ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:
БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
“БИНДЭР АЛТАЙ ОЮУ” ХХК
135,799,518 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөвт урлагийн заал, номын сан болон бусад өрөөнд халаалтын систем бүрэн төлөвлөөгүйн улмаас хүйтний улиралд сургууль, цэцэрлэгийн халаалт хангалтгүй байсан. Мөн шилэн гэгээвчийг өөрчлөхгүй бол говийн нөхцөлд тохиромжтой бус, бороо цасны ус гоожиж, барилгын ашиглалтын горимыг алдагдуулж байсан учир сургууль, цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, сургалтын ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагатай байсан.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- ✓ Урлагийн заал, номын сан болон бусад өрөөнүүдийн халаалтын системийг шийдвэрлэх
- ✓ Шилэн гэгээвчийг өөрчилж цас борооны үед ус гоождоггүй болгох

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын халаалт, дээвэр, шилэн гэгээвчийн нэмэлт ажил” төслийг санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Биндэр алтай оюу” ХХК, санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- ✓ Ханбогд сумын 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын халаалтгүй өрөөнүүдэд халаах хэрэгсэл байрлуулсан, дээврийн шилэн гэгээвчийн хийцлэлийг өөрчилж цас, борооны ус гоождоггүй болгосон.
- ✓ 2020 оны 08 дугаар сарын 10-нд улсын комисс ажиллаж төслийн ажлыг хүлээж авсан.

ҮР ДҮН:

- ✓ Ханбогд сумын 29-р цэцэрлэгийн 280 хүүхэд, 29 багш ажилчид, 2-р сургуулийн 708 сурагч, 55 багш ажилчдын сурах, ажиллах орчин нөхцөл сайжирсан.
- ✓ Сургууль цэцэрлэгийн халаалт бүрэн шийдвэрлэгдсэн.
- ✓ Бороо цасны ус, барилгын ашиглалт бүрэн шийдэгдэж, багш, сурагч, ажилчдын тав тухтай орчин бий болсон.



► **“ГАСУУНСУХАЙТ БООМТЫН ХЯНАЛТЫН КАМЕРААР
ТОНОГЛОГДСОН ЦАМХАГТ ХАРУУЛЫН БАЙР БАРИХ” ТӨСӨЛ**



ЗАХИАЛАГЧ:
БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ХИЛИЙН 0131 ДҮГЭЭР ЦЭРГИЙН АНГИ
188,880,300 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Гашуунсухайт боомт нь экспортын бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нэвтрүүлж буй гол боомт тул зорчих хөдөлгөөн ачаа тээврийн ачаалал маш их байдаг. Гэтэл боомтоор хүн, ачаа тээвэрлэж буй замын орчимд камержуулалт хангалтгүйгээс зөрчил илрүүлэх боломж сул байгаа нь төрийн байгууллага хяналт тавих, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж муутай байна. Энэхүү сул талыг технологийн тусламжтайгаар шийдвэрлэх бололцоотой юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Гашуунсухайт боомт орчмыг камержуулж Цагаан хад суурингаас хилийн боомт хооронд зорчиж яваа иргэд, суудлын болон ачаа тээврийн хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Гашуунсухайт боомтын хяналтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр барина.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Гашуунсухайт боомтод хяналтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр барих” төслийг дэмжиж санхүүжилтийг батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хилийн 0131 дүгээр цэргийн анги” хооронд ажил гүйцэтгэх гэрээ байгуулав.

ҮР ДҮН:

- ✓ Цагаан хад суурингаас хилийн боомт хооронд зорчиж яваа иргэд, суудлын болон ачаа тээврийн хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах
- ✓ Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох
- ✓ Хил хамгаалах үйл ажиллагаанд дорвитой дэмжлэг болно.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ “ДАЛАНЗАДГАД СУМЫН 200 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:
ТӨСӨВТ ӨРТӨГ:
2020 ОНД ГОХДС-С БАТЛАГДСАН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
2,215,485,316 ТӨГРӨГ
450,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулж чадахгүй байгаа, зарим хүүхдүүдийн хамрагдаж буй цэцэрлэг 4-6 км хол байрлалтай байдаг нь хүүхэд, гэр бүлд бэрхшээлтэй байдаг. Даланзадгад сумын Гурван сайхан, Нисэх, Баруун сайхан хорооллын хойд тал, Төгөл зэрэг алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн насны 300 хүүхэд бүртгэлтэй. Улсын стандартаар цэцэрлэгийн нэг ангид 25 хүүхэд хамрагдах ёстой байтал Даланзадгад сумын бүх цэцэрлэгийн анги дүүргэлт дунджаар 40 хүүхэдтэй, мөн дээрх хорооллуудын 136 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа зэрэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрт тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөл тааруу байгааг өөрчилж хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах боломжоор хангах шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- ✓ Даланзадгад сумын сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрт тэгш, хүртээмжтэй явуулахад дэмжлэг болох.
- ✓ Даланзадгад сумын Гурван сайхан хороололд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” төслийг 2020-2021 онд санхүүжүүлэхээр баталж үүнээс 2020 онд 450,000,000 төгрөгөөр уг төслийг дэмжив.
- ✓ Захиалагч Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан.

ҮР ДҮН:

- ✓ Даланзадгад сумын цэцэрлэгийн хүртээмж нэмэгдэнэ.
- ✓ Анги дүүргэлтийг багасгана.
- ✓ Хүүхдүүд гэртээ ойрхон цэцэрлэгт хамрагдана.
- ✓ Сургуулийн өмнөх боловсролын хоцрогдол багасна.
- ✓ 35 ажлын байр шинээр бий болно.
- ✓ Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд бүрийн тоогоор эцэг эхчүүд, асран хамгаалагч нар ажил эрхлэх боломжтой болж өрхийн орлогоо нэмэгдүүлнэ.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2019 ОНООС ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

▶ “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
БАРИЛГА УГСРАЛТ, ИНТЕРЬЕР ДОТОР ЗАСЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ:	“АГЛУТ” ХХК
ГАДНА ШУГАМ СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ:	“ДҮЖИЙ ХАЙРХАН” ХХК, “ТАНГАД АРАА” ХХК, “ЭРДЭНИЙН ГҮН ГОВЬ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	9,773,713,692 ТӨГРӨГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

- ✓ Барилга угсралтын ажил: **5,795,000,000 төгрөг**
- ✓ Гадна шугам сүлжээний ажил: **215,344,809 төгрөг**
- ✓ “Музейн барилгын дотор засал (интерьер), лифт, үүдний гонх барих” төсөл: **2,089,053,404 төгрөг**
- ✓ “Өмнөговь аймгийн музейн барилга барих төсөл” -ийн нэмэлт ажил: **471,702,337 төгрөг**
- ✓ “Музейн сан хөмрөгийн өрөөний тоног төхөөрөмж нийлүүлэх”: **137,454,000 төгрөг**
- ✓ “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах”: **493,990,000 төгрөг**



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд хэсэгт байрлах үзэсгэлэнт байгальтай, говь нутгийн байгаль цаг агаарт зохицсон уламжлалт нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын арвин уламжлалтай нутаг юм. Байгалийн өвөрмөц тогтоц нь, үзэсгэлэнт газрыг түшиглэсэн аялал жуулчлал нь аймгийн эдийн засгийн тулгуур салбарын нэг юм. Монгол улсад ирж буй жуулчдын 80 гаруй хувь нь говь нутгийг үзэж сонирхохоор ирдэг. Эдгээр жуулчдад нутаг орны соёлын өв, говь нутгийн нэрийн хуудас болсон үлэг гүрвэл олдвор зэрэг палеонтологийн ховор нандин үзмэрүүдийг үзүүлэхэд аймгийн музейн одоогийн барилгын хүчин чадал хаана нь ч хүрдэггүй. Учир нь музейн барилга нь 1954 онд чулуугаар барьсан аймгийн анхны зочид буудал, 1969 онд аж ахуйн аргаар хоёр давхар болгосон барилга юм. Барилгад суулт өгч, хана цуурсан зэрэг эвдрэл гэмтэл нь музейн үйл ажиллагаанд тавигдах MNS 5634:2006 стандартын шаардлага хангахгүй, үзмэрүүдийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж байна.

Энэ нөхцөл байдлын улмаас барилгын болон галын улсын байцаагчийн дөрвөн удаагийн дүгнэлтээр үйл ажиллагааг зогсоох шаардлага тавигдаад байгаа. Иймд уг барилгыг музейн зориулалтаар цаашид ашиглах боломжгүй болсон.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь стандартын шаардлага хангасан, барилга архитекторын өвөрмөц шийдэл бүхий музейн барилгыг барьж бүрэн тохижуулан ашиглалтанд оруулах юм. Ингэснээр Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгох, гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн Музейн барилга” төслийг 5.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж батлав.
- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилга байгууламжийн нэмэлт ажил” төслийг 3.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Аглут” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- ✓ 2020 оны эцсийн байдлаар барилгын ажил болон тохижилтийн ажил 95 хувьд хүрэв.
- ✓ 2018 онд орон нутгийн зах зээлээс 246 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 58 түр болон байнгын ажлын байр бий болсон.
- ✓ 2019 онд орон нутгийн зах зээлээс 455 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 123 түр болон байнгын ажлын байр бий болсон.
- ✓ 2020 онд орон нутгийн зах зээлээс 183 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, орон нутгаас 43 түр болон байнгын ажлын байр бий болсон.

ҮР ДҮН:

- ✓ Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгоход музей чухал үүрэг гүйцэтгэнэ.
- ✓ Гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулна.

► “ХАНБОГД СУМЫН ҮЕРИЙН ДАЛАН,
СУВАГ БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
“АРЦ СУВАРГА” ХХК
1,257,711,282 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын төвийн газарзүйн байршил нь нам дор ба сумын төвийн баруун болон урд уулнаас үерийн ус их буудаг. 2015 онд дуу цахилгаантай аадар бороо 30 минут орох төдийд сумын төв бүхэлдээ усанд автаж төрийн болон иргэдийн өмч хөрөнгө ихээр эвдэрч сүйдсэн, айлуудын бохир хальж иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлсөн зэрэг аюул тохиож байсан юм.



ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь сум, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, байгалийн унаган тогтоцыг хөндөхгүй, стандартын шаардлага хангасан үерийн далан, суваг байгуулж, байгалийн гэнэтийн, давагдашгүй хүчин зүйл болох үер усны гамшгаас ард иргэдээ хамгаалах, сумын төвийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Ханбогд суманд үерийн далан, суваг барих” төслийг санхүүжүүлэхээр дэмжиж батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Арц суварга” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- ✓ 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр улсын комисс ажиллан үерийн далан, сувгийн байгууламжийг ашиглалтанд шилжүүлсэн.

ҮР ДҮН:

- ✓ Сумын төвд оршин суудаг 5500 орчим иргэд эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөл бүрдэнэ.
- ✓ Байгалийн гэнэтийн, давагдашгүй хүчин зүйл болох үер усны аюулаас иргэдийн амьдрах орчин, амь нас, өмч хөрөнгийг хамгаална.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

▶ “ХАНБОГД СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ЛАНДФИЛЛЫН БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
“МӨНХ ӨРГӨӨ” ХХК
591,422,413 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг, Ханбогд сумын ахуйн хог болон хорт бодисын хаягдал зэрэг нь байгальд ил задгай байгаагаас хөрсөөр болон агаар дуслаар дамжин малын бэлчээр, орчин тойрныг бохирдуулахаас гадна гадаргын болон гүний усыг бохирдуулж олон төрлийн өвчний эх үүсвэр болох эрсдэлтэй юм. Хүн ам ихээр төвлөрсөн, хурдацтай өсөн нэмэгдэж байгаа тус суурин газрын хогийг цуглуулах, тээвэрлэх, ялгах, хадгалах, булах нэгдмэл үйлдвэрлэл мэт процессийг зөвхөн хогийг хотоос гаргаж тээвэрлэх асуудал мэт ойлгож хогийн цэг, хогийн толгой, хогийн хонхор, хогийн жалга гэх мэт нэртэй газарт тээвэрлэн ил асгадаг дадал зуршилтай болсон нь төвлөрсөн газар байх хогийн цэгийн тусгай менежментийг буй болоход сэтгэл зүйн саад болсоор байна.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- ✓ “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Ханбогд сумын ландфиллын байгууламж барих” төслийг дэмжиж санхүүжилтийг батлав.
- ✓ Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Мөнх өргөө” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- ✓ 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр улсын комисс ажиллаж ландфиллын байгууламжийг ашиглалтанд шилжүүлсэн.

ҮР ДҮН:

- ✓ Ханбогд суманд хог хаягдлыг ландфиллын аргаар байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээргүй, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд булшлах боломжтой байгууламж бий болсон. Ингэснээр хог хаягдлын менежментийг цаашид зөв зохистой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

▶ “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



ЗАХИАЛАГЧ:

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ:

ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ

НИЙГЭМЛЭГИЙН САНХҮҮЖИЛТ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ

2,382,466,000 ТӨГРӨГ

1,946,936,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” IRIM судалгааны хүрээлэнтэй хамтран 2017 онд Өмнөговь аймгийн иргэд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр олон талт хэлэлцүүлгийг зохион байгуулж “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2018-2021 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг боловсруулан сангийн Харилцааны хороо, Удирдах зөвлөлийн хурлуудад танилцуулан батлуулсан. Дээрх “Орон нутгийн жижиг, дунд бизнесийн хөгжил олон талт хэлэлцүүлэг”-ийн тайланд болон Өмнөговь аймгийн жижиг, дунд бизнесүүдийг дэмжих, чадавхжуулах, орон нутгийн шинэ бренд бүтээгдэхүүнүүдийг бий болгох зэрэг хэрэгцээ шаардлагад үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- ✓ Өмнөговь аймгийн эдийн засгийн төрөлжилт, өсөлтийг урт хугацаанд хангахад дэмжлэг үзүүлэх
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох
- ✓ Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- ✓ Орон нутгийн хөгжлийн урт хугацааны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо, чадавх, өрсөлдөх чадварыг сайжруулах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтарсан санхүүжилтээр Даланзадгад суманд “Өмнөговь аймгийн жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх” хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд:

- ✓ Даланзадгад сумын төвд Бизнесийн инноваци, хөгжлийн төв байгуулсан.
- ✓ АЗДТГ, “Оюу толгой” компани, хөтөлбөрийн хамтран санхүүжүүлэгч байгууллагуудын төлөөлөл, бие даасан эдийн засагч нарыг оролцуулсан Удирдах хороог байгуулан ажилласан.
- ✓ Төвийн үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч GIZ /Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/-с удирдан хэрэгжүүлсэн.
- ✓ Төвөөс үйлчилгээ авахаар бүртгүүлсэн компаниудад урьдчилсан үнэлгээ, дүн шинжилгээ хийж түвшнийг нь тогтоож тохирох чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан.
- ✓ Чадавхжуулах сургалтууд нь:
 - Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал
 - Бизнесийн нэгдмэл байдал ба дүрэм журмыг мөрдөх нь
 - Санхүүгийн боловсрол
 - Хүний нөөцийн удирдлага
 - Компанийн удирдлага менежмент
 - Худалдан авалт, ложистик, нийлүүлэлтийн сүлжээний менежмент, кластерын хөгжил
 - Чанарын удирдлага
 - Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийн менежмент, аж үйлдвэр
 - Хууль эрх зүй, гэрээний менежмент
 - Дижитал технологи ба хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах
 - Борлуулалт, маркетинг
 - Инновацийн менежмент
 - Байгаль орчин тогтвортой байдал

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

“Оюу толгой” компанийн одоогийн ханган нийлүүлэгч, ханган нийлүүлэгч болохоор ажиллаж байгаа компаниуд, ЖДҮ-ийг сургаж, чадавхжуулах бөгөөд үүний үр дүнд тухайн компанийн гүйцэтгэл, үйл ажиллагаа сайжирсан

“Оюу толгой” компанийн ирээдүйн ханган нийлүүлэгчдэд зориулсан сургалт:

- ✓ Сургалт нь нийт 8-10 сэдвээс бүрддэг. Тухайлбал, Хүний нөөц, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа г.м
- ✓ 102 удаа сургалт зохион байгуулсан.
- ✓ Оролцогчид: 736, үүнээс 37.7 % эмэгтэй

“Оюу толгой” компанийн одоо ажиллаж буй ханган нийлүүлэгчдэд зориулсан сургалт, зөвлөх үйлчилгээ:

- ✓ Сургалт нь “Үйлдвэрлэлийн менежмент” багц сэдвээс бүрддэг, энэ багц нь нийт 48 дэд сэдэвтэй. Тухайлбал, Бизнесийн төлөвлөлт, 5 S, КАЙЗЕН, г.м.
- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээний тоо: 48
- ✓ Оролцогчид: 408, үүнээс 60.7 % эмэгтэй

Өмнөговь аймгийн хоршоодыг чадавхжуулах:

- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ нь нийт 45-50 багц сэдвээс бүрддэг. Тухайлбал, Хоршоо, хоршооны гишүүн, хоршооны бизнес, кластер, бренд бүтээгдэхүүн, ХАА-н үйл ажиллагаа г.м.
- ✓ Сургалт, арга хэмжээний тоо: 20
- ✓ Оролцогчид: 236, үүнээс 54.4% эмэгтэй
- ✓ Санхүүжилт: 3 хоршоонд тоног төхөөрөмжийн шинэчлэлд тус бүр 10,0 сая төгрөг олгосон

Өмнөговь аймгийн Брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх:

- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ нь нийт 30 гаруй сэдвээс бүрддэг. Тухайлбал, Брэндийг бүтээх, Umbrella brand, Брэндийн онцлог, Брэндийн худалдаа г.м.
- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ, арга хэмжээний тоо: 25-30
- ✓ Оролцогчид: 150-160, үүнээс 57.9 % эмэгтэй
- ✓ Санхүүжилт: нийт 50.0 сая төгрөг 3 брэнд

Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих:

- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ нийт 15 гаруй сэдвүүдээс бүрддэг. Тухайлбал, бизнесээ эхэлье, бизнесийн загварчлал, таамаглал, тооцоолол г.м.
- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ, арга хэмжээ: 22
- ✓ Оролцогчид: 354 үүнээс 79.7 % эмэгтэй

Тендерийн бичиг баримт боловсруулах, санхүүжилтийн төсөл боловсруулах:

- ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ нийт 50 гаруй сэдвээс бүрддэг. Тухайлбал ЖАЙКА төслийн хөнгөлттэй зээлийн болзлууд, стартеги ба бизнес төлөвлөлт, байгууллагын ба санхүүгийн удирдлага г.м.
- ✓ Сургалт бусад арга хэмжээ: 30 гаруй
- ✓ Оролцогчид: 75, үүнээс 71.4 % эмэгтэй

Өмнөговь аймгийн Торомны самнасан ноосны нийлүүлийг нэмэгдүүлэх:

- ✓ Сургалт нь нийт 25-30 сэдэвтэй. Тухайлбал, хэрхэн ноос зөв самнах, боловсруулах, ноосны нийлүүлэлт г.м.
- ✓ Сургалт: 3
- ✓ Оролцогчид: 75, үүнээс 72 % эмэгтэй
- ✓ Санхүүжилт: Өмнөговь аймгийн 4 сумд тором самнах хашаа барьж өгсөн, нийт өртөг 12,0 сая төгрөг

Ногоон хөгжил, Тогтвортой Хөгжил:

- ✓ Сургалт нь маш өргөн хүрээтэй, тухайлбал Тогтвортой Хөгжлийн Боловсрол, НҮБ 17 зорилт, эрчим хүч, усны зохистой хэрэглээ г.м.
- ✓ Сургалт, арга хэмжээ: 20
- ✓ Оролцогчид: 257, үүнээс 57.2 % эмэгтэй
- ✓ Санхүүжилт: Даланзадгад сумын 4 ЕБС нийт 12.0 сая төгрөг

Бусад арга хэмжээ:

- ✓ Өмнөговийн аялал жуулчлалын бага хурал, сургалт – 100 хүн, 54% эмэгтэй
- ✓ Өмнөговийн эмэгтэй бизнес эрхлэгчдийн чуулга уулзалт – 120 хүн, 100% эмэгтэй
- ✓ Сургалт, мэдээллийн аялал – 4 удаа (БНХАУ, Гүрж улс, ХБНГУ, ОХУ-Беларусь)

- ✓ Сургалтын болон технологийн гарын авлага – 17 төрөл боловсруулсан.
- ✓ Хууль, эрх зүйн сургалт, зөвлөх үйлчилгээ – 12, оролцогчид 80 гаруй, үүнээс 52% эмэгтэй
- ✓ Өмнөговь аймгийн ЖДҮ, Брэнд бүтээгдэхүүний тухай 14 ТВ контент, нэвтрүүлэг бэлтгэж 32 удаа үндэсний ТВ-ээр орон даяар түгээсэн.
- ✓ Хоршоодын 10 га газарт гүний худаг, усжуулалтын систем барьсан.
- ✓ Ногоон/инновацийн төслүүдэд 30.0 сая төгрөгийн санхүүжилт үзүүлсэн.
- ✓ “Өмнөговьд үйлдвэрлэв” дэлгүүрийг Улаанбаатар хотод нээсэн.
- ✓ КОВИД 19 ийн үед ЖДҮ ийг дэмжих, КОВИД 19–тэй тэмцэх зарим арга хэмжээ



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ХАМТРАН САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР,
ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА,
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН,
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ХҮН АМЫН САН**

НИЙТ ТӨСӨВ:

12,187,819,360 ₮

ГОВИЙН ОЮУ ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ:

4,268,657,180 ₮

2020 оны жилийн эцсийн байдлаар 3,518,780,988 ₮ олгосон

НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:

2,993,414,100 ₮

НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:

778,774,400 ₮

ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ:

496,468,680 ₮

АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:

1,216,835,000 ₮

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:

2,433,670,000 ₮

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймагт нийт 60,675 байнгын оршин суугч хүн амын гуравны нэг нь 15 хүртэлх насны иргэд, гуравны хоёр нь 15-с дээш насны иргэд байна. 15-34 насны залуучууд нийт хүн амын 35%-ийг, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд мөн хүн амын гуравны нэгийг эзэлдэг. Хөдөлгөөнт хүн амын тоо их, оршин суугчидтайгаа бараг тэнцүү буюу ойролцоогоор 60,000 байгаа нь хүн амын тоон хурдацтай өсөлтөнд нөлөөлж байна.



Өмнөговь аймагт эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд 212.9, үр хөндөлт 1,000 амьд төрөлтөд 301 байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлт юм.

Өсвөр насны охидын төрөлт 2016 онд 1,000 амьд төрөлт тутамд 24 байсан. Тус аймагт халдварт болон халдварт бус өвчлөл аль аль нь өндөр байгаа юм. БНХАУ-ын хилийн боомт руу өдөр бүр нүүрс тээвэрлэх 6,500 хүртэлх тооны ачааны машин зорчдог холын тээврийн зам дээрх осол гэмтлийн улмаас зам тээврийн осол гэмтэл, нас баралт өндөр байна. Умайн хүзүүний хорт хавдар нь эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолддог хоёр дахь хавдар юм. Умайн хүзүүний хорт хавдрын үзлэг, оношилгоо Өмнөговь аймагт доогуур үзүүлэлттэй буюу оршин суугчдын ойролцоогоор 30 хувийг хамарч байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) зэрэг нь улсын хэмжээнд түгээмэл, өргөн тархсан бөгөөд уул уурхайн үйл ажиллагааны оргил үед хамгийн өндөр байдаг. Нийгэм, эдийн засгийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хэрэгжилт эхний үе шатандаа явж байгаа бөгөөд орон нутгийн чадавхыг хөгжүүлэх, орон нутгийн түвшин дэх хөрөнгө нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага их байна.

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудыг дэмжих НҮБ-ын байгууллагуудын нэгдсэн хөтөлбөр нь Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилт 2030, Өмнөговь аймгийн хөгжлийн стратеги, түүнчлэн НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ)-ний Үр дүн 2 (нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хамруулсан нийгмийн үйлчилгээг хүргэх) болон Үр дүн 3-ыг (иргэдийн дуу хоолойг дэмжих, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх) хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй хөтөлбөр юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ҮР ДҮН:

Нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд:

1. Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.
2. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.
3. Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.
4. Орон нутгийн түвшний засаглал бэхжиж, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт бий болгох, хүрч үйлчлэх ажил хийгдсэн байна.
5. Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлжиж, залуучуудын асуудлаарх бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.
6. Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**Үр дүн 1: Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.**

- ✓ ЭХЭМҮТ-ийн дэмжлэгтэйгээр нярайн эмч нарыг ажлын байран дээрх сургалтанд хамруулав.
 - ЭХЭМҮТ-ийн нярайн эрчимт эмчилгээний тасагтай хамтран 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өрхийн эмч нарт ажлын байрны дагалдан сургалтыг зохион байгуулав. Үүнээс 8 эмч, мэргэжилтнийг хүндэвтэр нярайн тохиолдол дээр ажиллуулан зөвлөх эмчийн зүгээс мэргэжлийн зөвлөгөө, чиглэл хүргэн ажиллав. Цаашлаад нярайн тасагт эмчлэгдэж байгаад эндсэн өвчтөний түүхтэй /8/ танилцан нярайд үзүүлсэн тусламжийн байдал, хийсэн эмчилгээ, сувилгааны талаар хэлэлцүүлэг зохион байгуулж анхаарах зүйлсийг тодорхойлсон. Сургалтын үр дүнд нярайн эмч мэргэжилтнүүдийн нярайн сэхээн амьдруулалт, сэхээн амьдруулалтын үед нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн.
- ✓ Сумын эрүүл мэндийн төвийн эх баригчдыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чадавхжуулав.
 - 2020 оны II улиралд сум, өрх, БОЭТ-ийн хүүхдийн болон хүүхдийн асуудал хариуцсан эмч нарын төлөөлөл 38 хүнийг оролцуулан “Нярайн тусламж үйлчилгээг сайжруулах нь” сургалтыг зохион байгуулав. Сургалтаар нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн бүтэлт сэхээн амьдруулалт, нярайн үзлэгийн онцлог, үнэлгээ, шарлалт, нярайн эмчилгээний онцлог, өтгөрүүлгийг тооцох, дистресс хам шинж, хүчилтөрөгч эмчилгээ зэрэг ур чадварт суралцсан. Сургалтаар нийт 50 хүүхдийг үзэж, зөвлөгөө өгч, 40 эхэд сургалт хийж өрхийн хүүхдийн асуудал хариуцсан 2 эмчийг дагалдуулан ажлын байран дээрх сургалтад хамруулж чадавхжуулсан. Мэдлэг шалгах тест сургалтын эхэнд 51%-тай байсан бол сургалтын төгсгөлд 74% болж 23% хувиар оролцогчдын мэдлэг чадварт нэмэгдсэн. Сургалтын үр дүнд эмч мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, нярайн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулсан.
- ✓ БОЭТ-ийн БНҮЭМ-ийн цогц үйлчилгээний нэгжид эмч, болон зөвлөхийг цалинжуулан ажиллуулж байна.
 - БОЭТ-ийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн БНҮЭМ-ийн цогц үйлчилгээний нэгжид нэн шаардлагатай эмч, зөвлөхийг ажиллуулж байна. Тийнхүү нийт 14 сумын эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай зөвлөгөө мэдээллийг цахимаар болон утсаар тогтмол өгч төрөх эмэгтэйчүүдийн тасагт хянагдаж буй эмэгтэйчүүдийг аймгийн төв, хөдөө орон нутгаар ялган тусламж үйлчилгээ хүргэж эхэлсэн нь үйлчлүүлж буй эмэгтэйчүүд өөрт шаардлагатай цогц тусламж үйлчилгээг нэг дороос авах, зөвлөгөө мэдээлэл авах бүрэн боломжтой болсон. 2020 оны 3-р улирлын байдлаар нийт 128 эмэгтэйд НҮЭМ-ийн тусламж үйлчилгээг үзүүлж, үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөө, ГБТ-ийн арга ЖСА хэрэглээний талаарх зөвлөгөөг өгч ажилласны дүнд давтан үр хөндөлт гараагүй байна. Мөн үр хөндөлтийн өмнөх зөвлөгөөг сайтар өгснөөр 18 эмэгтэй үр хөндөлт хийлгэх шийдвэрээсээ татгалзаж буцсан байна. Өрх болон сумын эмнэлгүүдтэй мэдээллийг харилцан солилцож, тус кабинетаар үйлчлүүлсэн эмэгтэйчүүддээ ЖСА хэрэглүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.
 - Жирэмсний эмгэгийн тасгаар үйлчлүүлсэн нийт 500 гаруй эмэгтэйд эмчилгээ, оношилгоо, зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан. 2020 оны 3-р улирлын байдлаар нийт төрөлтийн 90 /7.3%/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт юм. Цаашлаад үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 65,2-р буурсан боловч, охидын үр хөндөлт 2,9-р нэмэгдсэн байна.
- ✓ Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай клиникийн алгоритм сонгон, хэвлүүлэв.

- ✓ Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндэд анхаарч ажиллав
 - Өмнөговь аймагт өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын тархалтыг тодорхойлох суурь судалгааны тайланг эцэслэн боловсруулж, хэвлүүлэн, аймгийн хоёрдогч түвшинд үзүүлж буй сэтгэцийн эрүүл мэндийн бүх үйлчилгээг бэхжүүлэв. Судалгааны үр дүнгээс харахад өсвөр насны хүүхдүүдийн 41.8 хувь нь өөрсдийгөө эрүүл гэж үздэг бөгөөд тэдний 51.3 хувь нь сэтгэл хөдлөл, зан үйлийн бэрхшээлтэй, 6.9 хувь нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байна. Өсвөр насныхны өөрийгөө үнэлэх үнэлгээний дагуу “Стрессийг даван туулах чадваргүй байдал”, “Ганцаардал” нь өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн байдалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл байв. Тайланг 2021 оны эхний улирлад олон нийтэд танилцуулна.
 - Дээрх ажлын хүрээнд БОЭТ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсролын газар, эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын эмч, мэргэжилтнүүд, сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийн эмч зэрэг 30 мэргэжилтний зөвлөгөө өгөх ур чадварыг дээшлүүллээ. БОЭТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн кабинетийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилтоор ханган өсвөр насныханд зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэхэд ээлтэй орчныг бүрдүүлэв.
- ✓ БОЭТ-ийн амаржих газрын хүлээлгийн хэсгийг тохижуулав.
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн хүлээлгийн хэсгийг тохижуулах ажлыг дэмжин түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулан засвар, тохижилтын ажлыг бүрэн гүйцэтгүүлэв.
 - Өмнөговь аймгийн үе тэнгийн сургагч багш нар болон үе тэнгийн сүлжээг дэмжих аймгийн түвшиний зөвлөл байгуулж, сүлжээг бэхжүүлэв.
 - Цогтцэций сумын ЕБС-ын 27 сурагчид Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үндэсний сургагч багш Ш.Галбадрахтай хамтран зохион байгуулж, үе тэнгийн сургагчаар бэлтгэгдсэн сурагчдад гэрчилгээ олгов. Даланзадгад сумын 24 үе тэнгийн сургагчдын мэдлэгийг бататгах уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт тусгах саналыг авч нэгтгэсэн байна. Аймгийн БОЭТ, ЭМГ, Политехник коллеж, ЕБС сургууль, Өсвөр үеийн кабинет, хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн эмнэлэгийн их эмч, эх баригч эмч нарын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Өсвөр үеийн хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, багш, нийгмийн ажилтнууд зэрэг нийт 18 хүнийг оролцуулан салбар дундын уялдааг сайжруулах, бодлогын баримт бичигт тусгах ажлын санал, хүүхэд болон залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага судлах уулзалт хэлэлцүүлэг мөн зохион байгуулсан байна.

Үр дүн 2: Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.

- ✓ БОЭТ-д БЗДХ-ын эмчийг цалинжуулан ажиллуулж БЗДХын тандалт, тархвар судлалыг өргөжүүлэхэд холбогдох хүний нөөцийг чадавхжуулахад дэмждэг үзүүлэв.
- ✓ БЗДХын тандалт, тархвар судлалыг өргөжүүлэх, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг АЗДТГ, ХӨСҮТ-ийн ДОХ/ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгааны алба, АШУҮИС-ын эмч, багш нар, ЭМГ хамтран нийт 5 байгууллагын нийт 155 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд зохион байгуулав. Үүнд:
 - БОЭТ-ын эх барих эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, дотор, мэдрэл, бактерологи их эмч, серологи их эмч, халдварт, яаралтай тусламжийн их эмч нийт 15
 - 14 сумын эрхлэгч, их эмч, эх баригч нар болон бусад эмнэлгийн мэргэжилтнүүд нийт 110
 - 4 өрхийн ЭМТөвийн их эмч, лаборант, эх баригч нийт 8

- Хувийн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүд, дотор, лабораторын их эмч нар нийт 22 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулан танхим, дадлага, ажлын байрны дагалдан, цахим хэлбэрээр сургалтыг нийт 5 өдөр 4 удаа зохион байгуулж, сургалтын үр дүнг өмнө болон дараа асуумж, тестээр үнэлэхэд мэдлэг, дадлага, чадвар 30 хувиар нэмэгдсэн.
- БОЭТ-с серологи эмч-1, БЗДХ-ын сувилагч-1 Ханбогд, Цогтцэций, сумын ЭМТ лаборант тус бүр-1 хүнийг ХӨСҮТ-д ажлын байрны дагалдан сургалтанд хамруулаад байна.
- Энэхүү сургалтаар бэлгийн замаар дамжих халдварын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх чиглэлээр орчин үеийн нэгдсэн ойлголттой болж, эрт илрүүлэг, оношилгооны чадвар нэмэгдсэн бөгөөд илрүүлэг өмнөх оноос 3 дахин нэмэгдэж, хавьтал судлал 2 дахин нэмэгдэж, нюжентийн шалгуур болон ELISA-тоног төхөөрөмж ашиган оношлох чадвар 100 хувь нэмэгдсэн байна. Жирэмсний хяналтанд орсон эмэгтэйчүүдийг 100 хувь тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамруулж илэрсэн тохиолдол бүрийг хавьтлын хамт 100 хувь эмчлэн эрүүлжүүлж байна
- ✓ Өмнөговь аймгийн БЗДХ-ын тусламж, үйлчилгээний чадавх, хүртээмжийг сайжруулах хүрээнд 11 суманд эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийв.
- ✓ Ханбогд сумын малчдын эрүүл мэндийг дэмжих санаачилга
 - Санаачилгын хүрээнд Ханбогд сумын сум дундын эмнэлэгт алслагдсан баг, хөдөөний өрх айлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх, хөдөлгөөнт чиргүүлийг хүлээлгэн өгөв. Үйл ажиллагааны үр дүнд алслагдсан хөдөөний айлд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх, хэнийг ч орхихдуулахгүй байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. Явуулын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиргүүл нь шаардлагатай эрүүл мэндийн багаж тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор тоноглогдсон.

Үр дүн 3: Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.

- ✓ Халдварт бус өвчний илрүүлэг, эмчилгээ, осол гэмтлийн тусламж үйлчилгээ сайжирсан байна. #”БиХариуцлагатай аян”
 - Зам тээврийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтэлд хариу арга хэмжээ авах үндэсний болон аймгийн түвшний үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс ЗДТГ, түүний дэргэдэх Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Цагдаагийн Газар, ЭМГ, ГБХЗХГ-ууд хамтран #”БиХариуцлагатай аян”-ыг аймгийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сараас 2 сарын хугацаанд зохион байгуулж байна. Аяны хүрээнд зам тээврийн осол гэмтлийг бууруулах, урьдчилан сэргийлэх авто замын зорчих хэсэг орчин нөхцөлийг сайжруулах, залуучуудад эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, БЗДХ, ЖСХ, зам тээврийн осол гэмтлийн мэдээлэл харилцааны контент боловсруулан иргэд, олон нийтэд хүргэв. Үүнд зам тээврийн осол аваараас урьдчилан сэргийлэх зорилгоор 5 удаагийн хяналт шалгалт, 1 удаагийн сурвалжилга зохион байгуулж, 20 ширхэг постор, 6 төрлийн видео шторк, 10,000 ширхэг санамж сэрэмжлүүлэг хэвлүүлж, 2000 ширхэг замын хөдөлгөөний дүрэм агуулсан хэзрийг хэвлүүлэн түгээв. Аяны хүрээнд хийгдсэн постер болон шторкийг “Өмнөговь аймгийн Цагдаагийн газар” цахим хуудсанд байршуулж boost post хийлгэсэн бөгөөд 4 шторкийг 21934 иргэнд аяны хүрээнд хийгдсэн 10 постерийг 30221 Өмнөговь аймгийн харьяа иргэнд аяны талаарх мэдээлэл хүргэсэн байна. Мотоциклтой хөдөлгөөнд оролцож байгаа 100 гаруй иргэдийг А ангиллын сургалтад хамруулж, хамгаалах хэрэгслээр ханган ажилласан. Мөн аяны хүрээнд гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий гарын авлага хэзрийг 2000 ширхгийг хэвлүүлж Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумын залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан зорилтот бүлгийн хүүхэд, залууст түгээсэн байна.

Үр дүн 4: Орон нутгийн эрүүл мэндийн салбарын засаглал, чадавх бэхэжсэн байна

- ✓ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу сумдын Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулах
- ✓ Өмнөговь аймгийн 15 суманд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд шинээр Даланзадгад сумын 1, 2, 6, 8-р багийн 3 төв дээр залуучуудын зөвлөлийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.
- ✓ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх
- ✓ Өмнөговь аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хурлыг 2020.08.24-ний өдөр залуучуудын гарааны бизнес болох STREET27 дундын оффист зохион байгуулав, Хуралд салбар зөвлөлийн гишүүд, хэвлэл мэдээллийн байгууллага, залуусын төлөөлөл, ГБХЗХГ, ЗХТ-ийн ажилтнууд нийт 20 хүн оролцож аймгийн Залуучуудын хөтөлбөрын явцын тайлан, Залуучуудын хөгжлийн сарын аяны үйл ажиллагааг идэвхжүүлэх шийдвэрүүдийг гаргаж ажилласан.
- ✓ Мөн Монголын залуучуудын өдөр буюу 2020.08.25-ныг тохиолдуулан тус өдөр Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Эрдэнэцэцэг Даланзадгад, Цогтцэций сумын залуучуудын хөгжлийн төвийн ажилтнууд Ханбогд сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хурлын үйл ажиллагааг хамтран зохион байгуулж туршлага судлан хурлын явцыг Ханбогд сумын FB пейж хуудас, Алтанговь ТВ-ийн пейж хуудсаар шууд дамжуулж ажиллалаа. /Хуралд нийт 20 хүн оролцсон ба лайв үзсэн хүний тоо 2800/

Үр дүн 5: Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлжиж, залуучуудын асуудлаар бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.

- ✓ Өмнөговь аймгийн Боловсролын салбарын удирдах ажилтнуудын II зөвлөгөөн
 - Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ЕБС-ийн удирдах ажилтны II зөвлөгөөнийг 2020 оны 08-р сарын 26-нд Даланзадгад суманд хийж нийт 65 хүн оролцов. Удирдах ажилтны зөвлөгөөнөөр Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудын эрүүл мэндийн боловсролыг олгоход хөрөнгө санхүүжилт болон, ГБХЗХГ, ЭМГ-тай хэрхэн хамтарч ажиллаж байгаа талаар мэдээлэл өгөв. Мөн удирдлагуудыг багаар ажиллуулан өөрсдөд тулгамдаж байгаа асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар багаар ажиллуулан, зөвлөмжийг гарган хэрэгжүүлж ажиллахаар болов. Энэхүү зөвлөгөөнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулах нь аймгийн хэмжээнд эрүүл мэндийн хичээл зааж байгаа багш нар, сургуулийн удирдлагууд болон бусад байгууллагуудын хамтын үйл ажиллагааг уялдуулан бэхжүүлэхэд өндөр ач холбогдолтой байна хэмээн дүгнэв.
- ✓ Зорилтот бүлгийн залуучуудыг өсвөр үеийн кабинетийн үйлчилгээнд холбон зуучлах талаар гаргасан залуучуудын манлайлал, санаачилга, нөлөөллийн үйл ажиллагааг дэмжих
 - Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдын залуучуудын хөгжлийн төвийн ажилтнууд болон шинээр Залуучуудын хөгжлийн төв байгуулагдаж байгаа Булган, Гурвантэс, Номгон сумдад ажиллах ажилтнуудыг чадавхжуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, төвүүдийн сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Сургалт нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 6 төвийн 20 гаруй ажилтан албан хаагчдыг ажлын байран дээрх сургалт, туршлага судлах арга хэмжээнд хамрууллаа. Сургалтаар төвд ажиллах албан хаагчид сургалт мэдээлэл өгөх, суманд залуучуудтай ажиллахад тулгамдаж буй асуудал бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, хэлэлцүүлэг, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах болон харилцааны ур чадварт суралцсан.
- ✓ Өмнөговь аймгийн Даланзадгад дахь Залуучуудын хөгжлийн төвд шилэн хаалт хийх

- Даланзадгадын Залуучуудын Хөгжлийн төв нь ГБХЗХГ-тай нэг байранд үйл ажиллагаа явуулж байсныг Соёл, спортын цогцолборт нүүлгэн шилжүүлэх саналыг дэмжин ЗХТ-ийн байрны шилэн хаалтыг шийдвэрлэв. Тийнхүү тус төв нь бие даан үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой болов.
- ✓ Зорилтот бүлгийн залуучуудын шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоог хангах чиглэлээр тогтмол мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн удирдлагаар хангах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
 - Ханбогд сумын Залуучуудын хөгжлийн төв дээр сэтгэл засалч, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслан үйлчилгээг хүргэх зорилгоор шаардлагатай боловсон хүчнийг гэрээгээр ажиллуулав.
 - Мөн 2020.10.12-15-ны өдрүүдэд “Талархлын хүч” ТББ-ын сэтгэлзүйч Г.Баясах, Д.Бодьсайхан нарыг урилгаар ажиллуулан ГБХЗХГазрын мэргэжилтнүүд, ӨҮК-ын эмч нийт 25 хүнд Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүйд сургах сургалт, ЕБ-ын 2-р сургуулийн 67 сурагч, 4-р сургуулийн дотуур байрны 61 сурагч, Үе тэнгийн сурагч 25 сурагч, 2-р сургуулийн 100 эцэг эх, 3-р сургуулийн 47 багш нарт харилцаа хандлагын талаарх сургалт нийт 325 хүнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулав.
- ✓ Эрүүл мэндийн хичээлийн Бэлгийн боловсрол, жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх агуулгыг заах арга зүйн чиглэлээр аймгийн хэмжээний бүх ЕБС болон МСҮТ-ийн багш нарт сургалт зохион байгуулав.
 - Эрүүл мэндийн хичээл ордог багш нарын мэдлэг чадвар арга зүйг дээшлүүлэх зорилгоор 4 дэх удаагийн шаталсан сургалтыг 22 сургуулийн эрүүл мэндийн багш нарыг хамруулан зохион байгуулан ажиллалаа. Сургалтыг МУБИС-ийн Боловсролын суурь судалгааны төвтэй хамтран 9-р сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад нийт 55 багш хамрагдаж харилцан туршлага солилцож ажлын байрандаа бие биенээсээ суралцсан. Сургалтын үр дүн эрүүл мэндийн багш нар эрүүл мэндийн талаарх судалгаа, арга зүйг хэрхэн дэмжих, хичээл заах арга зүй, хэлэлцүүлэг зохион байгуулах ур чадварт суралцсан. Сургалтын үр дүнд цаашид багш нарын онолын мэдлэгийг шат дараатайгаар нэмэгдүүлж, аймгийн хэмжээний бодлогын баримт бичиг боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Үр дүн 6: Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.

- ✓ ЗДТГ-аас ЖСХ болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвийг өргөтгөх ажлын даалгавар, техникийн нөхцөлийг баталж, засгийн газрын худалдан авах ажиллагааны дүрэм, журмын дагуу цахим хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулав. Гүйцэтгэгчийг сонгон өргөтгөлийн барилгын ажлыг 100% гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулснаар Өмнөговь аймагт гэр бүлийн хүчирхийлэл болон бусад эрсдэлийн золиос болсон иргэд, эмэгтэйчүүд, хүүхэд, залууст үзүүлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэж нийт 276 хоногт 110 үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.
- ✓ Аймгийн нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, зохих протокол, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр чадавх бэхжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
 - Монголын урлагийн сэтгэл засалчдын мэргэжлийн холбоотой хамтран 2020 оны 04 сарын 13-16-ны өдрүүдэд Даланзадгад сумын хамтарсан багийн гишүүд, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд хамруулан онлайн сургалт хийв.
 - Мөн 2020 оны 04 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд ГБХЗХГ-ын дарга Б.Эрдэнэцэцэг, НЦҮТ, түр хамгаалах байрны зохицуулагч Ж.Энхтуяа, нийгмийн ажилтан Ц.Оролзод, сэтгэл зүйч У.Уянга нар Монголын Урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо

НҮТББ, Эрэгтэйчүүдийн “Хамтдаа” НҮТББ, Хүүхдийн тусламжийн 108 утасны хамгаалах байр, Хүүхдийн эрх хамгаалал-Үжин төвийн үйл ажиллагаатай танилцан, арга зүйн зөвлөгөө авч, туршлага судалсан. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийг хүлээн авч, аюулгүй байдлын хамгаалалт, нийгмийн ажлын үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, сэтгэлзүйн үйлчилгээ, хууль зүйн үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн эрх хамгаалал Үжин-2 төвийн үйл ажиллагаатай танилцан, бүтэн өдрийн турш үйл ажиллагаанд оролцож, кейс бүрдүүлэлтийн талаар арга зүйн зөвлөгөө авч дагалдан сургалтад хамрагдсан. Сургалтын үр дүнд НЦҮТ-ийн ажилтнуудыг хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, зохих протокол, тэмдэглэл, бүртгэл, холбогдох дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр чадавх бэхжиж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

COVID-19 бэлэн байдал

- ✓ Эрүүл мэндийн сайдын 2020 оны а/259 тоот тушаалаар батлагдсан “Коронавируст халдварын талаар сургалт зохион байгуулах тухай” тушаалын дагуу үндэсний сургагч багш нар Өмнөговь аймагт коронавируст халдварын сэргийлэлт, хяналт болон эмнэлгийн бэлэн байдалд үнэлгээ өгөх, орон нутагт сургагч багш бэлтгэх сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтаар аймгийн хэмжээнд 18 сургагч багшийг 6 чиглэлээр бэлдэж, Цогтцэций сумын сум дундын эмнэлэгт жишиг байдлаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад сургалтыг хэрхэн зохион байгуулах, бэлэн байдлыг хэрхэн үнэлэх зэргийг газар дээр нь дагалдан сургалт хийж аймгийн сургагч багш нарыг чадавхжуулж амжилттай зохион байгуулсан.
- ✓ Аймгийн хэмжээнд бэлтгэгдсэн сургагч багш нар 2020 оны 06 сарын 25-наас 07 дугаар сарын 08-ны өдрүүдэд 4 багт хуваагдаж, 14 сумын эрүүл мэндийн төв, 4 өрхийн эрүүл мэндийн төвүүд, хилийн боомт, уул уурхайн компаниудын эмч нарт сургалт хийж, бэлэн байдлыг үнэлж, зөвлөгөө өгөх ажлыг амжилттай зохион байгуулж дууслаа. Тус сургалтад нийт 82 эмч, 91 сувилагч, тусгай дунд мэргэжилтэн, 45 эмнэлгийн ажилтан, нийт 218 хүнийг хамруулж чадавхжуулсан байна.
- ✓ Арга хэмжээний хүрээнд эмчилгээ оношилгооны шинэ технологийг орон нутагт нэвтрүүлж байгаатай холбоотойгоор PCR шинжилгээ хийх эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ХӨСҮТ-ийн лабораторийн тасагт ажлын байрны дагалдан сургалтад үе шаттайгаар хамруулж, 8 эмч мэргэжилтэнг сургаж мэргэшүүлж байна. Вируслогийн лаборатори байгуулахтай холбоотойгоор орон нутгийн 4 эмч мэргэжилтэнг Сэлэнгэ, Дархан аймгийн Вируслогийн лаборатори, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лабораторид туршлага судлах арга хэмжээг зохион байгуулсан.



САНХҮҮЖИЛТИЙН КВОТ


САНХҮҮЖИЛТИЙН КВОТ, ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд олгох жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Түншлэгч болон уул уурхайгүй сумдад (хамтад нь “Зорилтот сумд” гэх) квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын болон Өмнөговь аймгийн иргэд, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, тусгай дэмжлэг шаардлагатай хүмүүсийн амьдрал ахуй, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилахыг эрмэлзэнэ.

Тухайн жилд Түншлэгч болон уул уурхайгүй сумдад дээрх зорилгоор хуваарилах санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тогтооно:

- ✓ Ханбогд сум 70,000 ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- ✓ Манлай, Баян-овоо, Даланзадгад сумд 50,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- ✓ Уул уурхайгүй сумд тус бүр 30,000 ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот

№	Зорилтот сумын нэр	2020 онд ХДС-аас хуваарилсан санхүүжилт	2020 онд нийт хуваарилах боломжтой санхүүжилт	2020 онд төсөл хөтөлбөрт хуваарилж зарцуулсан санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	Ханбогд сум	189,209,300	190,892,836	189,967,465	925,371
2	Манлай	135,149,500	141,745,040	141,562,475	182,565
3	Баян-Овоо	135,149,500	155,344,825	138,579,600	16,765,225
4	Даланзадгад	135,149,500	157,010,000	133,280,600	23,729,400
5	Баяндалай	81,089,700	81,715,217	81,070,736	644,481
6	Сэврэй	81,089,700	81,464,800	79,445,600	2,019,200
7	Булган	81,089,700	90,354,145	89,666,000	688,145
8	Номгон	81,089,700	86,822,800	86,208,000	614,800
9	Цогт-Овоо	81,089,700	97,135,115	97,128,000	7,115
10	Мандал-Овоо	81,089,700	81,564,120	79,701,000	1,863,120
11	Хүрмэн	81,089,700	81,089,700	76,939,999	4,149,701



■ 2018-2020 онд “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжилтийн квот олгосон сумд

2020 ОНД ХАНБОГД СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

▶ 1. “ ШҮДНИЙ КАБИНЕТ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
“МЕД БУЯН” ХХК
10,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын Сум дундын эмнэлгийн шүдний кабинет нь 2009 оноос үйл ажиллагаа явуулж иргэдэд шүдний үзлэг, эмчилгээг тасралтгүй хүргэн ажиллаж байна. Эмнэлгийн барилга анх ашиглалтанд ороход шүдний кабинетийг ор, үзлэг, эмчилгээний тоног төхөөрөмжөөр тохижуулсан боловч одоогоор уг тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул эрүүл ахуй, эмчилгээний стандартад нийцсэн орчинг шинэчлэн бий болгох шаардлагатай болсон.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Шүдний кабинетийг шинэчлэн тохижуулах зорилго нь сумын иргэд, хүүхдүүд болон уул уурхайн ажилчдад эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан орчинд үйлчлэх, амны хөндийн өвчлөлийг бууруулах, мэргэжлийн эмч, сувилагчид тохилог орчинд ажиллахад дэмжлэг болох юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Ханбогд сумын Сум дундын эмнэлгийн шүдний кабинетэд 7 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Ханбогд сумын Сум дундын эмнэлгийн шүдний кабинет шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан.
- ✓ Сумын иргэд, хүүхдүүд болон уул уурхайн ажилчид эрүүл ахуй, эмчилгээний стандартад нийцсэн орчинд үйлчлүүлж байна.
- ✓ Иргэдийн амны хөндийн өвчлөлийг буурахад эерэг үр дүн гарна.
- ✓ Шүдний мэргэжлийн эмч, сувилагч тогтвор суурьшилтай ажиллах, ур чадвараа дээшлүүлэх боломж бүрдсэн.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2. “ТАМХИЙГ БИШ ЭРҮҮЛ МЭНДЭЭ СОНГОЁ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ХАНБОГД СУМЫН ИРГЭН Э.УНДРАХНАРАН

8,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол улсад сүүлийн 10 жилд тамхинаас үүдэлтэй зүрх, судасны эмгэгээр нас барах тохиолдол хоёр дахин нэмэгдэж, нас барж байгаа гурван хүн тутмын нэг нь зүрх судасны эмгэг, таван хүн тутмын нэг нь хорт хавдрын өвчнөөр нас барж байна, Монгол улсын 15-64 насны дөрвөн хүн тутмын нэг нь буюу 27 хувь нь тамхи татдаг гэсэн мэргэжлийн байгууллагын судалгаа, дүгнэлт гарсан байдаг. Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн иргэдийн эрүүл мэндийн боловсролд дэмжлэг үзүүлэх шаардлагатай болсон.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

“Тамхийг биш эрүүл мэндээ сонгоё” сургалт зохион байгуулах зорилго нь зорилтот насны болон бусад насны эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох тамхины шалтгаант өвчлөл, нас баралтаас урьдчилан сэргийлэх, илрүүлэг үзлэгт тодорхой хугацааны давтамжтай хамруулах тогтолцоог бүрдүүлж, цаг алдалгүй эрт оношлох, эмчлэх, эрүүлжүүлэх, хүндрэлээс сэргийлж нас баралтыг бууруулах юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Ханбогд сумын Сум дундын эмнэлгийн сургалтын танхимд техник хэрэгсэл нийлүүлж, нэг сарын хугацаанд 15-39 насны 1816 иргэдэд тамхины хор уршгийн талаар 4 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Сургалтанд хамрагдсан иргэд тамхины хор уршиг, тамхинаас татгалзсанаар бий болох олон эерэг үр дүнгийн талаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй болсон.
- ✓ Тамхины шалтгаант өвчний эрт илрүүлэх үзлэгт тодорхой хугацааны давтамжтай хамруулах тогтолцоог бий болгох алхам болсон



Ханбогд сумын Гал түймэр унтраах, аврах 66 дугаар ангийн ажилтан С.Еркенур:

Аврагч гал сөнөөгч хүн эрүүл мэнд, бие бялдарын хувьд эрүүл байж ард иргэддээ түргэн шуурхай тусламж үзүүлэх үүрэгтэй байдаг учираас бид хорт зуршлаас татгалзах ёстой. Манай байгууллагын албан хаагчид энэ сургалтанд бүрэн хамрагдаж тамхины хор уршиг, тамхинаас татгалзах дадал зуршлын талаар өргөн мэдлэгтэй болсон. Би байгууллагынхаа хэмжээнд тамхинаас татгалзах 2 сарын аяныг зохион байгуулж байгаа. Үр дүнтэй төслийг санаачлан хэрэгжүүлсэн бүх хүмүүстээ талархлаа.



3. “ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАТАЙ БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ХАНБОГД СУМЫН ИРГЭН Д.ГАНЧИМЭГ
24,702,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд суманд сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, төвлөрөл нэмэгдсээр байна. Одоогийн байдлаар тус суманд 8700 гаруй иргэн албан ёсны бүртгэлтэй байна. Бидний судалгаагаар сумын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай бага насны 20 хүүхэд байгаа бөгөөд энэ нь тус сумын 0-18 настай хүүхдийн 1,5 хувийг эзэлж байгаа юм. Энэ үзүүлэлт нь тусгай хэрэгцээт боловсролын талаар багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, холбогдох төрийн ажилтнуудад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, энэ хүүхдүүдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах орчин нөхцөлийг нь сайжруулж тэдэнд эцэг, эх, багш, төрийн зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Ханбогд сумын Ерөнхий боловсролын 2 сургууль, 3 цэцэрлэг тус бүрт тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн сургалтын булан байгуулж, тоглоом хэрэгслээр хангах, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн судалгаанд үндэслэн тэдний эцэг, эх, багш болон төрийн байгууллагын холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулах ажлууд хийгдсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Эцэг, эх, багш, төрийн байгууллагын холбогдох ажилтнуудын тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдүүдэд үзүүлэх тусламж, дэмжлэг, үйлчилгээний талаарх онол, арга зүйн мэдлэг сайжирсан.
- ✓ Тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах нөхцөл боломж бүрдсэн.
- ✓ Сумын 2 сургууль, 3 цэцэрлэг тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд зориулсан тоглоом хэрэгслээр хангагдсан.



Ханбогд сумын 2-р сургуулийн бага боловсролын сургалтын менежер О.Түвшинзаяа:

Манай суманд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай бага насны 20 гаруй хүүхэд байна. Бидний хувьд тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн сэтгэл зүй, тэднийг хөгжүүлэх арга зүйн онцлогт тохируулан ажиллах мэдлэг, туршлага маш дутмаг байсан. “Тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй” төслийн сургалтаар сумын сургууль, цэцэрлэгийн багш нар, төрийн албан хаагч, эцэг эхчүүдэд дээрх чиглэлээр богино хугацаанд онол, дадлагын мэдлэг мэдээллийг олгосон. Энэ арга хэмжээ нь тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйн ойлголтын талаар олон нийтэд чиглэсэн чухал алхам боллоо гэж бодож баяртай байна.



▶ 4. “УХААЛАГ ХУДАГ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
“ХАНДИЗЕЛЬ” ОНӨААТҮГ
22,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын хүн ам жил ирэх тутам өссөөр байгаа. Үүнтэй холбоотой улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр тус суманд цэвэр бохир усны төвлөрсөн системийг бий болгож шугам сүлжээний өргөтгөлийг шат дараатай хэрэгжүүлж ирсэн. Одоогоор сумын төвийн ундны усны хэрэгцээг хангаж байгаа дөрвөн ус түгээх цэг байдаг бөгөөд үүний зөвхөн нэг худагт ухаалаг систем суурилуулсан байдаг. Энэ нь өглөө эрт гэрээс гарч ажилдаа яваад оройтож ирдэг олон иргэдэд хэрэглээний усаа авах боломж гардаггүйгээс гадна ус хангамжийн үйлчилгээг хариуцсан байгууллагын хувьд үйлчилгээний хүртээмжээ дээшлүүлж зардлаа бууруулахад ухаалаг худгийн системийг сонгох нь чухал шаардлагатай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Ханбогд сумын төвд нэг ус түгээх байр шинээр барьж хоёр ус түгээх байранд ухаалаг худгийн систем суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Ханбогд суманд 24 цагаар ажиллах 2 ухаалаг худагтай болж иргэд хүссэн үедээ усаа авах боломжтой болсон.
- ✓ Худгийн гадна орчныг хяналтын камераар хянах боломжтой болсон.
- ✓ Бэлэн төлбөр тооцоо хийгдэхгүй болсон нь борлуулалтыг хянахад хялбар болсноос гадна халдварт өвчин тархахаас сэргийлэх, эрүүл ахуйн шаардлагад илүү нийцсэн.
- ✓ Усны картаар үйлчлүүлэгчдийн бүртгэл, мэдээллийн сантай болно.
- ✓ Ундны усан хангамжийн хүртээмж сайжирна.
- ✓ Ашиглалт хариуцсан байгууллагын ажлын ачааллыг хөнгөвчилсөн.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

5. “ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗА ГЭЖ ХЭЛЬЕ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
“ГАЛБЫН ГОВИЙН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ТББ
12,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

2019-2020 оны хичээлийн жилтэй зэрэгцэн дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахал өвчин дэгдэж, улмаар уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хорио цээрийн дэглэм болон эцэг, эхийн тусламж, дэмжлэгийн дутагдлаас шалтгаалж уншиж, бичиж сураагүй хоёрдугаар ангидаа дэвшин орж байгаа 80 гаруй хүүхэд Ханбогд суманд байна. Эдгээр хүүхдүүд цагаан толгойн үсгээ үзэж дуусаагүй, унших эвээ олж амжилгүй хөл хорионд орсон тул нэн тэргүүнд тэдний хоцрогдлыг арилгаж хоёрдугаар ангийн хичээлд нь бэлтгэх шаардлага тулгарсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулснаар Covid-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж сурагчдад танхимын хичээл бага орсонтой холбоотой уншиж, бичиж, бодож сураагүй 1-2 дугаар ангийн сурагчдын хоцрогдлыг арилгах юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

“Галбын говийн гэрэлт ирээдүй” ТББ-ын судалгаагаар Ханбогд сумын, эцэг эх нь уурхайн сайтад ажилладаг, ганц бие эцэг, эхээр өрх толгойлуулсан, амжиргааны түвшин доогуур, дөрвөөс дээш хүүхэд нь сургуульд сурдаг гэр бүлийн 1-2 дугаар ангийн 80 хүүхдийг бүртгэж гурван сарын хугацаанд уншиж, бичиж, бодож сургах сургалтанд хамруулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ 1-2 дугаар ангийн 80 сурагчдын хоцрогдлыг богино хугацаанд арилгаж 2 дугаар ангид суралцах стандарт түвшинд нь хүргэсэн.
- ✓ Сургалтанд хамрагдсан сурагчид цаашид өөртөө итгэлтэйгээр сурч, хөгжих чадвартай болсон.
- ✓ Сургалтыг 3 сарын хугацаанд үнэ төлбөргүй явуулж хөтөлбөрт хамрагдсан 80 өрхийн санхүүд дэмжлэг болсон.



Ханбогд сумын Баян багийн иргэн Ё.Гантогтох:



Ковид-19 цар тахлаас шалтгаалсан хөл хорионы үед дөнгөж сургуульд орсон бяцхан үрсүүдэд маань сургуулийнхаа орчинд уншиж, бичиж сурах цаг хугацаа боломж гарахгүй байсаар байна. Ийм хүнд үед "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр хэрэгжсэн "Хүүхдийн төлөө за гэж хэлцгээе" хөтөлбөрөөр нэгдүгээр ангийн сурагчдын хичээлийн хоцрогдол арилгах сургалт зохион байгуулсан. Миний хүү, охин хоёр ихэр маань энэ сургалтанд хамрагдаж одоо уншиж бичиж сурсанд баяртай байна. Хэрэгцээ, шаардлага өндөртэй, цагаа

олсон төслийг санаачлан хэрэгжүүлсэн Одгэрэл багшдаа болон төслийг санхүүжүүлсэн "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-д талархал илэрхийлье.

6. “ТҮҮХЭН ЗАМНАЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ХАНБОГД СУМЫН ИРГЭН Б.ТӨМӨРБААТАР
20,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын нэг дүгээр сургууль нь 1940 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд тус сургуулийн 80 жилийн түүхэн ой 2020 онд тохиосон. Өнгөрсөн хугацаанд эрдэмтэн багш нарын эрдэм мэдлэг, төгсөгчдийн сурлага, урлаг, спортын амжилт, гавьяа зэрэг олон олон бахархуулах, сонирхуулах дурсамж, дуртгал арвин түүхтэй сургууль болсон байна. Дээрх сайн сайхан бүхнийг баримтжуулан багш, сурагчдад үр өгөөжтэйгээр сургалтын орчинг тохижуулахаар төслийг санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сурагчдад сургуулийнх нь талаар өргөн мэдлэг олгох, сайн сайхныг үлгэрлэн дагаж ёс суртахуун, хүнлэг энэрэнгүй, зөв хандлага, сэтгэлгээтэй иргэн болж төлөвшихөд нь дэмжлэг болох, сургуулийн өнгө үзэмжийг сайжруулж бусад сургуулиудад үлгэр дуурайл болгох, багш, ажилчдын ажиллах таатай орчинг бүрдүүлэх.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Ханбогд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн нэг өрөөг сургууль анх үүсэн байгуулагдсанаас хойших холбогдолтой түүхэн үйл явдлын сэдвээр баяжуулан тохижуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөтөлбөрийн үр дүнд Ханбогд сумын нэг дүгээр сургуульд сургууль анх үүсгэн байгуулагдсанаас хойших өнөөг хүртэлх түүхэн үйл явдлыг харуулсан танхимтай болсон.
- ✓ Сурагчдад сургуулийнхаа ахмад, дунд, залуу хойч үеийн шилдэг төгсөгчдөөрөө бахархан даган дуурайх, хөгжих, суралцах эерэг орчинг бүрдүүлж өгсөн.
- ✓ Цаашид сургуулийн түүхэн баримт, дурсамжийг баяжуулан хөгжүүлж ирээдүй хойч үедээ үлдээх суурь тавигдсан.



Ханбогд сумын Б.Чогдовын нэрэмжит 1-р сургуулийн газарзүй, биологийн багш Г.Энхмөрөн:

Манай сургуулийн байгуулагдсан цагаас хойш өдийг хүртэлх бүх түүхийг дурсамж болгон хадгалсан сургуулийн түүхийн музейтэй боллоо. Миний хувьд өөр орон нутгаас ирж 2 дахь жилдээ ажиллаж байна. Өөрийн ажлын гараагаа эхэлсэн энэ сургуулийнхаа түүхтэй танилцаж дурсамж болгоноор нь аялсан юм шиг мэдрэмж төрлөө. Мөн өдийг хүртэл үзмэрүүдийг хадгалж байсан багш нар, сургуулийн үе үеийн удирдлагуудаараа бахархах сэтгэл төрлөө. “Түүхээ мэдэхгүй хүн ойд төөрсөн сармагчин лугаа адил” гэдэг, ирээдүй хойч үеийнхэндээ энэхүү танхимыг тохижуулж өгсөнд талархлаа.



7. “ЧАВХДАСТ ХӨГЖМӨӨ ТОГЛОЁ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:
ГОХДС-С САНХҮҮЖҮҮЛСЭН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ХАНБОГД СУМЫН ИРГЭН О.ТӨРБОЛД
12,615,000 ТӨГРӨГ
6,470,000

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сум нь уул уурхай дагасан хүн амын төвлөрөл ихтэй онцлог сум учир үүнийгээ дагаад иргэдийн боловсрол, хөгжилд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах эрэлт хэрэгцээ ихтэй байдаг. Сумын хүүхэд залууст чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөгжүүлэх олон нийтийн газар ховорхон байдгаас хүүхэд залуус цахим хэрэглээнд хэт автаж байна. Мөн Ханбогд сум 2020 оныг Өрх гэр бүлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хөтөлбөрийг санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хөгжим сонирхдог иргэд, хүүхдүүдийн хөгжмийн боловсролд дэмжлэг болох, тэдэнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх өөрийгөө илэрхийлэх, баг хамт олонтой болж төлөвшихөд нь дэмжлэг болох

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

“Хандизель” ОНААТҮГ-ийн нэг өрөөг тохижуулан 10 ширээ, сандал, морин хуур /4 ширхэг/, товшуур хөгжим /3 ширхэг/, гитар /4 ширхэг/, Үкүлэлэ /4 ширхэг/, бөмбөр /2 ширхэг/ хөгжмүүдийг нийлүүлсэн. Хөгжим сонирхдог 350 иргэд, сурагчдыг хамруулан 6 сарын хугацаанд 7 хоногт 6-8 цагийн хөгжмийн сургалт зохион байгуулан ажиллаж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Ханбогд сумын “Хандизель” ОНӨААТҮГ хөгжмийн сургалтын танхимтай болсон.
- ✓ Хүүхэд залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх төвтэй болсон.
- ✓ Иргэдийн хөгжмийн боловсролд дэмжлэг болсон.
- ✓ Хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа 2 ажлын байр бий болно.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ 8. “ХАНБОГД ХАЙРХАН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ХАНБОГД СУМЫН ИРГЭН М.ЧҮЛТЭМСҮРЭН

15,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монголын үндэсний соёлын үнэт өв болох зээгт наамлын урлал нь Хүннү гүрний үед үүссэн тухай судалгаагаар тогтоогдсон байдаг. Зээгт наамал буюу торгон зураг нь монголчуудын урлахуйн өвөрмөц сэтгэмж, гарын нарийн ур, сэтгэлгээний давтагдашгүй байдлыг илтгэсэн ховор содон урлагийн төрөл юм. Энэхүү гайхамшигт урлалыг урлаач цөөн болсон өнөө үед Өмнөговь аймаг маань Монгол үндэсний уран хатгамал “Зээгт наамал” урлалыг соёлын нэрийн бүтээгдэхүүнээ болгон, Монгол улсын уран хатгамалч, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт А.Цэрэнхүү агсны нэрэмжит “Алтан утас” зээгт наамлын бүтээлийн үзэсгэлэнг 2015 онд Улаанбаатар хотод зохион байгуулж байсан билээ. Энэхүү соёлын өвийг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх, түүх соёлоо эрхэмлэн дээдлэх, хайрлан хүндэтгэх цаашид хөгжүүлэх зорилгоор хөтөлбөрийг санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн зорилго нь иргэдэд үндэсний түүх соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, уул усаа хүндлэн дээдлэх бахархлыг нэмэгдүүлэх, уламжлуулан үлдээх зэрэг эерэг нөлөөллүүд бий болгох юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

“Ханбогд хайрхан уулын эзэн” зээгт наамал бүтээл урлаж “Үлэмжийн чанар” соёлын төвд байрлуулна.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ “Ханбогд хайрхан уулын эзэн” зээгт наамал бүтээлийг “Үлэмжийн чанар” соёлын төвд хүндэтгэлтэйгээр байрлуулна.
- ✓ Иргэдэд үндэсний түүх соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, уул усаа хүндлэн дээдлэх бахархлыг нэмэгдүүлэх, уламжлуулан үлдээх эерэг нөлөөллүүд бий болно.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

9. “ЭЛБЭГ ЧАЦАРГАНА” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ХАНБОГД СУМЫН ИРГЭН Ц.МӨНХЧУЛУУ
17,335,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүний эрүүл мэндэд нэн тустай, хүч тамирын эх ундарга болсон чацаргана жимсний ач тус хэмжээлшгүй их. Чацаргана жимс нь найрлагадаа олон төрлийн витамин, амин хүчил, уураг тос, хүний биед зайлшгүй хэрэгтэй, микро элементүүд агуулдаг онцлогтой. Ханбогд сумын хэсэг ахмад сумандаа чацаргана жимс тариалж сумын иргэдийнхээ эрүүл мэндэд ач тус хүргэх зорилгоор төслийг санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумандаа чацаргана жимс тариалдаг болж иргэдийн эрүүл мэндэд өндөр ач тустай цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүнээр сургууль, цэцэрлэг, сумын хэрэглэгчдийг хангах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Ханбогд сумын ахмадын хорооны хашаанд 200 ш чацарганы мод тарина.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Ханбогд сумын ахмадын хороо чацарганын төгөлтэй болж тэтгэвэртээ гарсан ахмадууд ажлын байртай болох, сумын 3 цэцэрлэг, 2 сургуулийг чацаргана жимсээр хангах боломж бүрдэнэ.

▶ 10. “МЯНГАН МОД” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ХАНБОГД СУМЫН ИРГЭН А.ЦЭЦЭГ
18,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын Баян багийн нутаг Өрөлбөд хур бороо орох нь багасч, тэмээ голчлон бэлчээрлэдэг нутаг тул одоо байгаа гар худаг мал услахад хурдан шавхагддаг болсон. Мөн тус нутгийн малчин иргэн А.Цэцэг 2014 оноос эхлэн хайлаас, сухай, заг тариалж одоогоор 580 модтой болсон бөгөөд цаашид модны ургалтыг сайжруулах, хамгаалах, тоог нь нэмэгдүүлэхэд гүний худаг, усалгааны систем шаардлагатай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Цөлжилтийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, модны ургалтыг сайжруулах, тоо ширхэгийг нэмэгдүүлэх, хур, борооны ус татах, хүн, малын ундны усны чанар, нөөцийг сайжруулах.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Ханбогд сумын Баян багийн нутаг Өрөлбөд гүн өрмийн худаг гаргаж усалгааны систем суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөтөлбөрийн үр дүнд цөлжилтийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, модны ургалт сайжирч, тоо ширхэг нь нэмэгдэх, хур, борооны ус татах, хүн, малын ундны усны чанар, нөөц сайжрах зэрэг эерэг үр дүнгүүд бий болсон.

11. “ЭРҮҮЛ ХҮНС ХАДГАЛАЛТ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ХАНБОГД СУМЫН ИРГЭН Ч.МӨНХБАЗАР
27,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын иргэд, хоршоо, нөхөрлөлүүд 2015 оноос хүнсний ногоогоо тариалж “Оюу толгой” компанийн хүнсний ногооны багахан хувийг хангаж байна. 2020 оноос өвлийн хүлэмжтэй болж байнгын тариалалт хийж эхэлж байгаа. Сумын тариаланчид ногоогоо хадгалах хөргүүргүй учир эрүүл ахуйн шаардлага хангасан ногоогоор хэрэглэгчдийг хангах, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулахад байнга бэрхшээл хүндрэл гардаг.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын хэрэглэгч, уул уурхайн компаниудад эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний ногоогоор хангах, иргэд өрхийн орлогыг нэмэгдүүлэх.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Ханбогд сумын ЗДТГ-т 40 тн-ын багтаамжтай хүнсний ногоо хадгалах зориулалтаар тохижуулсан хөргүүртэй агуулах нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Ханбогд сумын хүнсний ногоо тариалагч иргэд, хоршоод хөргүүртэй агуулахтай болж сумын хэрэглэгч, уул уурхайн компаниудыг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний ногоогоор хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх нөхцөл боломж сайжирсан.

2020 ОНД МАНЛАЙ СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

1. “ШИНЭ САНАА, ШИНЭ ОРЧИН, ШИНЭ САНААЧИЛГА” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
МАНЛАЙ СУМЫН ЕБС-ИЙН БАГШ Т.ЭНХТУУЛ
32,350,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын ерөнхий боловсролын сургууль нь 12 жилийн тогтолцоонд шилжиж байгаатай холбогдон бага сургууль шинээр байгуулагдах болсон тул анги танхимуудаа тохижуулах, багш хөгжлийн төвийг шинээр байгуулж байна. Манлай сумын шинээр байгуулагдаж буй бага сургуульд 10 багш ажиллаж, бага ангийн 6-12 насны 243 хүүхэд суралцах бөгөөд багш нарын ажиллах, хөгжих, багш багшаасаа суралцах, багаар хамтран ажиллах эрүүл таатай орчин бүрдүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа юм.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- ✓ Суралцагчдын сурах, багш нарын ажиллах таатай орчин бүрдүүлэх.
- ✓ Суралцагчдын сурлагын чанарт ахиц гаргана.
- ✓ Багш нарын ажлын бүтээмж сайжирна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Манлай сумын бага сургуулийн 10 анги танхимд шаардлагатай байгаа сандал, ширээ, шүүгээ, самбар, LCD дэлгэц, багшийн шүүгээ, хөшиг зэрэг 6 нэр төрлийн 78 ширхэг тоног төхөөрөмж, хэрэглэлийг хүлээлгэн өгч суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Бага ангийн 10 ангийг тохижуулж, сургалтын кабинет болгож, сургалтын үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдүүлсэн.
- ✓ Суралцагчдын сурлагад эерэг нөлөө үзүүлж байгаа.
- ✓ Танхимд шаардлагатай тавилга хэрэгсэлтэй болсноор сургалт явуулахад хялбар болсон.



**Манлай сумын дунд сургуулийн бага ангийн багш
Чулуунбаатар овогтой Ачмаа:**

Энэ хичээлийн жилд манай сургуулийн бага ангийн 9 бүлгийг "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн төслийн санхүүжилтээр 6 нэр төрлийн эд зүйлээр тохижуулсан. Багш бидний ажиллах, сурагчдын сурах орчин сайжруулж өгч байгаа нь том хөрөнгө оруулалт болж байна. Төсвийн байгууллагын бид нэг доор ийм их хөрөнгө, мөнгөний асуудал шийдэх боломжгүй. Тиймээс энэ сангийн төслийн үйл ажиллагаа нь зөвхөн энэ төсөл ч биш сум орон нутгийн хэмжээнд үр өгөөжөө өгсөөр ирсэн ажил юм. Сургалтын үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдүүлж хөрөнгө оруулалт шийдэж өгсөн "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийнхандаа сургуулийнхаа багш, сурагчдынхаа өмнөөс талархал илэрхийлье.

Ба ангийн сурагч Чингэс овогтой Энэрэл:

Манай анги болон бүх бага ангиуд самбар, LCD дэлгэц, хөшигтэй болсон бас багш нар маань гоё шкаф, ширээ сандалтай болсон. Бидний энэ гоё юмнуудтай болоход "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн төслийн ах, эгч нар тусалж өгсөн. Надад хамгийн их таалагдсан зүйл LCD дэлгэц. Яагаад гэвэл бид цаасаар хийсэн үзүүлэн үздэг байсан бол одоо дэлгэцээр үзүүлэхэд сонирхолтой, тэгээд бас дуу, хөдөлгөөнтэй зураг үзэх таалагдсан. Ангийг минь гоё болгож өгсөн ах, эгч нарт баярлалаа.



2. “БИЕЙН ТАМИРЫН ГАДАА ТАЛБАЙ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
МАНЛАЙ СУМЫН ЕБС-ИЙН БАГШ Ж.БУРМАА
56,711,500 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумаас төрөн гарсан алдар цолтой бөхчүүд, гар бөмбөгийн мастерууд, хөнгөн атлетийн тамирчид, уулын дугуйны мастерууд гээд олон алдартнууд бий. Тус сумын спортын амжилт нь үе үеийн биеийн тамирын багш нартай холбоотой гэж үздэгээс гадна хөнгөн атлетийн талбайтай, тэр талбайгаа түшиглэсэн олон тооны уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулдаг байсантай холбоотой гэж дүгнэдэг. Иймд тэрхүү уламжлалыг сэргээж спортын талбайтай болох хэрэгцээтэй байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хүүхэд залуучууд болон сумын ард иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажиллах эрч хүч нэмэгдүүлэх, спортоор тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж өгөхөд оршино.

Мөн биеийн тамирын гадаа талбай байгуулагдсанаар спорт сонирхогчдын тоо нэмэгдэж, өөрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөртөө анхаарч жингээ хянах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, ажиллах бүтээмжээ сайжруулах зэрэгт анхаарлаа хандуулах хүний тоо нэмэгдэнэ. Тэсвэр тэвчээрийг нэмэгдүүлж, нээлттэй тэмцээн уралдаануудыг зохион байгуулах бүрэн боломжтой болно.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Манлай сумын төвөөс баруун хойд зүгт 300м орших Хадтай толгой хэмээх газар 300м хөнгөн атлетийн гүйлтийн зам, хөл бөмбөг, гар бөмбөг, 3х3 багийн тоглолтын сагсан бөмбөгийн талбай, бөөрөнцөг шидэлтийн талбай, тэмээн шат, уртын харайлтын талбай, турник, гимнастикийн шат болон ширээ, сандал суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөнгөн атлетикаар хичээллэж буй тамирчид болон иргэд дасгал сургуулилтаа хийх, амжилтаа ахиулах бололцоо бүрдсэн.
- ✓ Иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл мэнддээ анхаарч өдөр бүр дасгал хийх суурь бааз, боломж бүрдсэн.
- ✓ Спорт сонирхогчдын тоо өссөн.

3. “ЗАН ҮЙЛИЙН ӨРГӨӨ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 4,640,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

МАНЛАЙ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ Э.МӨНХСОЁЛ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын 15 дугаар цэцэрлэг нь 2019 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр барьсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулан нийт 200 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаар сумын төвийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна. Сургуулийн өмнөх боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс заншлаа өвлүүлэх, дээдлэх түүнд суралцах үйл ажиллагаанууд өргөн цар хүрээтэйгээр тусгагддаг. Тиймээс тухайн хичээлийг практик хэрэглээн дээр тулгуурлан заах нь хүүхдэд илүү хүртээмжтэй байдаг тул шинээр зан үйлийн буланг цэцэрлэгтээ байгуулах юм.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Ёс заншлаа дээдэлж, түүнийгээ амьдрал ахуйдаа хэвшил болгон мөрдүүлэхэд сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагаагаар төлөвшүүлэхэд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүнийг цэцэрлэгийн анги танхимд байрлуулж, хүүхдүүдэд бодит үзүүлэн дээр зааж сургана.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Манлай сумын цэцэрлэгт Монголын үндэсний ёс заншил, уламжлалт зан үйлийг заахад ашиглах иж бүрэн тавилгатай 3 ханатай гэр, Монголчуудын өдөр тутамдаа ашигладаг эд хэрэгсэл, таван хошуу малын чихмэл зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг нийлүүлэн хүлээлгэн өгсөн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүний баазтай болсон
- ✓ Хүүхэд багачууд Монгол ёс заншил, ахуйгаа дээдлэхэд суралцаж байна.



15-р цэцэрлэгийн бүлгийн багш М.Дариймаа:



Манай цэцэрлэг нь 2020 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн төслөөр ёс заншлын өргөөтэй болсонд багш нар бид туйлын баяртай байна. Энэхүү өргөөнд бидний хойч үе Монголын ирээдүй маань сурч хөгжинө гэдэгт багш би бат итгэлтэй байгаа. Одоо Монголчууд бид зан үйлээсээ суралцах нь маш хомс болоод байгаа. Өмнө нь хийсвэрээр л хүүхдүүддээ зааж сургах гэж хичээдэг мөн багш нар хамтран гарын доорх болон хаягдал материал ашиглан зан үйлийн булан байгуулж сургалтаа явуулдаг байсан ч үр дүн төдийлэн сайн байгаагүй. Зан үйлийн өргөөтэй болсноор бодит зүйл дээр багш нар бид гэрт орж сууж байгаад сургалтаа явуулах, тайлбарлах нь амьдралд ойр болж сургалт үйл ажиллагаа маань сонирхолтой явагдаж байгаа. Хүүхдүүд маань юм юм асуугаад л жинхэнэ танин мэдэхүйн сэтгэхүй нь хөгжиж байгаа мэт санагдаж Монголоороо бахархах сэтгэл төрж байна. Одоо манай суманд төдийгүй Монгол улсад гэрт ч орж үзээгүй хүүхэд олон болсон

байгаа учраас энэ зан үйлийн өргөө маш хэрэгтэй юм. Иймээс улам их баяжуулж сургалт үйл ажиллагаагаа явуулах нь чухал гэж бодож байна

4. “ЭМНЭЛГИЙН АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
МАНЛАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭМЧ Д.ОЮУНЧУЛУУ
8,995,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Эрүүл мэндийн төв нь 2019 онд 57 удаа, 2020 оны эхний сарын байдлаар 19 удаа багаж хэрэгслийн ариутгалыг уурын автоклаваар хийсэн байна. Ингэхдээ 2 төрлийн индикатор буюу ариутгалын чанар шалгах тууз, уурын тархалт шалгах индикатор ашиглаж байна. Одоогоор эмнэлгийн тусламж үйлчилгээнээс шалтгаалсан халдвар гараагүй байгаа боловч халдвар гарах өндөр эрсдэлтэй байгааг 2020 оны 5 сард ЭМЯ, НҮБ-ын хүн амын сангийн шинжээч нарын хийсэн хяналт үнэлгээгээр илрүүлж эрсдэлийг арилгах талаар зөвлөмж өгсөн билээ. Түүний дагуу эмнэлгийн ариутгалын хэсгийн урсгалыг зөв болгох, багаж хэрэгслийн угаалга халдваргүйжүүлэлтийг сайжруулах, ариутгалын чанарт шалгах индикаторын төрлийг нэмэгдүүлэх, эмнэлгийн ажилтнууд өөрсдөө халдвар авах эрсдэлээс сэргийлэх, стандартын дагуу багаж хэрэгслийн ариутгал халдваргүйтгэлийг зохион байгуулах юм.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгчдийн гэмтсэн болон гэмтээгүй арьс салст, зөөлөн эд, яс, биеийн хөндийд нэвтэрдэг дахин хэрэглэгддэг багаж хэрэгслийг холбогдох заавар журмын дагуу халдваргүйжүүлэн ариутгаж багаж хэрэгслээр дамжин халдвар тархах эрсдэлийг арилгах, эрүүл аюулгүй орчинд тусламж үйлчилгээ үзүүлэх зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Манлай сумын эрүүл мэндийн төвд дахин хэрэглэгддэг багаж хэрэгслийг ариутгаж халдваргүйжүүлэх зөөврийн дизкамер, ус нэрэгч, бохирын даавуун тэргэнцэр, хэт ягаан туяаны ламп, цэвэрлэгээний тэргэнцэр, хийн компрессор, гурван дамжлагатай тосгуурыг нийлүүлж суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Эрүүл мэндийн төвийн ариутгалын хэсэгт хийгдэх ариутгал, халдваргүйжүүлэлт сайжирсан.
- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс шалтгаалсан халдвар гарахгүй.
- ✓ Эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлж байна.
- ✓ Үйлчлүүлэгчдийн халдваргүй, эрсдэлгүй орчинд үйлчлүүлэх хэрэгцээ хангагдаж байна.



Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Уламбаяр:

Тус эмнэлэгт Ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж авах төсөл хэрэгжсэнээр багажнуудыг ариутгахаас гадна хэвтэн эмчлүүлэгчдийн гудас хөнжлийг дизкамер нэртэй орчин үеийн тоног төхөөрөмжөөр ариутгал халдваргүйтгэл хийж халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Энэхүү төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшил гарсан.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

5. “ДУЛААН БАЙР - ТУХТАЙ ОРЧИН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

МАНЛАЙ СУМЫН ИРГЭН Н.ПУНЦАГБОЛД

22,504,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын “Манлайн бадрах” ОНӨААТҮГазар нь төсөвт 5 байгууллага, 94 өрх, 16 аж ахуй нэгжийг халаалтын хугацаанд дулаанаар хангаж ажилладаг. Дулаанаар хангагддаг айл өрх, аж ахуй нэгж нь дулааны эх үүсвэрээс 2-2.5 км зайтай байдгаас үйлдвэрлэж буй дулаан хэрэглэгчдэд жигд хүрдэггүй. 2020 онд Манлай суманд хуучин сургуулийг засварлаж ашиглалтанд оруулах, 14 айлын орон сууц баригдах, Эрүүл мэндийн төв шинээр баригдаж буй зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэнээр дулааны эх үүсвэрээс хол байгаа айл өрх, аж ахуй нэгжүүдийн халаалт доголдолтой очих, үйлдвэрлэж байгаа дулаан жигд хүрэхгүй байх нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. Иймээс дулааны эх үүсвэрт ойр байрлах төсөвт албан байгууллагад ялтсан бойлуурыг суурилуулснаар захын хэрэглэгчдэд очих халаалт сайжирна. Энэ арга нь өмнө нь өөр суманд туршигдан хэрэгжсэн юм.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Дулаан хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагууд, айл өрхүүдийн халаалт жигд очих нөхцөлийг бүрдүүлэх, халаалтыг хэрэгчлэгчдэд ижил температуртай хүргэх, захын хэрэглэгчдийг чанартай дулаанаар хангах зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Манлай сумын төсөвт байгууллагууд болох ерөнхий боловсролын сургууль, тус сургуулийн дотуур байр, цэцэрлэг, соёлын төв гэсэн 4 байгууллагад 300-600 ваттын хүчин чадал бүхий ялтсан бойлуур суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Албан байгууллага, айл өрхүүд нэгэн жигд хэмээр дулаан хангамж, халаалтыг авч эхэлсэн.
- ✓ Дулааны алдагдал багасч үр ашиггүй зардал буурсан.
- ✓ Иргэд, айл өрхүүд дулаан тухай орчинд амьдрах боломж бүрдсэн.
- ✓ Халаалтын хэмжээ жигд болсноор сумын төвд айл өрхүүд гал түлэхгүй болж сумын төвийн агаарын бохирдол буурахад эерэг нөлөө үзүүлсэн.



Ерөнхий боловсролын сургуулийн сантехникч – Б.Баянмөнх:



“Дулаан байр тухтай орчин” нэртэй төсөвт байгууллагуудад ялтсан бойлуур суурилуулсан хөтөлбөр хэрэгжсэнээр тухайн байгууллагын паарны ус даралтаа аваад явсан байхад даралт дулааныг тогтвортой хадгалдаг болсноос гадна уурын зууханд асуудал үүсч галлагаа зогссон засвартай тохиолдолд 24 цагт хүйтэн усаа эргүүлж хөлдөөхгүй барьдаг болсон. Мөн гэр хорооллын айлуудад халаалт даралт ихтэй жигд явдаг болсон зэрэг маш олон давуу талуудтай бөгөөд үнэхээр үр дүнтэй төсөл хэрэгжсэн.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

5. “ЦЭВЭР ОРЧИН ЦЭМЦГЭР БАЙГУУЛЛАГА” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
МАНЛАЙ СУМЫН ИРГЭН М.МӨНХ-ОД
9,604,500 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манай суманд төвлөрсөн хогийн цэгтэй болоод нэлээдгүй хугацаа өнгөрч байгаа ч иргэд, албан газрууд хогоо ангилан ялгах соёлд суралцахгүй байгаа нь хогийг ангилах зориулалтын сав байдаггүйтэй холбоотой. Энэ байдлын улмаас хог бутарч салхинд хийсч хөрс, байгаль орчныг бохирдуулан иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, сумын өнгө үзэмжийг муутгах зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөн дахин ашиглах боломжтой хог хаягдлын төвлөрүүлэх, эмнэлэг болон банкны бичиг баримт зэрэг нууцлалын зэрэглэлтэй хог хаягдлыг шатаах, тариур зэрэг аюултай хог хаягдлыг булшлах, ахуйн хог хаягдлыг хийсч бутрахаас сэргийлсэн зориулалтын саванд төвлөрүүлэх зэрэг орчин цагийн төвлөрсөн суурин газрын хог хаягдлыг зохистой ашиглах, зөөвөрлөх, хадгалах зэрэг технологийг нэвтрүүлж, иргэдэд соёлтой хэрэглээний боловсролыг эзэмшүүлэх нэн шаардлагатай болсон нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл болсон.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Манлай сумын төвийн 6 байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг хүргэдэг ба эдгээр байгууллагад хог төвлөрүүлэх, ангилан ялгах зориулалтын сав байдаггүй. Хөтөлбөр хэрэгжсэнээр төрийн байгууллагуудын гадна орчин сайжирч, өнгө үзэмж нэмэгдэнэ. Мөн иргэд ажилчид цэвэр орчинд тав тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хог хаягдлаа байгальд хоргүйгээр устгах боломжтой болно.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Манлай сумын Засаг даргын тамгын газар, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, соёлын төв, “Манлайн бадрах” ОНӨААТҮГ гэсэн 6 байгууллагын гадна 80смХ80смХ120см хэмжээтэй шатаах зуух, 2мХ1мХ1.2м хэмжээтэй 2 төрлийн хог хаях зориулалт бүхий хогийн савыг хийж байрлуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хувь хүмүүс хог хаягдлаа ангилах соёлд суралцахад үлгэр дуурайл болно.
- ✓ Хувийн аж ахуй нэгжүүд үлгэр жишээ авч өөрийн байгууллагад тус туршлагыг нэвтрүүлэх боломжтой.
- ✓ Явуулын хүмүүс зорчиход цэвэр цэмцгэр орчин хүлээн авна.
- ✓ Сумын тохижилт, өнгө үзэмжид эерэгээр нөлөөлсөн.
- ✓ Иргэдийн амьдрах орчин сайжирсан.

ЗДТГ-ын ажилтан Ж.Батсүрэн:

Цэвэр орчин цэмцгэр байгууллага нэртэй төсөвт байгууллагад ангилан ялгах хогийн сав, шатаах зуух хийснээр бидний хогийн пошигонд бүх хогоо холиод хийдэг байсныг хөнгөвчилж хогоо ангилан ялгах орчин нөхцөл бүрдсэн. Мөн зориулалтын зуухандаа цаасаа хийгээд шатаахад маш хялбар бөгөөд сайн шатдаг давуу талтай. Бидний ажлыг дэмжсэн төсөл санаачлагч болон санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олонд талархал илэрхийлье.



2020 ОНД БАЯН-ОВОО СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

1. “АМЖИЛТ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
“НЭМЭХТ СУУРЬ” ХХК
41,700,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сумын Б.Доржийн нэрэмжит 9 жилийн сургуульд 31 багш ажилчид ажиллаж, 235 хүүхэд суралцдаг. Багш сурагчдыг хөгжүүлэх сургалт, олимпиад уралдаан тэмцээнд оролцуулах, бусад сургуулиудын багш, сурагчдын туршлага судлах, тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргэх боломж бүрдүүлэх, цаг хугацаа алдалгүй, найдвартай тээврийн хэрэгслээр зорчуулах шаардлагатай байдаг. Баян-Овоо сумаас аймгийн төв рүү хувийн унаагаар зорчиж буй иргэдийн тээврийн хэрэгслээр зорчдог байсан нь замдаа саатах, тухайн хувь хүний товлосон ажил нь цуцлагдаж хот хооронд явахаа болих зэргээр сургалт, уралдаан тэмцээнд оролцохоор төлөвлөсөн ажилдаа хоцрох, оролцох ажлаа цуцлах зэргээр сургалт, хүмүүжлийн ажилд хүндрэл учирдаг.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- ✓ Багш, ажилтан, сурагчид хөгжих боломж бүрдэнэ.
- ✓ Сургуулийн удирдах ажилтнууд, багш ажилчид сургалт семинарт товлосон хугацаанд хамрагдах боломжтой болно.
- ✓ Сурагчид улс, аймаг, бүсийн тэмцээнд бүрэн бүрэлдэхүүнээр оролцох боломжтой болно.
- ✓ Автомашинд зорчих нормыг ханган найдвартай, тухтай зорчих боломжтой болно.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

10 хүний суудалтай УАЗ-Фургон маркийн автомашиныг Баян-Овоо сумын дунд сургуульд хүлээлгэн өгсөн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Сурагчдын амралтаар багш нараа сургалтанд хамруулах, ажлын байран дээр нь хэрэгцээтэй сургалтыг зохион байгуулах багшийг урьж авч ирэх боломжтой болсон
- ✓ Сургуулийн 31 багш ажилтан сургалт семинар зохион байгуулагдах бүрт замын унаа хайхгүйгээр байгууллагын машинаар явах боломжтой болсон.
- ✓ Сургуулийн 235 сурагчдыг олимпиад, уралдаан тэмцээн бүрт оролцуулах боломж бүрдсэн.
- ✓ Багш ажилтан, сурагчдыг өөр сургуулийн туршлагаас суралцуулах, өөрсдийн сургуулийн туршлагыг түгээнэ.
- ✓ Багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд байгууллагын машинаар аюулгүй зорчуулах боломжтой болсон.

Б.Доржийн нэрэмжит 9 жилийн сургуулийн багш Ч.Эрдэнэбаяр:



Сургуулийн сурагчдын хувьд жилдээ аймаг, хот гээд тэмцээн уралдаанд олон явдаг. Энэ хэмжээгээрээ бидэнд аюулгүй, найдвартай сайн унаа хэрэг болдог. Энэ жил сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр шинэ автомашинтай болсондоо баяртай байна.

Боловсролын байгууллагын албан хаагчид, ажилчид маань ч гэсэн тасралтгүй сурч, хөгжих шаардлагатай байдаг учраас бид бүхэн сурагчдын тэмцээн уралдаанд явахаас

гадна сургалт зөвлөгөөнд хамрагдахаар явах аюулгүй тээврийн хэрэгсэл, унааны хэрэгцээг хангасан маш чухал хөрөнгө оруулалт болсонд баяртай байна.

Боловсролын салбарт чухал хөрөнгө оруулалт хийсэн "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-д баярлалаа гэж нийт багш сурган хүмүүжүүлэгчид болон шавь нарынхаа өмнөөс талархаж байна.

▶ 2. “ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

“НЭМЭХТ СУУРЬ” ХХК

41,700,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сумын төвөөс Өмнөговь аймгийн төв рүү зориулалтын зохион байгуулалттай шуудангийн үйлчилгээ байхгүйгээс болж иргэд тогтсон унаагүй, албан байгууллага, аж ахуй нэгжийн хоорондын бичиг хэрэг, төр засгийн байгууллагаас гаргасан шийдвэр өгөгдсөн үүрэг даалгавар цаг хугацаандаа очихгүй биелэлт хэрэгжилт нь шуурхай мэдээлэгдэхгүй зэргээр байгууллага, хувь хүний ажил хүлээгдэн цалгардах, ач холбогдол нь алдагдах зэрэг эрсдэл гардаг.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Долоо хоногт 1-2 удаа тогтмол хугацаанд Баян-Овоо – Даланзадгад – Баян-Овоо чиглэлд зорчдог байнгын шуудангийн үйлчилгээг бий болгож иргэдийг найдвартай нийтийн тээврээр хангах зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

10 хүний суудалтай УАЗ-Фургон маркийн автомашиныг Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгсөн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Тогтсон цагийн хуваарийн дагуу тогтмол шуудан явснаар иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэнэ.
- ✓ Аюулгүй найдвартай, зориулалтын шуудангийн үйлчилгээг бий болгосон.

▶ 3. “ШИНЭ ТЕХНОЛОГИ, БАГШИЙН ХӨГЖИЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
“МОНГОЛ МЭРГЭД” ХХК
42,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын модуль нь хүүхдийн төрөлхийн бие бялдар, авьяас чадваруудыг хөгжүүлэх, нийгмийн харилцаанд оролцох, сургуульд суралцах суурийг тавьдаг. Аливаа тоглоом нь сургалтын журманд үндэслэгдэн хийгддэг бөгөөд хамгийн жижиг тоглоом хүртэл хүүхдийн аль нэг чадварыг хөгжүүлж байдаг. Сурган хүмүүжүүлэгчдэд хүүхдийн чадварыг нь хөгжүүлэхэд зориулагдсан тоглоомууд хангалттай байх шаардлагатай. Иймд цэцэрлэгийн хүүхдүүдийг тоглоомоор хангаж, сурч хүмүүжих таатай орчин бүрдүүлэх, хүүхдүүдийн тоглох тоглоом хүрэлцээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:


- ✓ Багш, сурган хүмүүжүүлэгчдийн сургалтын орчинг сайжруулах, материаллаг баазыг нэмэгдүүлэх,
- ✓ Цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл, аюулгүй орчинд нас насныхаа онцлогт тохирсон, оюун ухаан сэтгэхүйг хөгжүүлэх эко тоглоомоор хангах.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Баян-Овоо сумын 19 дүгээр цэцэрлэгт багш нарын сургалтын орчинг сайжруулах, сургалтын материал бэлтгэх, хүүхдүүдэд үзүүлэн, сургалтын материалыг харуулах зэрэгт хэрэглэх принтер, проекторын дэлгэц, таблет зэрэг хэрэгсэл, хүүхдүүдэд зориулсан тоглоом, гадна саравч зэрэг 29 нэр төрлийн 44 ширхэг бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгч суурилуулсан.

**ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- ✓ Цэцэрлэгийн багш нар өөрсдийн бэлтгэсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг хэвлэж, тараах материал бэлтгэдэг болсон.
- ✓ Хүүхдүүд нас насны онцлогт тохирсон тоглоомоор тоглож, сэтгэхүй болон бие бялдрын хөгжил сайжрах боломж бүрдсэн.
- ✓ Цэцэрлэгийн сургалтын материаллаг бааз сайжирсан.

**19-р цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл И.Содбаяр:**

Цэцэрлэгийн сурагчдын маань гадаа талбайд тоглож наадах, мөн сургалтын тоног хэрэгслээр хангасанд баяртай байна. Энэхүү гадаа тоглоомын иж бүрэн талбайтай болсноор хүүхдүүд маань гадаа цэвэр агаарт тоглон, эрүүл чийрэг байх нөхцөл боломжоор хангагдлаа. Бас багш ажилчдад маань ч сургалтаа бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна. Энэхүү төслийг санхүүжүүлсэнд эцэг эхчүүд бид бүхэн маш их баяртай байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2020 ОНД ДАЛАНЗАДГАД СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

1. АЮУЛГҮЙ ОРЧИН-АМЬДРАЛЫН БАТАЛГАА



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
“ГОВИЙН ДӨРВӨЛЖ ХАЙРХАН” ХХК
36,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сумын иргэд төрийн үйлчилгээг аймаг, сумын ЗДТГ, төрийн бусад байгууллага, агентлагуудаас авдаг байсныг өөрчилж 2019 онд Оюут 7-р багийн хүн амын төвлөрөл ихтэй төрийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх боломжтой байршилд нэг цэгийн үйлчилгээний газар байгуулсан. Тус цэгийн байршил нь төвөөс холгүй боломжийн боловч уг цэгт хүрч очих тээврийн хэрэгсэл зорчих болон явган хүн явах хэсэг нь засч сайжруулах шаардлагатай, ус их тогтдог, ариутгал халдваргүйжүүлэлт шаардлагатай орчин байгаа. Тиймээс тэр хэсгийн газрыг тэгшилж ариутгал хийж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага зайлшгүй тулгарсан.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Даланзадгад сумын Оюут 7-р багийн 2390 иргэн, цаашлаад Даланзадгад сумын 26748 иргэний амьдрах, төрийн үйлчилгээг эрүүл аюулгүй орчинд авах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгор 2600 м² талбайн шороон замын тэгшилгээ, хотгор гүдгэрийн дүүргэлт, усан сан орчмын хөрсний ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийнэ.

**ТӨСЛИЙН ТӨСӨВ:**

№	Зардлын нэр	Бүгд өртөг /₮/
1	Барилга угсралтын ажлын төсөвт өртөг	32,272,727
2	Нэмэлт өртгийн албан татвар (10%)	3,227,273
3	Норм, норматив боловсруулах сангийн шимтгэл (0.18%)	
Дэд дүн		35,500,000
4	Захиалагчийн албаны эсвэл зөвлөх үйлчилгээний зардал 2%	-
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	500,000
Шууд зардлын дүн		500,000
Нийт дүн		36,000,000

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Даланзадгад сумын Оюут 7-р багийн 2600 м2 талбайн шороон замын тэгшилгээ, хотгор гүдгэрийн дүүргэлт, усан сан орчмын хөрсний ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэсэн
- ✓ Иргэд төрийн үйлчилгээ авахаар олноор зорчдог зам талбай чөлөөтэй, шавар шавхай, тогтоол ус, хог тогтохооргүй тэгш цэлгэр болсон.
- ✓ Оюут 7-р багийн иргэд төрийн үйлчилгээ төвлөрсөн хэсэгт машинаар болон явганаар аюулгүй зорчих боломжтой болсон бөгөөд халдваргүйжүүлэлт хийсэн газраар явах иргэдийн аливаа халдварт өвчин авах эрсдэл багассан.

Оюут 7 дугаар баг Оюутын 7-10 тоотод оршин суугч иргэн Л. Болормаа

Би манай багийн 2 гудамжны шороон замын тэгшилгээг "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр хийсэн гэж сонссон. Үнэхээр сайхан болсон байсан. Бид хотгор, гүдгэр замаар хүүхдээ хүргэх, авах гээд явган, мөн машинтай зорчдог. Энэ зам тэгшлээгүй байхдаа үнэхээр хэцүү байсан. Би энэ замыг тэгшлэхээс өмнө нүх рүү гишгээд хөлөө гэмтээж ч байсан юм. Машин техникт ч халтай гэж яригддаг байсан энэ зам засагдаж тэгшлэгдээд ийм сайхан болчихсон үнэхээр сэтгэл өндөр байна. Бүр сайжруулаад засмал замалтай холбочихвол бүр л сайхан байна. Гэхдээ засмал тавихад их мөнгө орно. Ямар ч байсан бидний амьдарч байгаа орчин нөхцөлд ийм том ажил хийж өгсөн тэр хүмүүст баярлалаа.

▶ 2. МОНТЕССОРЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНЭЭР ДАМЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

Ш.ГЭРЭЛМАА

5,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сургуулийн өмнөх насны хүүхдийн тархи хамгийн уян хатан, суралцах өргөн боломжийг агуулдаг онцлогтой байдаг. Тиймээс сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийг сургах, сургуульд бэлтгэхээс гадна хүний хөгжлийн үндэс суурь, өөрийн онцлог, чадвар бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын чухал үе хэмээн хөгжүүлэх шаардлага урган гарч байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Монтессори хичээлүүдээр дамжуулан Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн 2-6 насны 320 хүүхдийн математик сэтгэлгээ, амьдрах арга ухаан, мэдэрхүй, тоо тооллын чадамжийг хөгжүүлнэ. Уг төслийн хүрээнд монтессори хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авч 11 сургагч багш бэлтгэнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Монтессори сургалт нь хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйг хөгжүүлдэг олон улсын хөтөлбөр бөгөөд энэхүү сургалтын хөтөлбөрт хамрагдаж Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн хүүхдүүд оюун ухаан, бие бялдраар цогцоор нь зэрэг хөгжүүлж хувьсан өөрчлөгдөж буй орчин, нөхцөлтэй зохицон амьдрах чадварт суралцаж чадахаар боллоо. Монтессори сургалтын арга зүйгээр 11 багш дадлагажсан бөгөөд худалдан авсан хэрэглэгдэхүүнээрээ Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн 320 хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх хичээл орж байна. Бусад цэцэрлэгүүд сургалтандаа нэвтрүүлэх боломжтой туршлага болсон.

Багш А. Ууганчимэг:

Манай цэцэрлэг 2015 онд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр баригдсан. Цэцэрлэг баригдсанаас хойш "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилттэй 3 төсөл хэрэгжүүлээд байна. Эхний хэрэгжүүлсэн төсөл нь "Олон улсын STEM сургалтын хөтөлбөр" байсан бөгөөд аймагтаа анх удаа олон улсын стандартын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлсэн цэцэрлэг болж ажилласан. 2 дахь удаад Хүүхдийн хөдөлгөөнийг дэмжсэн "Хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр"-өөр цэцэрлэгийн өрөөг тохижуулан зориулалтын хэрэглэгдэхүүнээр хангасан. 3 дахь төсөл нь одоо хэрэгжүүлж буй "Монтессорийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан хөгжүүлэх арга зүй" төсөл юм. Монтессори хэрэглэгдэхүүн нь хүүхдийг бие даасан, бүтээлч, эмх цэгцтэй, сонголт хийх боломж олгодог, алдаагаа өөрөө олж засдаг, баяр хөөр, шинжлэх ухаанч мэдлэг олгодог чухал хэрэглэгдэхүүн. Монтессорийн сургалтын хэрэглэгдэхүүнийг иж бүрнээр авсандаа маш их байрлаж байна. Бүх хэрэглэгдэхүүн нь модон материалаар хийгдсэн хүүхдэд аюулгүй хэрэглэгдэхүүн юм. Энэ бүгдийг хэрэгжүүлэхэд дэмжин ажилласан "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олонд нийт багш, ажилчид, хүүхэд, эцэг эхийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье.

**25-р цэцэрлэгийн хүүхэд Амар-Эрдэнэ:**

Хүүхдүүд их сонирхож би би гээд уралдаад багш энэ хичээлийг дахиж орох уу гэж асуудаг.

Монтессорийн хичээл орох өдөр цагийг хүлээдэг. Их сонирхож байгаа учир маш тэвчээртэй сууж хичээлдээ оролцдог.

▶ 3. ШИНЭ ЗУУНЫ ХОТ СОЁЛТОЙ ИРГЭН



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
А.ЖАМЪЯНДЭЛГЭР
37,969,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хот суурин газар хөгжихтэй зэрэгцээд иргэд, оршин суугчдыг хотын соёлд сургах шаардлага зайлшгүй тулгардаг. Гудамж талбайд нус цэр, шүлсээ хаяхгүй байх, хогоо хогийн саванд хаях, эргэн тойрныхоо хүмүүсийн амар амгалан байдлыг өөрийн зүгээс хангаж амьдрах, хот суурин газрын бүтээн байгуулалтыг үнэлж хүндэлж хайрлан хамгаалах, цаашлаад байгальдаа хор нөлөөтэй зүйл хийдэггүй байх гэх мэт орчин тойрондоо сэтгэлтэйгээр хандах зэрэг дадал хэвшил ухамсар нь хотын соёлын нэгээхэн хэсэг билээ. Даланзадгад сум өргөжин тэлж төвлөрөл ихсэхийн сацуу нийт иргэдэд хотын соёлыг түгээх шаардлага зайлшгүй гарч байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:


Соёлтой иргэнийг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, хөгжил, бүтээн байгуулалтыг цахим орчинд сурталчлах ажлыг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийг Даланзадгад сумын ЗДТГ-т нийлүүлж, 175 видео контент бэлтгэн түгээх ажлыг хийнэ. Даланзадгад хотод хийгдэж байгаа ажил арга хэмжээнүүд, бүтээн байгуулалт болоод санхүүжүүлэгч "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд нийгмийн цахим сүлжээгээр дамжуулан сурталчилна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ 31 нэр төрлийн 42 тоног төхөөрөмж нийлүүлж, 1 жилийн турш 5 чиглэлийн 175 контент гаргаж байна.
- ✓ Даланзадгад сум видео, танилцуулга, мэдээлэл гаргах зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй болсноор Даланзадгад сумын иргэдэд хотын соёлыг түгээх, иргэдийг төлөвшүүлэх ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллах бүрэн боломжтой болсон
- ✓ Даланзадгад сумын иргэдэд орчноо хайрлах, бусдыг хүндэлж соёлтой амьдрах дадал төлөвшил илүү их суулгах үйл ажиллагаанууд хийгдэж байна.

№	Хийх ажил	Хугацаа
	Их хотын соёлтой иргэдийг бий болгох тэдэнд нөлөөлөх контент	50 удаа
1	“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн талаарх мэдээг цувралаар гаргах	25 удаа
2	Арван жилийн сурагчдын дунд хотын соёл, бусдын хийж бүтээсэн зүйлсийг хэрхэн хайрлан хамгаалах талаар сургалт хийнэ	10 удаа
3	Даланзадгад хотод хийгдэж байгаа цаг үеийн ажил арга хэмжээнүүдийг иргэдэд хурдан шуурхай хүргэж мэдээлэл түгээх	50 удаа
4	Хотын соёл юунаас эхэлдэг соёлтой иргэн гэж хэнийг хэлэх талаар видео контент	25 удаа
5	Өсвөр үеийнхэнд чиглэсэн сургалт арга хэмжээнүүд	15 удаа

Бэлтгэсэн контентуудыг Фэйсбүүкийн “Дэвшилтэт Даланзадгад” пэйж дээр байршуулж байна:



Даланзадгад сумын 7-р багийн иргэн Б.Наранцэцэг:

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон Дэвшилтэт Даланзадгад пэйж болон React up студи нь байгуулагдсанаасаа хойш хотын соёлыг иргэдэд түгээх чиглэлээр олон контентыг бэлтгэн хүргэж нийгэмд нөлөөлж чадаж байгаа юм. Энэхүү төслийг дэмжиж, хийж бүтээе гэсэн сэтгэлтэй хүмүүсийн санаачилгыг дэмжиж нийгэмд хэрэгцээтэй төслүүдийг санхүүжүүлж ажилладаг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олонд баярлалаа.



▶ 4. ЭРҮҮЛ БИЕ-АМЖИЛТЫН ҮНДЭС



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

Т.УУГАНБАЯР

24,491,600 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Улсын цэцэрлэг сургуулиудад эд хөрөнгө авах зардал, төсөв бага улмаас сургууль, цэцэрлэгүүд сурагчдын эрүүл ахуйн орчин нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна. Эрүүл аюулгүй орчинд байгаа эсэхээс хувь хүний эрүүл мэндийн байдал шууд шалтгаалдаг учир сурагчдын эрүүл орчинд сурах нөхцөлийг бүрдүүлэх, мөн өөрсдөө эрүүл мэндээ анхаарах, анхан шатны мэдлэг олж авах нь чухал зүйл болоод байна. Даланзадгад сумын 8 багийн 26748 хүн амын нийгмийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн судалгааг хийх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх, анхны тусламжийг чанартай хүргэж байх шаардлагатай болж байна. Тийм учраас хүүхдүүдийг эрүүл энх байлгах нь чухал асуудлуудын нэг яахын аргагүй мөн билээ.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Даланзадгад сумын 6 сургуулийн 6772 сурагч, 516 багш ажилчид, 10 цэцэрлэгийн 2564 хүүхэд, 286 багш ажилчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай доорх багаж, хэрэгслийг хуваарилж нийлүүлнэ.



№	Тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Зайнаас халуун хэмжигч	ширхэг	25
2	Пулсоксиметр	ширхэг	16
4	Жин, өндөр хэмжигч	ширхэг	17
5	Төмөр бикс	ширхэг	16
6	Хүүхдийн утлагын аппарат	ширхэг	32
7	Утлагын сольдог хошуу	ширхэг	320
8	Нэг хэрэглээний шарик, бинт, ороох, боох материалын ком	ширхэг	34
9	Лотошик /бөөрөн таваг/	ширхэг	32
10	Хараа шалгах таблиц	ширхэг	16
11	Кварцын гэрлийн сольдог гэрэл	ширхэг	25

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Даланзадгад сумын 10 цэцэрлэг, 6 сургуулийн хүүхэд багачууд эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг сургууль цэцэрлэг дээрээ авах нөхцөл боломж бүрдсэн
- ✓ Даланзадгад сумын 10 сургууль 6 цэцэрлэгийн нийт 9336 хүүхэд, 802 багш ажилчдын эрүүл мэндэд эергээр нөлөөлөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байна.



Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн эмч Н.Мөнхтоогоо:

Даланзадгад сумын ЗДТГазраас "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 10 цэцэрлэгийн эмч нарт нэн шаардлагатай эмчийн багаж, хэрэгслийг нийлүүлсэн нь үнэхээр цагаа олсон ажил байлаа.

Үүнээс: Бактерцитны ламп, зайнаас халуун хэмжигч, цахилгаан жин, өндөр хэмжигч, бикс, бөөрөн таваг, хүүхдийн утлагын аппарат, нүдний хараа шалгах тест, анхны тусламжийн иж бүрдэл нь цэцэрлэгийн эмчийн хувьд өдөр тутмын хэрэгцээ болж, байнга үйл ажиллагаандаа ашиглаж байна. Өндөр, жин хэмжигчтэй болсоноор бүх хүүхдүүдийнхээ БЖИ /биеийн жингийн индекс/



гаргаж дэлгэрэнгүй судалгаатай боллоо. БЖИ судалгаан дээр үндэслэн нэмэгдэл хоолонд гурван хүүхдийг хамруулахаар болсон. Мөн цуснаас гемоглобин үзэж цус багадалтыг тодорхойлсноор цаашид нарийн мэргэжлийн эмчид үзүүлээд байна. Сургууль, цэцэрлэгийн эмчийн ажиллах орчин, нөхцөл, багаж хэрэгслийг шийдвэрлэж бид бүгдийн ажлыг дэмжсэн "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олондоо Даланзадгад сумын цэцэрлэг, сургуулийн 9000 орчим хүүхэд багачууд, тэдний эцэг эхчүүд, сургууль цэцэрлэгийн эмч нарынхаа өмнөөс баярласнаа илэрхийлье. Эрүүл мэнд бүхнээс үнэтэй.

5. ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ БИЕ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
Ч.ДҮҮРЭНЖАРГАЛ
5,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Амьдралын буруу хэвшил, дадал зуршил, буруу хооллолтоос үүдэлтэй жингийн илүүдэл, зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин гэх мэт өвчнөөр өвчилсөн иргэдийн тоо эрс нэмэгдэх болсон. Зөв, зохистой хооллолтын талаарх мэдлэг, мэдээлэл хомс, мэддэг ч түүнийгээ хэрэгжүүлдэггүй иргэд гарал үүсэл нь тодорхойгүй тураах эм бэлдмэл ихээр хэрэглэж өөрийгөө эрсдэлд оруулж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар халдварын бус өвчний 83% нь буруу хооллолтоос шалтгаалж байна гэсэн байна.

Иймд иргэдэд зөв хооллолтын ач холбогдол, эрүүл амьдралын хэв маягт хэрхэн суралцах, хэрэгжүүлэх, хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх талаар сургалт, зөвлөгөө өгөх зайлшгүй шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙГДЭХ АЖИЛ:

Даланзадгад сумын 600 иргэнд 2 үе шаттайгаар дараах 3 агуулга бүхий сургалт явуулна.

- ✓ Зөв хүнс, зөв бүтээгдэхүүн сонгох
- ✓ Хоол хүнснээс үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх
- ✓ Эрүүл зөв хооллолт, түүний ач холбогдол

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Даланзадгад сумын иргэдэд дээр дурдсан 3 агуулга бүхий сургалтыг зохион байгуулна. COVID-19 цар тахлын эсрэг тогтоосон хорио цээр, цаг үеийн байдалтай холбоотой сургалтын ажил түр хойшлогдсон байна.

6. УЛЬТИМАКС



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

Н.ТАЙВАН-ЕРТӨНЦ

24,820,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Биеийн тамир, спортын салбарт шинэчлэгдсэн хууль тогтоомж, “Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т дэвшүүлсэн зорилтын хүрээнд “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх, салбар хоорондын уялдааг сайжруулах, идэвхтэй хөдөлгөөн, спортыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бүх нийтийн хөдөлгөөн болгон хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, хяналтын механизмыг оновчтой бүрдүүлэх, биеийн тамир, спортын заал, талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авах шаардлагатай гэж дүгнэсэн байдаг. Өмнөговь аймагт сүүлийн жилүүдэд биеийн тамир, спортын заал, талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг орон нутгийн зүгээс хэрэгжүүлж байгаа ч бие хамгаалах урлагийн төрөл орхигдож байгаа тул хөгжүүлэх шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Даланзадгад суманд карате, бокс, кик бокс, холимог тулаан, жюү жицүг спортын төрлүүдийг хүүхэд залуучуудад таниулах, бие бялдрыг хөгжүүлэх, өв тэгш хүмүүжил, хатуужил олгох, хөдөлгөөний дутагдлаас гаргах, авьяас чадварыг нээж аймаг, улс, тив, дэлхийн тэмцээнд оролцох, амжилт гаргахад дэмжлэг үзүүлнэ

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Дараах хэрэгслүүдийг нийлүүлж Даланзадгад сумын ЗДТГ-т хүлээлгэн өгч хамтран ажиллах гэрээгээр 5 төрлийн тулааны урлагийг Даланзадгад сумын сургууль цэцэрлэгийн хүүхдүүд, мөн сонирхсон насанд хүрэгчдэд заана.

№	Нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Татами /2х1м хэмжээтэй зөөлөн дэвсгэр/	ширхэг	130	90.000	11.700.000
2	Мишок /суурьтай/	ширхэг	2	350.000	700.000
4	Мишок /дүүжилдэг/	ширхэг	4	350.000	1.400.000
5	Мишок /ханын/	ширхэг	4	350.000	1.400.000
6	Хувцасны шкаф	локор	4	280.000	1.120.000
7	Хэрэгслийн шкаф	ширхэг	2	250.000	500.000
8	Гантель	ком	1	2.500.000	2.500.000
9	Штанк /суурьтай/	ком	1	2.800.000	2.800.000
10	Толгойны хамгаалалт	ширхэг	10	270.000	2.700.000
ДҮН					24.820.000

Дараах байдлаар хуваарь гарган ажиллаж байна

“ULTIMAX КЛУБЫН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД, НАСАНД ХҮРЭГЧДЭД ХОЛИМОГ ТУЛААНЫ СПОРТЫГ СУРТАЛЧЛАХ, ХИЧЭЭЛЛЭХ ХҮНИЙ ТОО”

№	Спортын төрөл	Хичээллэх анги	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	1 сард хамрагдах хүний тоо	Жилд хамрагдах хүний тоо
НЭГ. ULTIMAX КЛУБ ДЭЭРХ СУРГАЛТ										
1	Карате, Жюү жицү	6-11 насны хүүхдийн анги	09:00-11:00		09:00-11:00		09:00-11:00		20	240
2	Карате, Жюү жицү	11-18 насны хүүхдийн анги		09:00-11:00		09:00-11:00		09:00-11:00	20	240
3	Бокс, кик бокс	11-18 насны хүүхдийн анги	14:00-16:00		14:00-16:00		14:00-16:00		20	240
4	Бокс, кик бокс	Насанд хүрэгчдийн өглөөний анги	07:00-09:00	07:00-09:00	07:00-09:00	07:00-09:00	07:00-09:00	07:00-09:00	40	480
5	Холимог тулаан	Насанд хүрэгчдийн оройны анги	19:00-21:00	19:00-21:00	19:00-21:00	19:00-21:00	19:00-21:00	19:00-21:00	40	480
6	Бүх төрөл	Мэргэжлийн тамирчдын төлбөргүй анги								15 хүртэл



ХОЁР. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН СУРТАЛЧЛАХ СУРГАЛТ					
1	1-р цэцэрлэг	Карате, Жюү жицү спортыг Ахлах бүлгийн хүүхдүүдэд сард 1 удаа	Цагийг Цэцэрлэгийн удирдлагатай харилцан тохиролцоно	20	20
2	2-р цэцэрлэг			20	20
3	4-р цэцэрлэг			20	20
4	8-р цэцэрлэг			20	20
5	9-р цэцэрлэг			20	20
6	11-р цэцэрлэг			20	20
7	23-р цэцэрлэг			20	20
8	24-р цэцэрлэг			20	20
9	25-р цэцэрлэг			20	20
10	26-р цэцэрлэг			20	20
11	ЕБС-ийн сургууль 1	Биеийн тамирын хичээлээр дамжуулан сард 1 удаа	Цагийг Сургуулийн захиргаатай харилцан тохиролцоно	600	600
12	ЕБС-ийн сургууль 2			500	500
13	ЕБС-ийн сургууль 3			600	600
14	ЕБС-ийн сургууль 4			600	600
15	ЕБС-ийн сургууль 5			500	500
16	ЕБС-ийн сургууль 7			200	200
ХАМРАГДАХ ХҮНИЙ ТОО					4880 хүртэл

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Тус клубт хичээллэснээр биеэ хамгаалах урлагт суралцах бөгөөд аймаг, улс, бүс, Ази, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд оролцож амжилт гаргах бүрэн боломжтой:
- ✓ 1-6 сар хичээллээд Аймгийн аварга, бүсийн тэмцээнд оролцох
- ✓ 6-12 сар хичээллээд Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох
- ✓ 12-24 сар хичээллээд Олон улс, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох
- ✓ 24-36 сар хичээллээд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох ур чадварыг эзэмшиж чадна.

3-5 жилийн дотор Азийн шилдэг холбоо болох One Championship холбоонд тамирчдаа оруулах, цаашлаад Дэлхийн шилдэг холимог тулааны холбоо болох UFC-д Өмнөговь аймгийн тамирчинг оруулах алсын хараатай ажиллана.

Тоног төхөөрөмжийг гэрээний дагуу нийлүүлж сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн.

“Ultimax” холимог тулааны холбооны тэргүүн Н. Тайван-Ертөнц:

Даланзадгад сум энэ жилийн квотын санхүүжилтээр “Ultimax” клубыг иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж, таван төрлийн спортоор дамжуулан хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, мэргэжлийн тамирчдын ур чадварыг сайжруулах ажилд хөрөнгө орууллаа. Тус клубт одоогийн байдлаар 30 орчим хүүхэд залуус хичээллэж байгаа ба холимог тулаан, кик боксын халз тулааны тэмцээнийг Өмнөговь аймагтаа анх удаа амжилттай зохион байгуулсан байна. “Ultimax Mongolia” холбоо нь Өмнөговь аймгийн Даланзадгад хотод үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр клубын маань сургалт явуулах орчин нөхцөл сайжирч, холимог тулаан, кик бокс, карате, кюү жицү болон галбиржуулах ангиуддаа сургалт явуулж байна. Орон нутагт спортын хөгжлийг дэмжин ажиллаж буй “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-даа баярлалаа.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2020 ОНД БАЯНДАЛАЙ СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

6. СОЁЛЫН ТӨВИЙН ДОТОР ТОХИЖИЛТ



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ГАН МӨНХ БАХАРХАЛ КОНСТРАКШН” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 20,343,800 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баяндалай суманд 2020 онд 280 хүний суудалтай соёлын төвийн барилга баригдаж ашиглалтанд орсон. Тус барилгын дотор тохижилтыг төслийн санхүүжилтээр шийдвэрлэх шаардлага тулгарсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Соёлын төвийн ажилтнууд, иргэдэд тав тухтай орчинд ажиллах, үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Баяндалай сумын Соёлын төвд 16 нэр төрлийн 81 ширхэг тавилга, хэрэгсэл нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөтөлбөрийн үр дүнд Баяндалай суманд шинээр ашиглалтанд орсон соёлын төв шаардлагатай тавилга, хэрэгслээр хангагдсан бөгөөд соёлын төвийн ажилтнууд тав тухтай орчинд ажиллах нөхцөл бүрдэх, иргэд орчин үеийн стандартын шаардлага хангасан орчинд үйлчлүүлэх зэрэг эерэг үзүүлэлтүүд бий болсон.

Баяндалай сумын Соёлын төвийн эрхлэгч С.Өнөрбаяр:

Манай соёлын төв энэ жил шинэ барилгатай болсон. Шинэ барилга ашиглалтанд ороход тохижуулах том ажил гардаг. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн 20,3 сая төгрөгийн санхүүжилтээр соёлын төвийн маань шаардлагатай тавилга хэрэгслээр хангагдсанд бид баяртай байгаа. Төслийн санхүүжүүлэгч "Говийн оюу хөгжлийг дэмжих сан", захиалагч сумын ЗДТГ, гүйцэтгэгч "Ган мөнх бахархал" компаний хамт олондоо талархал илэрхийлье.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

2. АМГАЛАН ОРЧИН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ДЭТ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 38,226,936 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баяндалай сумын төв дэх 13-р цэцэрлэг, сумын нийт эзэмшлийн тоглоомын талбай дээгүүр 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам дайрч гардаг байсан нь хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдалд маш их эрсдэл бий болгодог байсан. Иймээс иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах үүднээс тус шугамыг буулгаж, өөр трассын дагуу уг шугамыг татах шаардлагатай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хамгаалах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Баяндалай сумын 13-р цэцэрлэг болон сумын нийт эзэмшлийн тоглоомын талбайн дээгүүр гарсан 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын трасс өөрчилж цамхагт гэрэлтүүлэг суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөтөлбөрийн үр дүнд Баяндалай сумын 13-р цэцэрлэг, сумын нийтийн эзэмшлийн талбай дахь тоглоомын талбайн дээгүүр гарсан 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг буулгаж трассыг нь өөрчилснөөр иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хамгаалах, болзошгүй эрсдэлийг бууруулах боломжтой болсон.

▶ 3. “УХААЛАГ ХУДАГ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 22,500,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ

“УНДРАГА ӨМНӨГОВЬ” ХХК

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сумын төвийн иргэдийн ундны усны хэрэгцээг хангаж байгаа нэг худаг нь өвөл, зуны цагийн хуваариар ажилладаг, бусад үед худаг хаалттай байдаг учир цагийн ажилтай болон гадагшаа явсан иргэд шөнө оройн цагаар ирээд хүссэн үедээ усаа авах боломж хязгаарлагдмал байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Иргэдэд 24 цагийн ажиллагаатай ус түгээх ухаалаг худгаар үйлчлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Баяндалай сумын хуучин ус түгээх худагт шинээр худгийн барилга барьж худгийг тойруулан хашаа татан ухаалаг худгийн тоног төхөөрөмж суурилуулсан.



ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөтөлбөрийн үр дүнд Баяндалай суманд иргэдэд 24 цагаар үйлчлэх ухаалаг худагтай болж дараах эерэг үр дүнгүүд бий болсон. Үүнд:
- ✓ Ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн эрсдэл буурна.
- ✓ Шинээр худгийн барилга барьсан
- ✓ Худгийн гадна орчныг хяналтын камераар хянах боломжтой болсон.
- ✓ Усны хэмнэлт нэмэгдэнэ.
- ✓ Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийгдэхгүй болсон эрүүл ахуйн шаардлага, халдвар хамгааллын дэглэмд нийцэж байгаа.
- ✓ Усны картаар үйлчлүүлэгчдийн бүртгэл, мэдээллийн сантай болно.
- ✓ Усны зарцуулалт, борлуулалтыг нарийн хянах боломжтой болсон.
- ✓ Ундны усан хангамжийн хүртээмж сайжирна.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2020 ОНД МАНДАЛ-ОВОО СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

▶ 1. “ТОГЛООМ-ХҮҮХЭД ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 8,000,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

ИРГЭН А.БАЙГАЛЬХҮҮ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сумын 17-р цэцэрлэг нь 58 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Тус суманд 2009 онд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга баригдсан. Одоогоор тус цэцэрлэгт 15 багш ажилчидтай 4 бүлэгт 1.5-6 насны 95 хүүхэд хамруулан сургалтын өмнөх боловсролыг олгож байна. 2019 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр яслийн бүлэг нэмэгдсэн. Тус цэцэрлэг нь хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх шаардлагатай тоглоом, хэрэглэгдэхүүнээр хангагдаагүйн улмаас хүүхэд хөгжүүлэх орчин нөхцөл муутай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- ✓ Хүүхэд хөгжүүлэх тоглоомуудаар хангагдсан цэцэрлэгийн орчин бүрдүүлэх
- ✓ Хүүхдийн оюун санаа, сэтгэл зүйн болон бие бялдрын хөгжлийг сайжруулах, тэдэнд өөртөө итгэх итгэл, тэсвэр тэвчээр, багаар ажиллах, асуудлаа шийдвэрлэх чадваруудыг нь тоглоом, хэрэгслээр дамжуулан хөгжүүлэх.

**ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:**

Мандал-Овоо сумын 17-р цэцэрлэгт 24 нэр төрлийн 212 ширхэг тоглоом, хэрэгсэл нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

Мандал-Овоо сумын 17-р цэцэрлэг хүүхэд хөгжүүлэх тоглоом, хэрэгслээр хангаж сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хүртээмжтэй, үр дүнтэй явуулж байна.

**Мандал-Овоо сумын иргэн Г.Ганцэцэг:**

“Тоглоом-Хүүхдийн хөгжил” хөтөлбөр хэрэгжсэнээр бяцхан үрсүүдийн маань оюун ухаан сэтгэхүй, бие бялдрыг хөгжүүлэх, тоглонгоо суралцах боломж олгогдож байна. Хүүхдийн хөгжилд маш том хөрөнгө оруулалт хийж, тоглоомжуулж өгсөн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олондоо нийт эцэг эхчүүд болон хувийнхаа зүгээс талархал илэрхийлье.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

▶ 2. “ЦАГ УУРЫН МЭДЭЭГ ЦАГТ НЬ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 4,000,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

ИРГЭН А.ГАНЦЭЦЭГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сумын цаг агаарын харуулын алба нь 1961 оноос өнөөг хүртэл үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Уг албанд цаг агаарын мэдээ боловсруулах орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулаагүйгээс мэдээг өдөрт зөвхөн 3 удаа өгдөг хүчин чадалтай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- ✓ Иргэд, нийтэд цаг агаарын мэдээг цаг тухайд нь, үнэн зөв мэдээлэх
- ✓ Учирч болзошгүй эрсдэлээс хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, урьдчилан сэргийлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын Цаг уурын харуулын албанд цаг агаарын мэдээг автоматаар хэмжигч 5 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Мандал-Овоо сумын Цаг уурын албанд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж цаг агаарын төлөв байдлын мэдээллийг дэлгэцэн дээрээс хүссэн үедээ, үнэн бодитой, түргэн шуурхай авдаг болсон.

▶ 3. “ӨНӨД ДЭЭДЛЭХ ӨВ СОЁЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 9,870,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

ИРГЭН Ч.ЭРДЭНЭТОГТОХ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Нийгмийн өөрчлөлт, амьдралын хэв маягаас шалтгаалан хүүхэд, залуучуудын Монгол өв соёлын талаарх мэдлэг буурч үндэсний зан заншил, түүх соёл мартагдах, балрах эрсдэлтэй байдаг. Иймээс ирээдүй хойч үе болсон хүүхэд залуучууддаа ёс заншил, өв соёлын талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулан энэ талын мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлж байх шаардлагатай.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- ✓ Үндэсний өв соёл, зан заншлаа түгээн дэлгэрүүлэх, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх
- ✓ Ахмадуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж тэдэнд чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэхэд нь дэмжлэг болох

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын Ахмадын хороонд тавилгатай монгол гэр нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

Ахмадын хороо нь тавилгатай монгол гэртэй болж өв соёл, зан заншлын талаар сургалт мэдээлэл явуулах орчин нөхцөл сайжирсан төдийгүй тус сумын ахмадуудад чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэхэд нь дэмжлэг болсон. Гэрийн зарим хэрэгсэл, тавилгыг сумын иргэдээр хийлгэсэн тул түр ажлын байр бий болсон.



Мандал-Овоо сумын Мандал багийн иргэн А.Отгонбилэг:



“Өнөд дээдлэх өв соёл” хөтөлбөрөөр сумын ахмадын хороонд хүүхэд залуучуудад үндэсний уламжлалт зан заншил, нүүдэлчдийн өв соёлыг таниулах, өвлөн эзэмшүүлэх, арга ухааныг сургах зэрэг танин мэдэхүйн өндөр ач холбогдолтой, бодит үзмэрээс бүрдсэн сайхан танхимтай болсон. Ахмадууд бид Монгол зан заншлынхаа талаар мэддэг чаддаг бүхнээ энэ танхимаар дамжуулан хүүхэд багачууддаа зааж сургаж байгаадаа баяртай байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ 4. “НОГООН СУРГУУЛЬ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 12,700,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

“ХАС БАТ МӨНХ” ХХК

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний бодлого хөтөлбөрийн хүрээнд сургуулиар олгож буй боловсролын чиг баримжаанд сурагчдад экологийн боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Мөн сурагчдыг эрүүл хүнсээр хангахад төслийн дэмжлэг шаардлагатай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн үр дүнд тус сургуульд сургалтын тохилгог орчин бий болгож 160 сурагчдад экологийн боловсрол олгох хичээлд дэмжлэг болсон төдийгүй сурагчид багшийнхаа заавар, зөвлөмжөөр хүнсний ногоо тарьж сурах, тарьсан ногоогоо сургуулийн хэрэгцээнд хэрэглэж хөдөлмөрийн үр шимийг мэдрэх юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуульд нэг ширхэг хүлэмжийг дагалдах хэрэгслийн хамт нийлүүлж, барьсан. Мөн сургуулийн коридорт аквариум, гадна талбайд байгалийн чулуун тохижилт, ангиудад хиймэл зүлэг, тасалгааны цэцэг байрлуулах зэргээр ногоон орчин бий болгох ажлууд хийгдсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Бусад тохижуулсан хэрэгслүүд дээр туршилт хийх, танилцах, харах, мэдрэх зэргээр экологийн хичээлийн сургалтын орчин нөхцөл сайжирч сурагчдын байгаль дэлхийгээ хайрлах, хамгаалах зөв төлөвшилд эерэг нөлөө авчирсан.
- ✓ Сурагчдад экологийн боловсролыг үр дүнтэй эзэмшүүлэхэд дэмжлэг болсон.
- ✓ Сургуулийн үдийн цай хөтөлбөрийг өөрсдийн тарьсан шинэ ногоогоор хангах боломжтой болсон.
- ✓ Сургуулийн өнгө, үзэмж сайжирсан.



Мандал-Овоо сумын ЕБСургуулийн Хими, биологийн багш Б.Цэцэгжаргал:



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дэмжлэгтэйгээр манай сургууль “Ногоон сургууль” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхэд, залуучууд, орон нутгийн иргэдэд тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэг чадварыг түгээх, байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хүүхэд, залууст төлөвшүүлэх, зөв дадал хэвшилд сургах мөн биологийн хичээлийг сурагчид өөрсдөө бодитоор туршиж үзэх боломж бололцоогоор хангагдсан. Сургуулийн хэмжээнд 10 гаруй төрлийн 50 амьд цэцэг, загасны аквариум, усан оргилуур, зүлэг, хүлэмж, модны суулгац, олон нэр төрлийн мандлын цэцэг гэх зэрэг олон зүйлсийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар тохижуулж багш, сурагчдын сурч боловсрох таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

5. “ИРГЭНЭЭ ДЭЭДЭЛСЭН ЭЭЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ЭРХЭТ РАЙ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 19,850,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сумын ЗДТГ-ын үндсэн зорилго бол төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод, хүртээмжтэй, чанартай хүргэх бөгөөд Мандал-Овоо сумын тамгын газар 2017 онд нэг цэгийн үйлчилгээний танхимыг нээж иргэдэд 4 төрлийн төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байсан. Гэвч тус танхим нь зай талбай багатайгаас иргэдэд хүртээмжтэй, шуурхай үйлчлэх нөхцөл боломж муу учир танхимаа томсгох, тохижуулах, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх шаардлагаар төслийг санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод, хүртээмжтэй, чанартай хүргэх нөхцөл боломжийг сайжруулж төрийн албан хаагчдын ажиллах таатай нөхцөлийг нэмэгдүүлэх зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээний танхимд 9 нэр төрлийн 51 ширхэг тавилга, хэрэгсэл нийлүүлж суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Мандал-Овоо сумын ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээний танхимыг өргөжүүлэн иргэдэд 10 төрлийн төрийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай, хүртээмжтэй өгөх орчин, нөхцөлийг бүрдүүлсэн.

Мандал-Овоо сумын Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн А.Байгальсайхан:



“Иргэнээ дээдэлсэн ээлтэй үйлчилгээ” хөтөлбөрийн үр дүнд иргэдэд төрийн долоон байгууллагын 80 гаруй үйлчилгээг нэг цэгт хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Ингэснээр иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй, хүртээмжтэй авах боломжоор хангагдаж байгаа юм. Мөн төрийн албан хаагч бидэнд тав тухтай орчинд ажлын бүтээмж сайтай ажиллах эерэг нөлөө үзүүлж байгаад талархаж байна.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

▶ 6. “АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ОРЧИН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“АЙ ТИ ЭС ӨҮ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 6,578,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сум нь аялал жуулчлалын бүс нутагт оршдог тул сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын аялагчдын тоо нэмэгдэж сумын төвөөр дайран өнгөрөх, буудаллах зэргээр сумын төвийн хүн амын хөдөлгөөн ихэсч байна. Үүнтэй уялдан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгцээнд үндэслэн төслийг санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын төвийн замын хөдөлгөөний зөрчил, танхай, хулгай гэх мэт гэмт хэргээс үүдэлтэй зөрчил, осол, гэмтлээс урьдчилан сэргийлж, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Мандал-Овоо сумын ЗДТГ-т 6 нэр төрлийн 12 ш хяналтын камер, дагалдах хэрэгслийн хамт нийлүүлж, сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Мандал-Овоо сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай, гэр хороололд өдөр, шөнийн аль ч үед харах тусгал, хүчин чадал сайтай хяналтын камер суурилуулж гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлсэн.



**Мандал-Овоо сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, дэслэгч
Н.Тогмид:**


“Амар тайван амьдралын орчин” хөтөлбөрөөр Мандал-Овоо сумын төв камерын хяналттай болсноор аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй амар тайван ажиллаж амьдрах нөхцөл боломж бүрдэж, сумын төвийн хөдөлгөөн болон дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хянадаг болсон. Сум орон нутагт маань нэн шаардлагатай хөтөлбөр хэрэгжсэнд талархаж байна.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

7. “ӨӨДЛӨХ АЙЛЫН ӨНГӨ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ИВЭЭЛТ ТАЛ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 14,703,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга байшин нь нэгдсэн зохион байгуулалттай хаягжуулалт байхгүйгээс эмнэлгийн болон галын аюулгүй байдлын түргэн тусламжийн дуудлага цаг хугацаандаа очиж тусламж үзүүлэх, бусад ажлын зохион байгуулалт хийх, гадны хүмүүс зорьсон газраа хаягаар эрж олох, гэмт хэргийн зөрчлийн мэдээлэл хүргэх, мэдээллийн мөрөөр ажиллах, эрэл хайгуул хийх гэх мэт маш олон үйл ажиллагаанд хүндрэл чирэгдэл гардаг. Иймд сумын төвийн нэгдсэн хаягжуулалтыг стандартын дагуу хийж эмх цэгц, зохион байгуулалтад оруулах шаардлага тулгарсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Мандал-Овоо сумын төвийн нэгдсэн хаягжилтыг Монгол улсын “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандартын шаардлагад нийцүүлэн хийж эмнэлэг, цагдаа, иргэд, зорчигч, аялагчдад тухайн объектод саадгүй, түргэн шуурхай хүрэхэд нь дэмжлэг болох.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын төвийн гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажил хийгдэж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хөтөлбөрийн үр дүнд сумын төвийн албан байгууллага, айл өрх, гудамж талбайг стандартын шаардлагад нийцүүлэн хаягжуулж сумын төвийн өнгө үзэмж, эмх цэгцийг сайжруулна. Сумын 549 өрхийн 1623 иргэн болон сумын төвөөр ирэх иргэд, аялагчид хөтөлбөрийн үр шимийг шууд хүртэнэ.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2020 ОНД СЭВРЭЙ СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

▶ 1. “ НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ-НАСАН ТУРШИЙН БАТАЛГАА” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 8,845,600 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

Ц.САЙНЗАЯА АХЛАГЧТАЙ ИРГЭДИЙН БҮЛЭГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй суманд насан туршийн боловсролын сургалтын байр байхгүй учир сургуулийн нэг өрөөнд үйл ажиллагаа явуулж байсан. Мөн тус сум нь 2020 оныг “Өрх гэр бүл, насан туршийн боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбоотойгоор иргэдийнхээ боловсролд анхаарсан төслийг хэрэгжүүлэхээр санаачилсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Иргэд, хүүхдүүдэд амьдрах ухаан, ёс суртахууны олон төрлийн сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж танхимыг тохижуулж сургалтын орчныг сайжруулна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Насан туршийн боловсролын сургалтын танхимыг засварлан 20 нэр төрлийн 61 ширхэг тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг нийлүүлж суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Сэврэй сумын Насан туршийн боловсролын сургалтын танхим нь шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангагдан иргэдэд сургалт, зөвлөгөө үйлчилгээ явуулахад таатай орчин бүрдсэн.

Сэврэй сумын иргэн Б.Батцэцэг:



Би Сэврэй сумын Ерөнхий боловсролын сургуульд ажилладаг. Манай суманд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр насан туршийн боловсролын төвийг тохижуулж өгсөнд маш их талархаж байна. Миний бие уг төвийг байгуулагдсанаас хойш "Угийн бичиг хөтлөх арга зүй", "Нэхмэл гутал урлах арга зүй" зэрэг сургалтуудад хамрагдсан. 2020 оны 10 дугаар сард нэхмэл гутлын сургалтанд төв хөдөөний нийлсэн 24 бүсгүй хамрагдахад ямар нэгэн албан байгууллага дээр биш болохоор нялх хүүхэдтэй хүмүүс хүүхдээ авч

ирээд, дуртай цагтаа ирж буцаад, дутагдах зүйлгүй тохитой, дулаахан, сайхан санагдсан. Уг сургалтаас хойш 20 гаруй нэхмэл гутал хийж худалдан өрхийн орлогоо тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн мөн найз нөхөд болох 3 бүсгүйд зааж сургасан байгаа. Энэ мэтчилэнгээр надад үр ашигаа өгч байгаатай адил олон өрх гэр бүл бүсгүйчүүдэд үр өгөөжөө өгсөн сайхан төв байгуулсан сумын удирдлагууд, "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олонд үнэхээр их баярлалаа.

Сэврэй сумын иргэн Д.Булгантамир:

Сэврэй суманд Насан туршийн боловсролын сургалтын танхимтай болсноос хойш танхимын сургалтууд хэд хэдэн удаа зохион байгуулагдсан. Би 2020 оны 10 дугаар сард Нэхмэл гутал урлах арга зүйн сургалтанд нь хамрагдсан. Сургалтын өөрийн байртай болсноор иргэд бидэнд тав тухтай, хүссэн үедээ хүссэн сургалт авах боломжтой санагдлаа. Энэ төвийг байгуулснаар сумын иргэдэд маш их үр өгөөжтэй ажил болсон гэдгийг нэг удаагийн сургалтанд хамрагдаад мэдэрсэн. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олон болон сум орон нутгийн удирдлагууддаа баярлалаа. Сүүлийн жилүүдэд бүсгүйчүүдийн гар урлал, гэр бүл, залуучуудын сурах үйл ажиллагааг дэмжсэн ажлууд их хийгдэж байгаа нь "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилттэй холбоотой гэж ойлгон талархаж явдаг.



▶ 2. “АНГЛИ ХЭЛТЭЙ СЭВРЭЙН БАГАЧУУД” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 2,750,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

О.ӨРНӨХ АХЛАГЧТАЙ ИРГЭДИЙН БҮЛЭГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сум нь аялал жуулчлалын бүс нутагт оршдог, сургуулийн англи хэлний тохижилт муу зэргээс шалтгаалан сурагчдын англи хэлний мэдлэгийг сайжруулах, багш, сурагчдын ажиллах, сурах орчин нөхцөлийг нь сайжруулах шаардлагатай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын ажиллах, сурах орчин нөхцөлийг сайжруулж хүүхэд бүрийг хөгжүүлэх, бие даан суралцах чадварыг нь сайжруулах, гадаадын жуулчидтай харилцан ойлголцож сургах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Сургуулийн англи хэлний кабинетэд 9 нэр төрлийн /1 ширхэг принтер, 1 ширхэг номын тавиур, 77 ширхэг ном/ тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл нийлүүлж тохижуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

Сэврэй сумын Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний кабинет сурах бичиг, сургалтын материалаар хангагдаж багш, сурагчдын ажиллах, сурах таатай орчин бүрдсэн.

Сэврэй сумын ЕБС-н 7А ангийн сурагч О. Аззаяа:

Сайн байцаана уу? Манай сургууль "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгө оруулалтаар Англи хэлний сонирхолтой картууд бүхий номын сантай болсон билээ. Бид чөлөөт цагаараа ном уншиж, картаа ашиглан үгээ цээжлэх нь сонирхолтой бас үр дүнтэй байдаг. Та бүхэндээ баярлалаа.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

3. “БАГИЙН ХӨГЖЛӨӨС СУМЫН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
Ч.НАРАНЦЭЦЭГ АХЛАГЧТАЙ “АРВИН ЭРДЭНЭ”
ИРГЭДИЙН БҮЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 5,380,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сум нь гурван багтай бөгөөд багийн төвийн барилгууд халаалтгүй, хааяа зохион байгуулдаг хурал, үйл ажиллагааны үед зуух галласан ч жигд халдаггүй учир иргэдэд тав тухгүй байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Багийн төвийн барилгыг түргэн шуурхай халаах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тав тухтай орчинд явуулах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Сэврэй сумын Хоолт, Сайншанд, Бүйлсэн багуудад 6 ширхэг хийн халаагуур, 6 ширхэг хийн баллон дагалдах хэрэгсэл, хийн хамт нийлүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

Сэврэй сумын гурван багийн малчдад хурал, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагаагаа тохилог дулаан орчинд зохион байгуулах орчин нөхцөл нэмэгдэж багийн төвийн үйл ажиллагаа тогтмолжино.



Сэврэй сумын Бүйлсэн багийн иргэн И.Сумъяа:

“Багийн хөгжлөөс сумын хөгжил” төслөөр манай багийн төвд 2 ширхэг халаагуур суурилуулсан байна. Сайхан дулаахан хурлын танхимтай боллоо. Юм хөгжинө гэдэг сайхан юм. Малчид багийн хуралдаа мотоциклоор даарч ирэхэд хурлын заал нь дулаахан угтаж байна. Сайхан ажил санаачилж хэрэгжүүлсэнд сэтгэгдэл өндөр байна. Өвлийн улиралд 2-3 удаа багийн хурал зохион байгуулагддаг мөн бусад арга хэмжээнүүд зохиогддог. Тав тухтай орчин бүрдүүлж өгсөнд баярлалаа.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

4. “СЭВРЭЙ СУМЫН НУТАГТ БЭЛЧЭЭР УСЖУУЛАХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН ХОЛБОО” ТББ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 23,480,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын нутаг дэвсгэрт сүүлийн жилүүдэд агаарын дундаж температур +05 градусаар дулаарсан, газрын хөрсөн дээрх температур зуны аагим халууны үед +40 градусаас дээш хүрч халж байгаа, хур тунадасны хэмжээ багассан, салхины хурд нэмэгдсэн үзүүлэлтүүд ихсэж байна. Эдгээрээс шалтгаалан ургамалын гарц, мал услах худгийн ундарга муудан мал, малчдад хүндрэл, эрсдэл ихтэй болсон.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сэврэй сумын нутаг дахь гүн өрмийн эвдэрсэн худгуудыг сэргээн засварлаж усгүй бэлчээрийг усжуулах, бэлчээрийг хүртээмжтэй ашиглах, мал, малчдын усан хангамжийг нэмэгдүүлэх.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Сэврэй сумын Хоолт, Сайншанд, Бүйлсэн багуудын нутаг дахь ашиглалтын шаардлага хангадаггүй гүн өрмийн 7 худагт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлж суурилуулан ашиглалтанд оруулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

Сэврэй сумын гурван багийн 30 малчин өрхийн 96 хүн, 15100 мал сүрэг хөтөлбөрийн үр шимийг шууд хүртсэн.

Сэврэй сумын Малчин Очирбат овогтой Алтан-Очир:



2020 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр манай худаг дээр мотор, насос тоног төхөөрөмж суурилуулж өгсөн. Одоо энэ худгаас 4 айлын 2200 мал ууж байна. Гүн өрмийн худагт сүүлийн үеийн дизель мотор тавьж өгснөөр түлшний хэрэглээ бага өвлийн улиралд мотор асаахад хялбар, хэрэглээ сайтай байна. Гүн өрмийн худагт дизель мотор их тохиромжтой, ашиглалтын хугацаа урт, жижиг бензин мотор 2-3 жил болоод эвдэрдэг. Манай худагт тоног төхөөрөмж суурилуулсан та бүхэнд баярлалаа.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ 5. “ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ БАЙГУУЛАХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 38,990,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

НҮДЭН БУЛГИЙН ӨГӨӨЖ ХОРШОО

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын ЗДТГ нь 2019 онд Ёслол хүндэтгэлийн өргөө байгуулахаар 6 ханатай гэр барьсан. Уг гэрийг нар, салхи, борооноос хамгаалах, өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх зорилгоор гадна талаар нь хамгаалах байр барих, дотор тохижилтын ажлыг хийх шаардлагатай байгаа.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумандаа өнгө үзэмжтэй ёслол хүндэтгэлийн өргөөтэй болж хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, сум орон нутгаа сурталчлах, таниулах зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Төслийн хүрээнд Сэврэй сумын төвд байрлалтай сумын ЗДТГ-ын Ёслол хүндэтгэлийн өргөөний гэрийн гадна талаар нар, салхи, ус, чийгнээс хамгаалах зорилгоор байр барьсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

Сэврэй сум өнгө үзэмжтэй ёслол хүндэтгэлийн өргөөтэй болж хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, сум орон нутгаа сурталчлах, таниулах боломжтой болсон. Ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааг тохилог орчинд явуулах байртай болсон. Мөн хуримын ёслол зохион байгуулах, гэрлэлтийн баталгаа гардуулах зэргээр хосуудад гэр бүлийн үнэ цэн, эерэг дурсамж төрүүлэх, Монгол үндэсний ёс заншил таниулах, сурталчлах боломж сайжирсан, сумын өнгө үзэмжинд эергээр нөлөөлсөн зэрэг эерэг үр дүнгүүдийг бий болгосон.



Сэврэй сумын иргэн Х.Мөнхбат:

Сум орон нутаг минь Ёслол хүндэтгэлийн өргөөтэй болж залуучууд бид сэтгэл хангалуун байгаа. Залуучуудын амьдрал, гэр бүл бат бөх байхад хамгийн том үйлдэл бол гэрлэх ёс гэж боддог. Энэхүү арга хэмжээг зохион байгуулах сайхан өргөөтэй болох ажлыг санаачилсан хүмүүстээ баярлалаа. Мөн ёслол хүндэтгэлийн өргөөг бас сайхан тохижуулсан байна. Үнэхээр сэтгэл дүүрэн байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2020 ОНД БУЛГАН СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

1. “ФИТНЕСС ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ
“АНХСАН” ХОРШОО
7,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Булган сумын хэмжээнд хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх газар дутмаг байна. Залуучууд чөлөөт цагаа компьютер, зурагтны өмнө өнгөрүүлж байна. Соёлын төвд байрлах 80м² талбай бүхий фитнесийн зориулалттай өрөө байгаа боловч фитнесийн төхөөрөмжийн хүрэлцээ муу, одоо байгаа төхөөрөмжүүд эвдэрч муудсан байгаа учраас энэхүү фитнес өрөөг зориулалтын тоног төхөөрөмжөөр ханган тохижуулж, иргэдийг эрүүл чийрэг биетэй, зөв дадалтай болгох, спортоор хичээллэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Булган сумын иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл зөв дадалтай болгох зорилгоор фитнес өрөөг тохижуулж тоног төхөөрөмж нийлүүлнэ.

ТӨСЛИЙН ТӨСӨВ:

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Гүйлтийн зам	1 ш	2,800,000	2,800,000
2	Суурин дугуй	1 ш	650,000	650,000
3	Тросс	15 ш	9,500	142,500
4	Соронз	1 ш	32,000	32,000
5	Одоо байгаа төхөөрөмжийн засвар, тээвэр		511,500	511,500
6	Жин	1 ш	28,000	28,000
7	Багц төхөөрөмж	4	700,000	2,800,000
8	Фитнесс шал	3	120,000	36,000

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Гэрээнд заасан тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж сумын иргэд фитнессээр хичээллэж эхэлсэн. Фитнессийн танхим тохижуулснаар иргэд идэвхтэй хөдөлгөөн хийж эрүүл энх байх үндэс тавигдсан бөгөөд сумын хэмжээнд 300-400 иргэнийг байнгын үйлчлүүлэгч байлгах зорилтыг тавин ажиллаж байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2. “ЭМНЭЛГИЙН ГАЛ ТОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ
“БАЛЖ ХӨМӨЛИЙН УНДАРГА” ХХК
10,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Эрүүл, тэжээлтэй хоол хүнсээр хооллож байж хүн олон өвчнөөс урьдчилан сэргийлж болдог гэдгийг хоол судлаач, эрдэмтэд тогтоогоод байгаа. Тэр тусмаа эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй иргэдийн хоол эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байх зайлшгүй шаардлагатай байдаг. Булган сумын хувьд 1952 онд анх эрүүл мэндийн төвийн барилга барьснаас хойш 1985, 2010 онуудад барилга шинэчлэгдсэн боловч гал тогооны тоног төхөөрөмж хэрэгслүүд шинэчлэгдээгүй өдий хүрсэн байна. ЭМТ-ийн хувьд тоног төхөөрөмж муу, одоогоор галлаж хоол хийж байгаа ба эмчлүүлэгчдэд эрүүл, тэжээллэг хоолоор үйлчлэхээр хичээж ажилладаг. Энэ нөхцөл байдлыг өөрчилж тоног төхөөрөмж шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Булган сумын Эрүүл мэндийн төвийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилж ЭМТ-өөр үйлчлүүлж байгаа болон ЭМТ-д ажиллаж байгаа ажилчдад эрүүл, тэжээллэг хоол хүнсийг түргэн шуурхай стандартын дагуу өгөхийг зорьж байна.

ТӨСЛИЙН ТӨСӨВ:

№	Тоног төхөөрөмж	Үнэ ₮
1	Цахилгаан зуух 2 ширэмтэй, дотроо дамнуургатай шарх шүүгээ	3,000,000
2	Махны хөлдөөгч- дээд хэсэгтээ мах ногооны хөргүүртэй	4,100,000
3	1-2 хоолны таваг цайны аяга, халбага, сэрээ ариутгах хатаах шүүгээ	450,000
4	Хоолны дээж хадгалах хөргөгч	600,000
5	Хоол бэлтгэх ширээ	600,000
6	Ханын шкаф	750,000
7	Хутга ком, 1-2 хоол зөөх хувин, тагтай жигнүүр, ногоо хэрчигч	500,000

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Эрүүл мэндийн төвийн гал тогоонд шаардлагатай байсан тоног төхөөрөмж хэрэгслүүдийг нийлүүлснээр хэвтэн эмчлүүлэгсэд болон эрүүл мэндийн төвийн ажилчдын хоолыг бэлтгэхэд амар болж тогоочдын ажил хөнгөрч шим тэжээлтэй хоолоор түргэн шуурхай үйлчилдэг болсон.

Эрүүл мэндийн төвийн тогооч, бэлтгэгч нарын ажиллах орчин нөхцөл сайжирч эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн амт чанартай, шингэц сайтай хоолоор хэвтэн эмчлүүлэгч нарт үйлчилж эрүүл мэндийн төвийн үйлчилгээ сайжирсан


Булган сумын эрүүл мэндийн төвийн үйлчилгээний ажилтан С.Цэцэгмаа:

2020 онд Булган сумын Эрүүл мэндийн төв нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас 10 сая төгрөгийн гал тогооны иж бүрэн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаж стандартад нийцсэн гал тогоотой болсон билээ.

Үүний хүрээнд иргэдийн болон эмч, ажилчдын сэтгэл ханамж нэмэгдэж ая тухтай тохилог орчин бүрдэж эмчилгээний хоолоор үйлчлэхэд бэрхшээлгүй болж үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж эрс өссөн үзүүлэлттэй байна.

Үйлчлүүлэгчдийн ирүүлсэн сэтгэл ханамжийн судалгаанаас:

- ✓ Эрүүл тохилог ая тухтай орчин бүрдэж хоолны амт чанар нэмэгдсэн байна.
- ✓ Эмчилгээний хоолыг баталсан цэсийн дагуу олгодог юм байна. Өмнө жил хэвтэн эмчлүүлж байснаас тавтай тухтай болж хоолны чанар сайжирсан байна.
- ✓ Тохилог ая тухтай орчинг бүрдүүлсэн Эрүүл мэндийн төвийн хамт олондоо амжилт хүсье.



3. БУЛГАН СУМЫН ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ

“ДАЛАН-ОД” ХХК

39,500,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Төв суурин газарт оршин суугаа иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн тулд гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, зүлэгжүүлэлт хийх нь иргэдийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Иймд Булган сумын хувьд нэгдсэн байдлаар гудамжны гэрэлтүүлгийн ажил хийж иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байсаар ирсэн.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Булган сумын төвийн гудамжинд 13 гэрэл суурилуулж иргэдийн тав тухтай аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

ТӨСӨВ:

Д.д	Зардлын нэр	Бүгд өртөг ₮
1	Ажиллах хүчний зардал	6,265,091
2	Материал	17,878,125
3	Тээвэр	738,230
4	Машин ашиглалт	1,596,167
	Шууд зардлын дүн	26,477,612

5	Нэмэгдэл зардал-84,3%	2,698,290
6	Ашиг-15%	4,376,385
	Барилгын угсралтын ажлын дүн	33,552,288
7	НӨАТ 10%	3,355,229
8	Нормчлолын сан 0,18%	60,394
	Дүн	36,967,911
9	Захиалагчийн албаны зардал	671,046
10	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	850,000
11	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	339,997
	Дүн	38,828,954
12	Магадлашгүй ажил 2%	671,046
13	Бусад нэмэлт зардал	0
	Дүн	39,500,000

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Булган сумын төвийн гудамжинд 13 ширхэг гэрэлтүүлэг суурилуулав. Ингэснээр сумын иргэд болон сумын төвөөр зорчин өнгөрөгч, аялагч жуулчдын аюулгүй, тав тухтай орчинд байх нөхцөл, мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлж чадсан.
- ✓ Гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлснээр сумын өнгө үзэмж сайжирсан
- ✓ Иргэд шөнө оройн цагаар гэрэлтэй гудамжаар зорчдог болж аюулгүй байдал хангагдлаа.



Булган сумын иргэн Ц.Поль:

Манай суманд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Том хэмжээний төслүүд ч их хэрэгжиж байна. Мөн жижиг хэмжээний төслүүд нь бидний өдөр тутмын амьдралд үр шимээ өгч байна гэж би бодож байна. Манай гэрийн ойролцоо хийсэн гэрэлтүүлэг бол жижиг төсөл байх. Энэ нь олон айлын гудамжийг хамарсан маш сайхан гэрэлтүүлэг болсон.



4. БУЛГАН СУМЫН СУРГУУЛИЙН МОНГОЛ БИЧГИЙН КАБИНЕТИЙН ТОХИЖИЛТ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ
“ЛОГМОН” ХХК
6,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 6-9-р ангид 7 хоногт 2 цагаар 85 сурагчид Монгол бичгийн хичээл ордог. Монгол бичгээрээ бахархан сурах, бие биэндээ үлгэрлэн өв соёлоо түгээн дэлгэрүүлэх үйл явцыг түргэсгэж, үндэсний уламжлалт болон орчин үеийн бийрэн бичгээр сурагчдыг бичүүлж сургахын тулд Монгол бичгийн кабинетийг тохижуулан сурагчдын сурах орчин нөхцөлийг сайжруулах хэрэгцээтэй байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Монгол бичгийн хичээл заах, өв соёлөө түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, сургалт явуулах, мөн сурагчид хүссэн цагтаа дадлага хийх зориулалтаар орчин үеийн тохилог кабинетийг тохижуулах зорилготой.

ТӨСӨВ:

№	Зардлын төрөл	Үнэ ₮
1	Компьютер	1,230,000
2	Сурагч ширээ	1,800,000
3	Сурагч сандал-урт	960,000
4	Модон шкаф	600,000
5	3-н үйлдэлт А4 өнгөт принтер	500,000
6	Монгол бичгийн үзүүлэн-А2 дүрмийн	200,000
7	Кабинетийн булан, акустик хавтан-самбар	100,000
8	Монгол бичгийн ангийн булан	100,000

9	Бүтээлийн самбар	180,000
10	Муутуу цаас	100,000
11	Бэх, бийр	230,000

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Булган сумын сургуулийн Монгол бичгийн кабинетийг тохижуулан сурагчид идэвх сонирхолтойгоор хичээлдээ сууж багш нар сургалтын шинэ хэрэглэгдэхүүнээр хичээлээ заах орчин нөхцөл бүрдсэн.
- ✓ Иж бүрэн тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнтэй Монгол бичгийн кабинеттэй болж сурагчдын идэвх, оролцоо, бүтээмж нэмэгдсэн
- ✓ Сурагчид үндэсний бичгээрээ бахархах сэтгэлтэй болж хичээлд оролцох оролцоо нэмэгдэж байна
- ✓ Сурагчдын бийр ашиглан Монгол бичгээр бичих ур чадвар нэмэгдэж бүтээлч чанар сайжирна

Өмнөговь аймгийн Булган сумын ЕБСургуулийн 8а ангийн сурагч Ө.Мөнхчимэг:

Намайг Өлзийтогтох овогтой Мөнхчимэг гэдэг. Булган сумын ЕБСургуулийн 8-р ангид суралцдаг. Манай анги 14 сурагчидтай. Анги удирдсан багшийг Д.Батчулуун гэдэг. Монгол хэл, бичгийн



багшаар ажилладаг. Багш маань Өмнөговь аймгийн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д төсөл бичин ангиа тохижуулна гэж бид нарт болон эцэг эхийн хурал дээр ярьж байсан нь биеллээ олж энэхүү төсөл хэрэгжсэнээр олон зүйл өөрчлөгдсөн. Жишээлбэл: Өмнө нь цэнхэр өнгийн ширээ сандалтай байхад хувцас байнга урдаг, дорхноо салчихдаг эвдэрдэг байсан бол одоо модон ширээ сандалтай болсноор суухад тухтай, цэвэрлэхэд хялбар болсон. Мөн ангийн бүх самбар эко болж, акустик хавтангаар хийсэн самбаруудтай болсон. Мөн принтертэй болсноор ангидаа даалгавраа олшруулж канондаж хийдэг болсон гэх мэтчилэн ангийн орчин тухтай дулаахан болсон нь бид нар сэтгэл хангалуун ангидаа цагийг өнгөрүүлдэг болсондоо ангийн багшдаа болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олонд маш их баярлаж байгаагаа илэрхийлж байна.



5. АРЬС НЭХИЙ БОЛОВСРУУЛАХ ЦЕХ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ
“АЛТАНГОВИЙН ШИРЭЭ” ХОРШОО
10,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хөдөөгийн сумдын хувьд жижиг дунд бизнесийг хөгжүүлэх нь тухайн сумын эдийн засагт оруулах хувь нэмэртэй шууд холбоотой байдаг. Жижиг дунд бизнесүүд бий болсноор ажлын байр бий болж өрх гэрүүд орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, амьдралын чанараа дээшлүүлэх гэх мэт олон эерэг үр дүн гардаг. Тиймээс Булган суманд одоогийн байдлаар бий болох боломжтой байгаа малын түүхий эд, арьс ширийг боловсруулах цехийг байгуулбал орон нутгийн иргэдийн амьдрал ахуйд эергээр нөлөөлөх юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Малын түүхий эд болох арьс, шир, нэхийг боловсруулах жижиг цех байгуулж шинээр 3-4 ажлын байр бий болгоно

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Арьс шир боловсруулах цехийн барилга баригдаж үйл ажиллагаа явуулахад бэлэн болж байна.
- ✓ Үйл ажиллагаа жигдэрснээр сумандаа түүхий эдийн боловсруулалт хийх бололцоотой болж малчдын түүхий эд худалдан авч бүтээгдэхүүн болгох боломж бий болно.

▶ 6. БУЛГАН СУМЫН СУРГУУЛИЙН ДУУ ХӨГЖМИЙН КАБИНЕТИЙН ТОХИЖИЛТ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ
“БУЛГАН ЛУС” ХХК
8,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид сурч хүмүүжих явцдаа өөрийгөө таньж мэдэх, сонирхлоо нээн илрүүлэх, цаашид ямар мэргэжилтэй болж юу хийж амьдрахаа шийдэж байдаг. Булган сумын хувьд сурагчдынхаа идэвх санаачилгыг хөгжүүлэн хичээлдээ идэвх чармайлт гарган, дур сонирхолтойгоор суралцах үйл явцыг дэмжихийн тулд сургуулийн кабинетуудыг тохижуулах ажилд их анхаарч ажиллаж байна. Дуу хөгжмийн кабинетийн хувьд тохижилт хийхийн тулд хөгжим зэмсгээр хангах шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Булган сумын сургуулийн дуу хөгжмийн кабинетийг тохижуулж сурагчдын хөгжим сурах сонирхлыг дэмжиж дуу хөгжимд сонирхолтой хүүхдүүдийг сургана.

ТӨСӨВ:

№	Шаардлагатай хөгжим, хэрэглэгдэхүүн	Тоо ширхэг	Тавигдах шаардлага
1	Морин хуур	3	Сургалтын зориулалттай
2	Лимбэ	2	Хулсан- тоглолтын
3	Ятга	2	16 утастай
4	Чадлын өсгөгч	2	900x2-1800w
5	Утастай микрофон	2	Шүүрэн SM 58
6	Алсын зайн микрофон	2	Шүүрэн USB оролттой олон үйлдэлт
7	Холболтын утас	6м-2 ш	USB оролттой уян
8	Ёочин	1	Тоглолтын энгийн
9	Фүлт	1	8 замтай, 48В аар дээрээ чадалтай
10	Нөүтбүүк	1	CPU i5, 4 GB
11	Принтер	1	3 үйлдэлт, L 200

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Дуу хөгжмийн кабинет тохижуулах ажлыг эхлүүлж шаардлагатай зэмсэг болон бусад хэрэгслүүдийг нийлүүлж байна
- ✓ Уг хөгжмийн зэмсгүүдийг нийлүүлж дуу хөгжмийн кабинет тохижуулснаар Булган сумын сургуулийн 167 хүүхэд авьяас чадвараа хөгжүүлэх орчин бүрдэж сурагчдын идэвх санаачилга, оролцоо нэмэгдэнэ.

**Булган сумын ЕБС-ийн 9-р ангийн сурагч М.Энхзаяа:**

Би 7-р ангиасаа хөгжмийн дугуйланд хамрагдаж өөрийнхөө чөлөөт цагаар Монгол ардын хөгжмийн зэмсгийг тоглож амжилттай сурч байгаа. Хөгжмийн дугуйланд надтай адил олон сурагч хамрагддаг. Хөгжмийн зэмсгийн хүрэлцээ жаахан дутмаг байдаг. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн төслөөр бид хөгжмийн бүрэн зэмсэгүүдтэй болсноор урлагийн тоглолт, шинэ жилийн үйл ажиллагаа, урлагийн үзлэг зохион байгуулахад хүндрэлгүй таатай нөхцөл бүрдсэн. Чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх таатай орчинтой болсондоо бид бүхэн баяртай байна.

2020 ОНД ЦОГТ-ОВОО СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

▶ 1. ХАМТДАА СУРЧ ХАМТДАА ХӨГЖЬЕ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
“ТОВОН ОЧИР” ХХК
15,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасны дагуу Цогт-Овоо сум нь сар бүр зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн ажил зохион байгуулж уулзалт, хүлээн авалт хийх, мөн бусад нийтийг хамарсан үйл ажиллагааг иргэний танхимдаа зохион байгуулдаг.

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, иргэдийн ая тухтай байдлыг хангах, сумын иргэдэд сургалт мэдээлэл өгөх ажилд иргэний танхимыг тохижуулах шаардлага байна гэж үзсэн.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Цогт-Овоо сумын ЗДТГ-ын Иргэний танхимын нээлттэй байдал, мөн ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор дотоод тохижилт, техник тоног төхөөрөмж авч суурилуулах ажил хийнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Төслийн хүрээнд 85 тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлж Иргэний танхимын тохижилтын ажлыг хийсэн. Иргэд тав тухтай орчинд мэдээ мэдээлэл авч, сургалтанд хамрагдаж төрийн үйлчилгээг ая тухтай орчинд авч чаддаг боллоо.

Нийгмийн бодлогын мэргэжилтэн: Т.Одонцэцэг:

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар иргэний танхимын “Хамтдаа сурч хамтдаа хөгжье” төсөл амжилттай хэрэгжиж, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр бүрэн хангагдсан. “Хамтдаа сурч, хамтдаа хөгжье” уриан дор Аавуудын өдөрлөг амжилттай зохион байгуулагдсан. Бүх хайраа гэр бүлдээ арга хэмжээ зохион байгуулагдсан. Иргэд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах тохилог орчинтой болсондоо “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлье.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

▶ 2. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖ



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
“УРГАЦ КАПИТАЛ” ХХК
23,000,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Цогт-Овоо сумын 9 ортой 2 давхар эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сумын иргэдэд үзүүлдэг. Цогт-Овоо сум нь Даланзадгад сум, Улаанбаатар хот хоёрыг холбосон засмал зам дагуу байрладаг тул бусад сумдаас авто тээврийн осол аваар гарах нь илүү байдаг бөгөөд жил ирэх тусам осол аваарын тоо нэмэгдсээр байна. Цогт-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь гэмтлийн нарийн мэргэжлийн эмчгүй тул Даланзадгад сумын БОЭТ-д өвчтөн хүргэж өгөх шаардлага гардаг. Эмч мэргэжилтнүүд сургалт болон бусад ажлаар аймгийн төв рүү явах ажил ч их гардаг.

Эрүүл мэндийн төв нь 2 фургон автомашинтай бөгөөд 1 нь эвдрэл гэмтэл их гардаг болсон тул дуудлаганд явдаггүй. 1 фургоноор аймгийн төв ороход 60 литр шатахуун зарцуулдаг. Энэ зардлыг багасгах, мөн эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор шатахуун бага зарцуулдаг суудлын автомашин худалдан авч ЭМТ-д нийлүүлэх хэрэгцээ байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Фургон машины шатахууны зарцуулалтыг 50%-иар бууруулахын тулд, мөн суудал нь налж хүнд өвчтөнг хэвтүүлэн тээвэрлэх боломжтойг нь тооцож Prius 41 автомашин Цогт-Овоо сумын ЭМТ-д нийлүүлнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Цогт-Овоо сумын Эрүүл мэндийн төв сард дунджаар 21, жилд 258 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ явуулын байдлаар үзүүлэх, эсвэл Даланзадгад сум уруу шилжүүлэх ажил хийдэг тул эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа иргэд түргэн шуурхай үйлчлүүлж иргэдийн амь насыг аврах болж илүү их болно.

Эрүүл төвийн мэндийн эрхлэгч : Х.Гүнжлхам:

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас олгосон санхүүжилтийн квотын хүрээнд нийлүүлэгдсэн Prius 41 маркийн машинтай болсноор Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд маш их дөхөм болж байна. Ойрын болон сумын төвийн гэрийн дуудлаганд энэхүү машинаараа түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлж, аймгийн төврүү өвчтөн тээвэрлэхэд цаг хугацаа, шатахууны хэмнэлттэй ажиллаж байгаа давуу талууд их байна. Хамт олны болон иргэдийн сэтгэл ханамж өндөр байгаа билээ.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг

Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

▶ 3. ЭКО ОРЧИНГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭ



ЗАХИАЛАГЧ:	ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	АЗ БИЛЭГТЭЙ ХХК
НИЙТ ТӨСӨВ:	48,830,000 ТӨГРӨГ
САНГИЙН САНХҮҮЖИЛТ:	45,088,000 ТӨГРӨГ
ИРГЭДИЙН САНХҮҮЖИЛТ:	3,742,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн “Өрх гэр бүлийн хөгжлийн жил”-ийн хүрээнд, мөн сумын хөгжлийн бодлоготой уялдуулан зорилтот бүлгийн эмзэг ядуу өрхийн иргэдийн амьдрах орчин нөхцөл, орчны тохижилтыг сайжруулан жорлон, муу усны газрын нөөц бололцоогүй болсон, амьжиргааны түвшин доогуур өрхийн оршин суугаа газрын хөрсний бохирдлыг бууруулж байгаль орчинд ээлтэй эко нойлын шийдлийг бий болгох, мөн нийтийн эзэмшлийн гудамж талбайд хүүхэд, залуучууд, хөгшид салхилж, агаарт гарч амарч суух боломж олгох зорилгоор сүүдрэвч, савлууртай сандал, хогийн савыг байршуулах зэрэг тохижилтын ажил хийж сум орон нутгийн иргэдийн амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ ХИЙХ АЖИЛ:

Сумын төвийн гэр хорооллын өрхийн амьжиргаа түвшин доогуур иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж нийт иргэдийн сумандаа амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхийг зорино.

Нийтийн эзэмшлийн талбайд 1 сүүдрэвч, 2 савлуурт сүүдрэвчтэй сандал, 2 хогийн сав байрлуулж 20 хашаанд эко жорлон бий болгож 43 өрхийн 173 иргэний амьдралын орчин сайжирна.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- ✓ Гудамжны тохижилт хийгдэж гэр хорооллын иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирна
- ✓ Эко нойлын шийдлийг бий болгосноор хөрсний болон агаарын бохирдлыг бууруулж гэр хорооллын иргэд эрүүл, цэвэр эко орчинд амьдарна
- ✓ Иргэдийн халдварч өвчин тусах эрсдэл багасч эрүүл ахуй сайжирна

Төсөлд хамрагдсан Ц.Осормаа, А.Оюундорж, Ш.Гантулга:

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Замыншанд багийн иргэн Ц.Осормаа. Энэ төсөл нь ард иргэд бидний амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан чухал хэрэгцээтэй төсөл болж чадсан. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-д баярлаж талархсанаа илэрхийлье.



► 4. ДОТУУР БАЙРНЫ ОР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
Ц.БАТЦЭНГЭЛ АХЛАГЧТАЙ
“БАЯН ОРГИЛ” ИРГЭДИЙН БҮЛЭГ
9,990,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Цогт-Овоо сумын сургуулийн 80 хүүхдийн дотуур байр нь 2015 онд ашиглалтанд орсон бөгөөд ашиглалтанд орсон цагаас дотоод тохижилтын ажил хийх бололцоо олдоогүй бөгөөд дотуур байрны хүүхдийн орны хүрэлцээ муу байна. Одоо байгаа орнууд стандартад нийцэхгүй, хуучирч элэгдсэн байгаа. Ор хүрэлцдэггүй тул хүүхдүүд гэрээсээ ор авч ирэх, эсвэл нэг гэр бүлийн хүүхдүүд ороо хувааж хэрэглэх гэх мэт хүндрэлүүд гардаг. 80 хүүхдийн дотуур байр ч гэлээ 50 орчим хүүхэд ихэвчлэн байрладаг тул 50 хүүхдэд хүрэлцэхүйц орны хэрэгцээ байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Сумын сургуулийн дотуур байранд 25 ширхэг давхар модон ор нийлүүлж, хүүхдүүдийн сурч хүмүүжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлж одоо байгаа хүндрэлийг арилгах юм.

**ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:**

- ✓ Жил бүр дотуур байранд байрлах 50 орчим сурагчдын орчин нөхцөл сайжирч аятай таатай орчинд амьдарч эрүүл ахуй сайжирна.
- ✓ Дотуур байранд хүүхдээ байрлуулсан эцэг эхийн сэтгэл ханамжинд эергээр нөлөөлнө

Цогт-Овоо сумын ЕБС-ийн багш

2020 онд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд сурагчдын тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд анхаарч, стандартад нийцсэн, давхар модон ортой /50 ширхэг/ боллоо. Гэр орноосоо хол амьдран суралцаж байгаа малчин өрхийн хүүхдүүдийн тулгамдсан асуудал шийдэгдсэнд туйлын баяртай байна. Өмнө нь орны хангалт тааруу, стандартын бус, хүрэлцээ муутай байсан ба одоо тус тохижилтын хүрээнд өнгө үзэмж сайтай, байгалийн гаралтай, эрүүл мэндэд ээлтэй модон ортой болж, эмх цэгц, тав тухтай байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2020 ОНД НОМГОН СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

1. “СУРГУУЛИЙН ГАДНА ТАЛБАЙН ХАШАА” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОМГОН СУМЫН ЗДТГ
НОМГОН СУМЫН ЕБС-ИЙН БАГШ Д.ГАНБОЛД
28,945,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Номгон суманд 2020-2021 оны хичээлийн жилд эрдэмтэн Р.Цэрэндоржийн нэрэмжит 320 хүүхдийн багтаамжтай 2 давхар шинэ сургууль ашиглалтанд орж байгаа бөгөөд сургуулийн орчин, гадна тохижилтын санхүүжилт төсөвт нь суугдаагүй байсан тул сургуулийг олон нийтийн эзэмшлийн талбайгаас тусгаарласан хашаа, сургууль орчмын талбай зэргийг хийгээгүй тул гадна хашаа, хаалга, гарц гарам хийж стандартад нийцсэн аюулгүй, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх шаардлагатай болсон.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Шинэ сургуулийг хашаажуулснаар сургуулийн орчинг олон нийтийн эзэмшлийн талбайгаас тусгаарлах, орц гарцын хаалга хийх, багш ажилчид болон хүүхдүүдийг аюулгүй ажиллаж, суралцах орчинг бүрдүүлэх, бага ангийн сурагчдын аюулгүй байдалд анхаарч сумын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хамгаалсан чиглэл бүрт гарах хаалга, гарцыг байгуулна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Номгон сумын 320 хүүхдийн шинэ сургуулийг гадна орчноос тусгаарлах 240м хашаа, автомашин орж гарах том хаалга 1, явган хүнд зориулсан гарц дөрвийг хашааны дөрвөн талд гаргасан.



ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Шинээр ашиглалтанд орсон 320 хүүхдийн сургууль орчин үеийн загвар шийдэл бүхий аюулгүй хашаатай болсон.
- ✓ Суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагч, багш нар аюулгүй орчинд ажиллах, сурч боловсрох орчин нөхцөл бүрдсэн.
- ✓ Байгууллагын гадаад үзэмж сайжирсан.

Номгон сумын ЕБС-ийн багш Д.Жаргалсүрэн:

Сурагчдад таатай, аюулгүй орчин бүрдүүлж, стандартад нийцсэн хашаа хийсэнд сургуулийн сурагчид, багш болон сумын иргэд хөдөлмөрчид талархалтай хүлээн авч байна. Сэтгэл ханамж өндөр байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2. “ТОГЛООМЫН ТАЛБАЙ ТОХИЖУУЛАХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОМГОН СУМЫН ЗДТГ
НОМГОН СУМЫН ИРГЭН Х.БАТ-ЭРДЭНЭ
14,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

АНУ-ын сэтгэлзүйч, сурган хүмүүжүүлэгч Ховард Гарднер нь хүний авьяас чадвар, танин мэдэхүйн хөгжлийн талаар судалгаа хийдэг дэлхийд нэр хүндтэй эрдэмтэн юм. Тэрээр хэлэхдээ хүүхэд багачуудын хөгжил нь бие бялдар, хөдөлгөөн, хүртэхүй, хэл яриа, сэтгэл хөдөлгөөн – харилцаа, дадал дүй, анхаарал төвлөрүүлэлт, ой тогтоолт, дүрслэн төсөөлөн бодох зэрэг хөгжлийн олон талт хүчин зүйлүүдээр тодорхойлогддог тул хүүхдүүдийн оюун ухаан, харилцааг хөгжүүлэх үйлийг тоглоомын аргаар дамжуулан хөгжүүлэх нь хамгийн үр дүнтэй гэж дүгнэжээ. Номгон суманд олон нийтэд зориулсан цэцэрлэгт хүрээлэнтэй бөгөөд насанд хүрсэн иргэд амрах, алжаалаа тайлах, өсвөр насны хүүхдүүд тоглох талбайтай боловч бага насны хүүхдэд зориулсан талбай, тоглоом байдаггүй. Тиймээс уг хүрээлэнд бага насны хүүхдэд зориулсан тоглоомын талбай байгуулах шаардлагатай байгаа юм.

**ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

Номгон сумын цэцэрлэгт хүрээлэнд эрүүл ахуйн шаардлага хангасан, хүүхдэд тохирсон тохилог тав тухтай орчинд сэтгэл санаа, харилцааны таатай нөхцөлийг бүрдүүлсэн хүүхэд багачуудын хэрэгцээнд тохирсон тоглоомын талбай байгуулна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Цэцэрлэгт хүрээлэнд хүүхдүүдэд зориулсан гулсууртай тоглоом 2, хүүхдүүдээ тоглуулангаа амрах боломжтой эцэг эхчүүдэд зориулсан сүүдрэвч нэг ширхгийг нийлүүлж суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Бага насны хүүхдүүд тоглож, хоорондоо харилцаж хөгжих боломжийг бүрдүүлсэн тоглоомын талбайтай болсон.
- ✓ Хүүхдээ салхилуулж буй эцэг эхчүүдэд зориулсан сүүдрэвчтэй болсон

Номгон сумын иргэн Б.Мөнхбаатар:

Манай сумын цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд хүүхдийн тоглоомын талбай хийгдэж байгаад сэтгэл хангалуун байна.

Номгон сумын иргэн Б.Жаргалсайхан:

Эцэг эхчүүд хүүхдээ тоглуулах, салхилуулах газар байхгүй хэцүү байсан. Энэхүү төсөл хэрэгжсэнээр чөлөөт цагаараа хүүхдээ салхинд гаргаж, хамтдаа цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх болсонд баяртай байна.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ 3. “СТАНДАРТ ХАЯГ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОМГОН СУМЫН ЗДТГ

НОМГОН СУМЫН ИРГЭН Б.АЗБИЛЭГ

19,393,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Номгон сум нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 2528 хүн амтай, 859 өрхтэй гэж тоологдсон. Сум төвийн Рашаант, Жирэм, Хайрхан гэсэн 3 хороололд 54 гудамжинд 550 иргэн гэр бүлийн хэрэгцээндээ газар өмчилж авсан байдаг бөгөөд сумын төвийн иргэн, аж ахуй нэгж байгууллагын 41 хашаа болон байшин үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байдаг. Гэвч эдгээр үл хөдлөх хөрөнгө, хашаанд зориулалтын хаягжуулалт хийгдээгүйгээс үүдэн Номгон суманд ирсэн явуулын хүмүүс зорьсон газраа олохгүй байх, хаяг андуурах зэрэг хүндрэл учирч байна. Тиймээс Монгол улсад мөрдөгдөж буй стандартын дагуу айл өрх, албан байгууллага, барилга үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах шаардлагатай байна

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Номгон сумын төвд бүртгэлтэй айл өрх, албан байгууллагын хашаа, барилга, үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын 2019 оны 325 тоот тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” болон Монгол улсад мөрдөж буй хаягжуулалтын MNS 5283:2014 стандартын дагуу хаягжуулна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Номгон сумын төвийн 54 гудамжны эхлэл төгсгөлд гудамжны дугаарын хаяг, Рашаант багийн 8 гудамжны 52 хашаа, Жирэм багийн 23 гудамжны 211 хашаа, Хайрхан багийн 23 гудамжны 287 хашаанд гудамж болон хашааны хаяг, мөн сумын төвд буй 41 барилгын хоёр талд хаягжуулалт хийсэн.



ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Номгон сумын айл өрх, албан байгууллага, хашаа гудамж бүрт MNS 5283:2014 стандартын дагуу хаягтай болсон
- ✓ Суманд ирсэн явуулын иргэд хаяг андуурахгүй болсон.
- ✓ Шуудангийн үйлчилгээ, хүргэлтийн үйлчилгээ хурдан шуурхай хүрэх боломж бүрдсэн.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ 4. “ХҮҮХЭД ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОМГОН СУМЫН ЗДТГ
НОМГОН СУМЫН 14-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
БАГШ Б.АЛТАНТУЯА
15,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хөдөлгөөн нь хүүхдийн бие бялдрыг зөв тэгш хөгжүүлж сэргэлэн цовоо байхад тустай. Хүүхдийн бие бялдрын хөгжил нь тасралтгүй үргэлжилдэг үйл явц бөгөөд үндсэн суурь нь сургуулийн өмнөх насанд бүрэлддэг. Хөдөлгөөнийг амьдралын хэвшил болгосноор хүүхдийн сэтгэн бодох чадварт эергээр нөлөөлөхөөс гадна хөдөлгөөний дутагдал, түүнээс үүдэн гарах олон төрлийн өвчнөөс ангид өсөн торниход тустай.

Мөн хүүхэд урлаг, уран сайхныг сонирхож гоо зүйн мэдлэгтэй болдог ба дуу хөгжмийн хичээлээр хүүхдийн сонсгол сайжрах, хөдөлгөөний эвсэлтэй болох, хөгжмийн хэмнэл мэдрэх, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх чадварт суралцдаг.



Номгон сумын цэцэрлэгт хамран сургах тойргийн хүүхдийн 4 бүлгийн 98 хүүхдэд дуу хөгжим, биеийн тамирын хичээл бүлэг бүрт 7 хоногт хоёр цагаар ордог бөгөөд 98 гаруй хүүхэд хамрагддаг. Гэвч хүүхдэд хөгжмийн болон биеийн тамирын мэдлэг чадвар эзэмшүүлэх, хичээл сургалт явуулах тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас шалтгаалан энэ төрлийн сургалт, мэдлэгийг олгоход хүндрэлтэй байдаг.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Номгон сумын сургуулийн өмнөх боловсролын 14-р цэцэрлэгийн урлаг, спортын танхимыг тохижуулж, сургалт явуулахад шаардлагатай хөгжмийн тоног төхөөрөмж, биеийн тамирын хичээлийн хэрэглэлээр хангана.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Номгон сумын 14-р цэцэрлэгийн урлагийн заалыг тохижуулж дэвсгэр, урлагийн тайз хийж, ханын толь байрлуулсан. Мөн сургалтанд ашиглах микрофон, өсгөгч, бүжгийн хувцасыг хүлээлгэн өгсөн.

Биеийн тамирын танхимд нуман шат, ханын шат, суудаг тоглоомон машин, бөмбөлөг, мөлхөгч хоолой болон хүүхдэд зориулсан бие бялдрын төхөөрөмжүүдийг нийлүүлж суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хүүхдэд урлагийн болон биеийн тамирын хичээлийг үр бүтээлтэй заах сургалтын бааз суурь бүрдэж жишиг танхимтай болсон.
- ✓ Эрүүл аюулгүй орчин бий болсноор хүүхэд гоо зүйн мэдрэмжээ хөгжүүлж сэтгэл ханамжтай суралцаж байна.
- ✓ Сургалтыг програмын дагуу явуулах сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон.
- ✓ Багш нар идэвхтэй сургалтын арга зүйг шинэлэг, бодит орчинд нэвтрүүлж, бүтээлч сэтгэлгээ нь идэвхэжнэ.

Номгон сумын 14-р цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл Ч.Гэрэлт-Од:

Манай хүүхдийн цэцэрлэгт бие бялдрын тоглоомын танхим тохижуулан хүүхдийн сонирхол татсан хөдөлгөөнийг дэмжсэн, хүүхэд бүрийн сурах таатай орчин бүрдэж хүүхдүүдийн минь хувьд хамгийн дуртай тоглоомын төв бий болсонд баяртай байна.



5. “МАЛЫН ЭМЧ НАРЫН ЦАХИМ СИСТЕМИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОМГОН СУМЫН ЗДТГ
НОМГОН СУМЫН МАЛ ЭМНЭЛГИЙН
ТАСГИЙН ЭМЧ Т.МӨНХЗУЛ
4,870,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Номгон сумын мал эмнэлгийн тасаг, нэгж нь сумын нийт 662 малчин, мал бүхий өрхийн нийт 302,862 мал, амьтанд эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэж ажиллах зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна. Эмчилгээ үйлчилгээнд сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрч үзүүлэх тусламж үйлчилгээ сайжирч байгаа бөгөөд хөдөө алслагдсан айл өрхөөр цахим эрүүл мэнд, цахимаар өвчтэй мал амьтан бүртгэх, цахим гарал үүсэл бичих, дээд шатны мал эмнэлэгийн газартай цахимаар холбогдох зөвлөгөө тусламж авах зэрэг олон ажлууд хийгдэж байна.

Мөн “Малын эрүүл мэнд, Монгол мал” үндэсний хөтөлбөр хэрэгжиж, үүний хүрээнд мал угаалга, өвөлжөө, бууц ариутгал халдваргүйтгэл, мал сүргийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, дархлаажуулалтанд хамрагдсан мал, амьтныг цахимаар бүртгэх тайлагнах, гарал үүсэл бичих, гарал үүслийн гэрчилгээ хэвлэж олгох зэрэг ажлыг хийж байна. Малчид иргэдэд сүүлийн үеийн дэвшилтэт технологиор тусламж үйлчилгээ үзүүлэхэд эмч нар болон тасгийн мэргэжилтнүүдийн ашиглах техник хэрэгсэл хангалтгүй байгаа бөгөөд зөөврийн тоног төхөөрөмжүүд зайлшгүй шаардлагатай байгаа юм.



ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Мал эмнэлгийн тасаг, нэгжүүд зөөврийн таблет, зөөврийн компьютер болон өнгөт хэвлэгчтэй болсноор малд ямар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн талаар мэдээллийг малчин айл өрхийн гаднаас кординатаар цахим системд оруулах, гарал үүслийн гэрчилгээг байгаа газраасаа бичиж хэвлэн малчдад олгох, гарын авлага, тараах материал бэлтгэн малчдад хүргэснээр шинээр гарч байгаа мал амьтны өвчний шинж тэмдгийг малчид өөрсдөө анхлан онош тавьж малын эмчдээ мэдэгддэг, өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг мал эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зорилготой юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Номгон сумын мал эмнэлгийн тасаг нэгжид шаардагдаж буй компьютер, өнгөт принтер, таблет компьютерийг нийлүүлэн хүлээлгэн өгсөн.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Малын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг нэмэгдүүлсэн.
- ✓ Үйлчлүүлэгчдийн хүлээгдэл багасч, сэтгэл ханамж нэмэгдэж байгаа.
- ✓ Малын эмч нарын малчин өрхөд үйлчилсэн мэдээлэл цахим системд цаг алдалгүй бүртгэгдэж, мэдээ тайлан хурдан шуурхай болно.
- ✓ Нэгжийн эмч нарын цахим систем ашиглалт сайжирсан.

Малын эмч О.Эрдэнэзаяа:

Таблеттай болж цахимд мэдээлэл оруулснаар малын эмч бид сар, улирлын тайлан гаргах, багийн малчид хэдий хэмжээний малын гаралтай түүхий эд бэлтгэн борлуулж, худалдаалж буйг нэгтгэн гаргахад дөхөмтэй, хурдан шуурхай сайхан байна.

Малын эмч Б.Билгүүн:

Малчдад үйлчилгээг тухайн байгаа газраасаа шууд хүргэж чаддаг боллоо. Малын эмч нарын цаг хугацааг хэмнэсэн материаллаг баазтай боллоо.

2020 ОНД ХҮРМЭН СУМАНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР :

▶ 1. “ТУСГАЙ РОТЫН ХҮҮХДИЙН ТАЛБАЙ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

ХҮРМЭН СУМЫН ИРГЭН Б.ӨЛЗИЙТОГТОХ

7,500,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүрмэн суманд тусгай ротын 252 дугаар анги байрладаг бөгөөд цэргийн ангийн алба хаагчид уг суманд цэргийн хотхоны албан тушаалын орон сууцанд амьдардаг. Энэхүү орон сууцны хувьд 1985 онд ашиглалтанд орсон, сумын төвөөс 3 километрийн зайтай байдаг, хүүхдийн тоглоомын талбай байгаагүйгээс гадна байгуулагдсан үеэс хотхонд шинэчлэл засвар хийгдээгүй. Сүүлийн жилүүдэд цэргийн хотхонд ажиллагсад нь гэр бүлээрээ ирж суурьших болсонтой холбоотойгоор хүүхэд багачуудын тоо эрс нэмэгдэж, тэдний тоглох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар байхгүйгээс хүүхдийн эрх ихээр зөрчигдөх болсон. Тиймээс уг хотхонд хүүхдийн тоглоомын талбай байгуулах хэрэгцээ шаардлага байгаа ч албан тушаалын орон сууц нь харьцангуй цөөн өрхтэй учраас энэхүү ажлыг өөрийн хөрөнгөөр бие даан гүйцэтгэх боломжгүй юм. Тоглоомын талбай байгуулснаар одоо амьдарч байгаа болон цаашид ирж амьдрах албан хаагчдын гэр бүл, үр хүүхдүүдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх эрүүл аюулгүй орчинд тогтвортой ажиллах боломжийг нээж өгөх юм.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Албан тушаалын орон сууцанд амьдрагсдын оролцоонд тулгуурлан орон сууцны дэргэдэх тоглоомын талбайг шинээр тохижуулж, хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй, таатай орчны бий болгох, цэргийн хотхоны оршин суугчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн бүтээн байгуулалтыг хийх зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн суманд байрлах тусгай ротын 252 дугаар ангид хүүхдийн тоглоомын талбай байгуулж уг талбайд шаардлагатай хүүхдийн тоглоом, сандал, гэрэлтүүлгийг байрлуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Тусгай ротын хотхонд амьдардаг албан хаагчдын гэр бүл, хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрөөх, тухлах газартай болсон.
- ✓ Хүүхдүүд хоорондоо тоглож, харилцаж, нийгмийн харилцаанд орох боломж бүрдсэн.



Дэслэгч Э.Анхбаяр:

Хүүхдийн тоглоомын талбайтай болсонд сэтгэл маш өндөр байна. Та бүхэндээ баярлалаа.



**ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН**

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

▶ 2. “ХҮРМЭН СУМ ХОГГҮЙ СУМ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ
ХҮРМЭН СУМЫН ИРГЭН С.БАТСАЙХАН
9,700,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүрмэн суманд амьдардаг иргэд, албан байгууллагын гадна байрлах хогийн савнууд стандартын шаардлага хангаагүй, нэгэн загварын бус, хогийн сав нь таглаагүй, хэмжээний хувьд хэт том, эсвэл жижиг байдгаас шалтгаалан хог хаягдлын хуримтлал үүсэх, уг хуримтлалыг мал, амьтан бусниулан тараах, салхинд хийсэх зэргээр сумын орчин тойрон бохирдох, цаашлаад байгаль орчин болон сумын иргэдийн амьдрах орчин бохирдож халдварт өвчин үүсэх эрсдэлтэй байдаг. Мөн хог тээвэрлэх, зайлуулах үед стандартын бус савнаас хог хаягдал бутрах, хийсэх, үлдэх зэргээр тухайн орчин тойрныг бохирдуулж байгаагаас үндэслэн нэгдсэн нэг загварын, хог хаягдлын ангилах зориулалт бүхий хогийн сав байршуулах хэрэгтэй байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын төвийн гэр болон байшин хороолол, албан байгууллага, аж ахуй нэгж, үйлчилгээний газруудын байрлалд тохирсон хогийн савнуудыг байршуулснаар сумын өнгө үзэмж сайжрахаас гадна хог бутрах, мал амьтан онгичихоос сэргийлэх, хог дамжуулах, ачих хүмүүст илүү хялбар болгож, тогтмол хог ачих хугацааг хүлээлгүй өрхийн хогийг хадгалалгүй байгуулсан цэгт аваачиж хаях зэрэг олон талын ач холбогдолтой. Цаашлаад айл өрх бүрийг хогийн савжуулах, хогоо ангилан ялгаж сурахад илүү дөхөм болох юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн сумын төвийн айл өрх, аж ахуй нэгж, үйлчилгээний газруудын гадна талд 3 төрлийн загвар бүхий 17 ширхэг хогийн савыг хийж байрлуулсан. Уг савнууд нь хоол хүнсний хог хаягдал, дахин ашиглах болон дахин ашиглах боломжгүй шууд устгах гэсэн 3 төрлөөс ангилах зориулалттай юм.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хог хаягдлыг тээвэрлэх зардлыг хэмнэхэд эерэг нөлөө үзүүлж байна.
- ✓ Байр, хороолол, аж ахуй нэгжүүд нэг загварын, хог тээвэрлэхэд хялбар хогийн цэгтэй болсон
- ✓ Мал амьтад хог тараахгүй болсноос гадна хог хаягдал хийсэх, бутрахгүй болсноор сумын гадна болон дотор өнгө үзэмж сайжирсан.
- ✓ Иргэд ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд илүү хялбар болсон.

Хүрмэн сумын байгаль хамгаалагч Т.Баярчимэг:

Бид хоггүй сумын иргэн болох хамгийн эхний алхам бол хогийн саванд хогоо хаях зуршил бүтээх юм. Мөн суманд хог хаягдал багасах боломжтой боллоо. 3 нэр төрлийн хогийн сав бол тохиромжтой санагдаж байна. Өмнө нь бол бид хогоо хогийн саванд хиймээр байдаг ойр орчимд хогийн сав цөөтэй байсан бол одоо олон цэгт хогийн савтай болсноор бид хогоо хогийн саванд хийх зөв дадал зуршилтай болно гэж сумын байгаль хамгаалагчийн хувьд баяртай байна.

252-р тусгай ротын захирагчийн ар талын хангалт хариуцсан орлогч Б.Өлзийтогтох:

Сум орон нутагт өнгө үзэмж нэмсэн шинэлэг сайхан хогийн савтай боллоо. Хог хаягдлыг ялган ангилснаараа байгаль эх дэлхийгээ хайрлаж, үр хүүхдэдээ хог ангилж хаях зааж зөвлөх боломжтой боллоо. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-даа баярлалаа.



▶ 3. “ХҮРМЭН ГОЁЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

ХҮРМЭН СУМЫН ИРГЭН Д.МӨНХЗУЛ

16,239,999 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Хүрмэн сум нь 1500 гаруй хүн амтай. Үүнээс сумын төвд 500 орчим хүн оршин суудаг. 2008 онд шинэ соёлын төвийн байр ашиглалтанд орсон бөгөөд сум орон нутгийн ард иргэдэд урлаг соёл, спортын үйл ажиллагааг хүргэж байна. Өнөөгийн байдлаар спортын олон төрөлт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг боловч урлагийн ямар нэгэн арга хэмжээг зохион байгуулахад тухайн урлагийн төрөлд тохирсон үндэсний хувцас хэрэглэл дутмаг байдгаас зохион байгуулалтанд хүндрэл учирдаг. Энэ жил Өмнөговь аймгийн хэмжээнд боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан олон төрлийн урлаг, соёлын арга хэмжээ төлөвлөгдөн зохион байгуулагдаж байгаа юм. Зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа бүр нь урлагийн тусгай хувцас шаарддаг тул хувцас хэрэглэлээ өөрсдөө олох болдог.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Орчин үеийн соёл урлагийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өнгө үзэмж сайтай хувцас хэрэглэлтэй болж үзэгчдийн таашаалд нийцсэн урлаг, уран бүтээлийг үзэгчдэд чанарын өндөр түвшинд хүргэх, ардын авьяастныг дэмжих, залуучуудын хөдөө орон нутагтаа идэвх сонирхолтой амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд оршино.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн сумын соёлын төвд морин хуурчны иж бүрэн хувцас, бүжгийн хамтлагийн малгай, хувцас, гутал, хантааз, ардын дуучны эрэгтэй, эмэгтэй иж бүрэн хувцас, хөгжимчний иж бүрэн хувцас зэрэг 26 нэр төрлийн 190 хувцас, хувцасны шүүгээ нийлүүлсэн.



ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Урлаг уран сайхны иж бүрэн хувцсаар хангагдсан.
- ✓ Хүрмэн сумын Соёл, спортын төв нь хил залгаа сум, 3 багийн малчид, ард иргэдэд соёл урлагийн явуулын үйл ажиллагааг хүртээмжтэй, чанартай хүргэх боломж бүрдсэн.
- ✓ Сум орон нутгийн урлаг, соёлын хүмүүжлийн ажлын цар хүрээ, чанар дээшлэхэд дэмжлэг болсон.
- ✓ Хэрэгцээтэй хувцас хэрэглэлтэй болсноор залуучуудын хэрэгцээ шаардлагыг хангасан үйл ажиллагаа зохион байгуулж тэдний оролцоог дэмжихэд дөхөмжэй болсон.



Хөгжмийн багш Н.Баянхүү:

Хувцас хадгалах шкаф миний хувьд хамгийн ихээр таалагдаж байна. Урлагийн иж бүрэн хувцастай болж байгаа явдал урлаг уран сайхны үйл ажиллагаа чанарын өндөр түвшинд хүргэж ажиллах эрч хүч, урам зоригтой болж байгаадаа сэтгэл хангалуун сайхан байна.



Соёлын төвийн ажилтан С.Дулмаа:

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн төслөөр хийгдсэн урлагийн хувцас, хувцас хадгалах шкаф надад маш их таалагдаж байна. Ийм сайхан урлагийн хувцастай болж байгаа ирэх онд болох ЕБС-ийн ой, сумын 100 жилийн ойн арга хэмжээг угтаж хийгдсэн маш том хөрөнгө оруулалт боллоо гэж талархаж байна.

Бүжгийн багш О.Мөнхэрдэнэ:

Ийм сайхан урлагийн хувцас, шкафтай болсон явдалд миний хувьд маш сайхан байна. Урлаг соёлын ямар ч арга хэмжээ болоход нүүр бардам иж бүрэн хувцас хэрэглэлээр хангагдаж цаашид ажиллах урамтай байх болсонд баяртай байна.



▶ 4. “ДОТУУР БАЙР-БИДНИЙ АЮУЛГҮЙ ХӨГЖЛИЙН ОРЧИН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ
ХҮРМЭН СУМЫН ИРГЭН Ц.СҮНЖИДМАА
20,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургууль 150 сурагчтай. Үүнээс 50 сурагч дотуур байранд амьдардаг. 2020 онд шинэ дотуур байр ашиглалтанд орж хүүхдүүдийн сурч, амьдрах тав тухтай боломжийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бүрдүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар байрны гадна талбай хашаажуулалт байхгүйгээс сурагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, тоглож наадах эрх зөрчигдөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, мөн бага насны хүүхдүүдэд тохирсон тоглоом байхгүй зэрэг асуудал байрны хүүхдүүдийн өмнө тулгарч байна. Сургуулийн дотуур байранд хүүхэд хөгжүүлэх тоглоом, наадгайн зардал улсын төсөвт тусгайлан тусгагддаггүй юм.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Дотуур байрны гадна болон дотоод иж бүрэн тохижилтыг хүүхдийн нас сэтгэхүй, бие бялдарт зохицсон байдлаар тохижуулж сурагчдын эрүүл аюулгүй орчинд суралцах, хөгжих боломж бүрдүүлж багш-сурагч-эцэг эхийн гуравласан холбоо нэмэгдэж малчид тав тухтай орчинд хүүхдүүдээ сургах, улмаар сумандаа сайхан амьдрах орчин бүрдэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны гадна талбайг тойруулан 1.5 метр өндөртэй, 190метр хашаа суурилуулсан. Мөн хашаан дотор хүүхдүүд амарч тухлах, салхилах зориулалт бүхий модон саравч байрлуулсан. Дотуур байранд хүүхдүүдэд зориулсан хүүхэд хөгжлийн өрөөг тусгайлан зассан ба уг өрөөнд хөгжмийн зэмсэг, одон бөмбөгний ширээ байрлуулж, бага ангийн хүүхдүүдэд зориулсан тоглоомын хэсгийг тохижуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлсэн.
- ✓ Хамран сургах тойргийн сурагчдын дотуур байранд амьдрах хүүхдийн тоо нэмэгдэнэ.
- ✓ Сурагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж, өөрсдийгөө хөгжүүлж байна.
- ✓ Дотуур байрны гадна хашаатай болсноор эзэмшил газрын 25 хувиас багагүй хэсгийг ногоон байгууламжтай болгохоор ажиллаж байна.



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

► 5. “ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ
ХҮРМЭН СУМЫН ИРГЭН Б.БАЯРАА
6,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүрмэн сумын 18-р цэцэрлэг 1964 онд байгуулагдсан бөгөөд 2010 онд өөрийн эзэмшлийн 100 хүүхдийн цэцэрлэгийн шинэ байртай болж, хүүхдийн сурч хөгжих таатай орчин бүрдэж, жил бүр хамран сургах тойргийн 2-5 насны нийт 75 хүүхэд 3 бүлэгт өдрөөр хамрагддаг. 18-р цэцэрлэг нь Өмнөговь аймгийн “Хүүхдэд ээлтэй байгууллага”-аар 2 жил дараалан шалгарч байсан. 2010 оноос 10 жилийн хугацаанд хүүхдийн зөөлөн эдлэлийг шинэчилж солиогүй, эдэлгээний хугацаа дуусч, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсноор халдварт болон халдварт бус өвчин гарах магадлалтай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Цэцэрлэгт хамрагддаг хүүхдүүдийн хэрэглэдэг хуучирсан зөөлөн эдлэлийг сольж, шинэ зөөлөн эдлэлтэй болох, ингэснээр хүүхдэд аюулгүй орчинг бүрдүүлэх юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн сумын сургуулийн өмнөх боловсролын 18 дугаар цэцэрлэгт хүүхдүүдийн ашиглах зөөлөн эдлэл болох хөнжил, гудас тус бүр 75 ширхэгийг нийлүүлсэн.




ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлсэн.
- ✓ Эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэрхэн дулаан зөөлөн эдлэлд амрах нөхцөл боломжоор хангасан.
- ✓ Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ цэцэрлэгт явуулах итгэлтэй болно.
- ✓ Багш, туслах ажилтнуудын ажлын ачаалал буурна.

Эцэг эхийн төлөөлөл Б.Цэцэгээ:

Төслөөр нийлүүлэгдсэн хүүхдийн хөнжил гудас нь эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан хөнжил нь цэвэр даавуун гадартай, гудас нь монгол бор эсгийгээр хийгдсэн байна. Хүүхдийн маань эрүүл аюулгүй сурч хөгжих таатай орчин бүрдсэн байна.



Эцэг эхийн төлөөлөл Е.Тунгалагтамир:

Хуучин хөнжил гудас нь урагдаж хуучирсан стандарт эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон байсан. Одоо энэ төслөөр нийлүүлэгдсэн хөнжил цэвэр даавуун гадартай, гудас нь бор эсгийгээр хийгдсэн хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан зөөлөн эдлэлтэй болсонд талархаж байна.

6. “НОГООН ХҮРМЭН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

ХҮРМЭН СУМЫН ИРГЭН Г.ОЮУНЦЭЦЭГ

1,500,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сумын төвд байх ашиглалтгүй байгаа нийтийн эзэмшлийн газарт сумын төвийн ахмад настнууд төрөл бүрийн мод, бут тарьж ургуулан ногоон байгууламж бий болгож байна. Ингэснээр сумын төвд эко орчин бүрдүүлэх, ахмадын өргөөний талбай гэлтгүй хажуу зэргэлдээ хашаанд өмнө нь тарьсан болон шинээр суулгасан модыг усалж тордон ургуулах, цаашлаад сумын төвийн иргэдийн амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын төвийн болон харьяа албан газруудын хөгжил дэвшил, өнгө үзэмж сайжрах, ард иргэд, ажилтан албан хаагчдын амьдрах, ажиллах орчин нөхцөлд байгаль орчны таатай нөхцөл бий болгох, сум орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах гэсэн ахмад буурлуудын ногоон байгууламж арчлах хөдөлмөрийг хөнгөлөх зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн сумын ахмадын өргөөний гаднах ногоон байгууламж, цэцэрлэгийг услах усалгааны систем суурилуулсан.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг тордож байна.
- ✓ Ахмад настнууд өөрсдийн тарьж ургуулсан модоо арчлах усалгааны системтэй болсон.
- ✓ Ногоон байгууламжийг услах, арчлах хөдөлмөрийг хөнгөвчилж өгсөн.
- ✓ Сумын төвийн болон харьяа албан байгууллагуудын өнгө үзэмж сайжирсан.

7. “АНАЛИЗАТОР НИЙЛҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:
ГҮЙЦЭТГЭГЧ:
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН СУМЫН ЗДТГ
НУГАН ХХК
16,000,000 ТӨГРӨГ

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүрмэн сумын эрүүл мэндийн төв нь 1938 онд байгуулсагдсан ба нийт 18 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сумын нийт хүн амд эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, лабораторийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай хүргэж ажиллах зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг ба жилд дунджаар давхардсан тоогоор 5300 иргэнд үйлчилгээ үзүүлдэг. Эрүүл мэндийн лабораторийн тусламж үйлчилгээ эрүүл мэндийн системийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Өвчлөлийн хяналт оношилгоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ болон эрүүл мэндэд чиглэсэн бүхий л үйл ажиллагааны үр дүн болон үр ашиг нь тэдгээрт чиглэсэн лабораторийн найдвартай тусламж үйлчилгээнээс хамаардаг.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Элэг бүтэн Монгол, Элэг бүтэн Өмнөговь хөтөлбөр хэрэгжиж үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн шинжилгээний хариуг цахимаар тайлагнах, хариуг хэвлэж олгох зэрэг ажлыг хийж байна. Суманд жилдээ дунджаар 991 иргэн шээсний ерөнхий болон бусад шинжилгээнд хамрагдаж байна. Гематологийн анализатор байхгүй улмаас зөвхөн цусны ерөнхий шинжилгээ өгөхийн тулд 2 дугаар шатлалын эмнэлэг рүү явж цаг алдах, аймгийн төв орж шинжилгээ өгч ирэх зэргээр эдийн засагт хүндрэл учирч байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Эрүүл мэндийн төвийг лабораторийн тоног төхөөрөмжөөр хангаснаар иргэдэд үзүүлж байгаа оношилгоо, шинжилгээний чанар сайжирч Элэг бүтэн Монгол, Элэг бүтэн Өмнөговь хөтөлбөр, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хүрмэн сумын эрүүл мэндийн төвд цусны гематологийн анализатор, түүнд ашиглах урвалж эм бодисыг нийлүүлж, суурилуулж өгсөн. Уг төхөөрөмж нь цагт 60 тестийг шинжлэх хүчин чадалтай юм.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- ✓ Сум орон нутагтаа цусны дэлгэрэнгүй шинжилгээг авдаг болсон.
- ✓ Сумын хэмжээнд шинжилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо нэмэгдсэн.
- ✓ Элэг бүтэн Өмнөговь хөтөлбөрийн хамрагдалт өссөн.
- ✓ Мобайл технологийн тусламж үйлчилгээнд хамруулсан иргэдийн тоо нэмэгдсэн.

ЭМТ-ийн дүн бүртгэгч Д.Ичинхорлоо:

Бид сумандаа цусны шинжилгээний анализатортай боллоо. Ингэснээрээ сумын нийт хүн амд эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, лабораторийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэж ажиллах боломжтой боллоо. Өвчлөлийн хяналт оношилгоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ болон эрүүл мэндэд чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд үр дүн гарах боломжтой болсон. Гематологийн анализатортой болсоноор тусламж үйлчилгээнд ахиц гарч оношилгоо эмчилгээний чадвахи сайжирч, иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж 2-р шатлалд илгээх өвчтөний тоо багасна. Мөн алслагдсан баг болон хилийн заставын иргэдэд үзлэг шинжилгээ хийж, өвчин эмгэгийг цаг алдалгүй эрт илрүүлж, малчид иргэдийн хувьд цаг хугацаа, эдийн засагт хэмнэлт гарна.



Хүрмэн багийн иргэн С.Оюунсүрэн:




Манай суманд цусны шинжилгээний аппараттай болж явдал чирэгдэлгүй болгож өгсөнд талархал илэрхийлье.

Хүрмэн багийн өндөр настан С.Пүрэв:

Миний бие тус эрүүл мэндийн төвөөр байнга үйлчлүүлж, хяналтанд байдаг. Гэнэт бие өвдөж эмнэлэгт ирэхэд маш түргэн шуурхай үйлчилж, оношилж өгсөнд талархаж байна. Манай сум шинжилгээний аппараттай болсон юм байна. Маш баяртай байна. Бүгдэд нь ажлын амжилт хүсье.

САНГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

№	Ил тод байдлыг хангах ажил	Тайлбар	Холбогдох зураг
1	Сангийн цахим хуудсанд тогтмол мэдээлэл байршуулж байна	www.goviinoyu.mn	
2	“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Фэйсбүүк пэйжээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн	92 удаагийн постоор давхардсан тоогоор 193,989 хүнд хүрч ажилласан	
3	Орон нутгийн болон үндэсний сонинд Сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл нийтэлж байна	Төслийн нээлт, хүлээлгэн өгөх ёслол, хаалтын үйл ажиллагаа, Сангийн үйл ажиллагааны тухай гэх мэт мэдээлэл сонинд нийтлүүлж байна	
4	Жил бүр хөндлөнгийн аудитын үйлчилгээ авч байна	Далайван аудит	

5	Даланзадгад сумын төвийн зарын самбарууд дээр Сангийн тухай мэдээлэл байршуулж байна	Санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр, тэтгэлэг, Сангийн үйл явцын мэдээлэл, хөрөнгө оруулалтын тухай мэдээлэл	
6	Хөрөнгө оруулагч “Оюу толгой” ХХК, Хамтын ажиллагааны гэрээний талууд болох Өмнөговь аймгийн ЗДТГ, Ханбогд сумын ЗДТГ-тай албан тоот, имэйл, уулзалт зохион байгуулж мэдээлэл солилцож байна	Сангийн санхүүжилтийн хуваарилалт, батлагдсан төсөл, үйл явцын мэдээ, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт	
7	Жил бүрийн үйл ажиллагааны тайланг товхимол байдлаар 3000 хувь хэвлүүлэн олон нийтэд тайлагнаж байна		



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



САНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- ✓ Сангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг 2018 оны 03 сарын 15-ны өдөр Удирдах зөвлөлөөс баталсан бөгөөд Сан нь уг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.
- ✓ Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын зорилго нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Санхүүжилтийн удирдамж, Сангийн дүрэм болон Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ХДС-аас санхүүжилтийн дэмжлэг олгохоор батлагдсан төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, санаачлан удирдагч, хэрэгжүүлэгч, холбогдох орон нутгийн төр захиргааны байгууллагууд болон төслийн үр шим хүртэгчдийн зүгээс төсөл хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шалгараагүй болон хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөрийн хаалт, төсөл хөтөлбөрт эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршиж байна.
- ✓ Сангийн хяналт-шинжилгээ үнэлгээний ажилд дараах оролцогч талууд оролцоно.
 - Хөрөнгө оруулагч - “Оюу толгой” ХХК
 - Санхүүжүүлэгч байгууллага - “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”
 - Захиалагч - Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж хэрэгжиж дууссанаас хойш үйл ажиллагааг авч явах /хариуцах иргэн/ байгууллага
 - Гүйцэтгэгч/Хэрэгжүүлэгч - Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байгаа иргэн/ байгууллага
 - Шууд болон шууд бус үр шим хүртэгч - Өмнөговь аймгийн иргэд/байгууллага
 - Үнэлгээний байгууллага/хувь хүн- Бие даасан үнэлгээ, судалгааны байгууллага/хувь хүн

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ АРХИВТ БҮРТГЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

№	Төсөл хөтөлбөрийн нэр	№	Төсөл хөтөлбөрийн нэр
1	Шүдний кабинет	12	Соёл спорт хөгжил
2	Шилмэл сүрэг	13	Ном бол ертөнцийг харах цонх
3	Бэлчээр эрдэнэ	14	Зөв дадал
4	Оюу хүлэмж-2	15	Ёс заншлын өргөө байгуулах
5	Өвс тэжээлийн агуулах	16	Эрүүл хүүхэд
6	Ботгон тэшээ	17	Цэвэр агаар
7	Цамын хувцас	18	Эрүүл мал-Эрүүл хүнс
8	Хүлэмжийн аж ахуйн цогцолбор	19	Таван эрдэнэ
9	Аюулгүй хашаа	20	Ногоон төгөл
10	Ахмад настанд ээлтэй орчин	21	Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ
11	Халуун ус		

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ

Сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хүлээн авахаас эхлэн хаах хүртэлх бүх үе шатанд хяналт тавьж захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч болон үр шим хүртэгчтэй харилцаа холбоотой хамтран ажиллаж байна.

ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ

1-р үе шат-Санал хүлээн авах

- Төсөл санаачлагч төслийн ерөнхий мэдээлэл, хүрээ болон бусад материалыг тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөтэй хамт Санд ирүүлдэг
- Төслийг цаашид авч явах Захиалагч үйл ажиллагааны зардлаа тодорхой болгодог

2-р үе шат-Үнэлэх, батлах

- Сан, Харилцааны хороо, Удирдах зөвлөл төслийн материалыг хянаж үзэн Сангийн бичиг баримтууд, Хамтын ажиллагааны гэрээ болон аймаг сумдын төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхэд үнэлгээ өгнө
- Барилга байгууламж барих төсөл дээр Захиалагч нь цаашид авч явах төсөвтэй эсэхийг нягтална

3-р үе шат-Гэрээ байгуулах

- Төсөл хэрэгжүүлэхэд оролцож байгаа оролцогч талууд гэрээний эрх, үүрэг хариуцлагаа ухамсарлан хүлээн зөвшөөрч байгаа эсэхэд хяналт тавина
- Гэрээгээр биелүүлэх ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт, хяналтын тогтолцоог талууд бүрэн хүлээн зөвшөөрч байгаа эсэхэд хяналт тавина

4-р үе шат- Хэрэгжилт

- Гэрээгээр биелүүлэх ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтэнд тулгуурлан ХДС, Зохиогч, Захиалагч, болон ОТ ХХК-иас хяналт тавина

5-р үе шат- Хэрэгжүүлж дуусгах, хүлээлгэн өгөх

- Хүлээн авч комиссын акт үйлдэх
- Улс, орон нутгийн өмчид бүртгэх
- Захиалагч үйл ажиллагааг авч явах баг бүрдүүлэх- ажилчин, албан хаагчдыг ажилд авах
- Захиалагч үйл ажиллагааны зардлыг хариуцан авч явах
- Захиалагч гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээг хүлээн авч тогтвортой байдлыг хангана

6-р үе шат-Хүлээлгэн өгсний дараа

- Тогтвортой байдлыг хангах, судалгаа явуулах
- ОТ ХХК, ХДС, хөндлөнгийн судалгааны байгууллага, хувь хүнээр үнэлгээ хийлгэж зөвлөмж авах



НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Ашиглалттай холбоотой мэдээлэл

- ✓ 2015-2020 оны хооронд 41.3 тэрбум төгрөгийн төсөв бүхий 50 нийгмийн дэд бүтцийн шинж чанартай төсөл хэрэгжүүлж байна.
- ✓ 4 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тендерийн шатнаас эхлээд 90 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй байна.
 - Өмнөговь аймгийн музейн барилга
 - Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургууль
 - Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэг
 - Гашуунсухайт боомтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр

Иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах тухайд

- ✓ Урьд нь байсан нөөц бололцоо, багтаамжийг нэмэгдүүлсэн- 10 төсөл
 - 2017 онд Ханбогд болон Манлай сумын халаалтыг 140%-иар нэмэгдүүлсэн
 - 2017 онд Даланзадгад сумын 11-р цэцэрлэгийг өргөтгөж нэмэлтээр 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барьсан
 - 2019 онд Баян-Овоо суманд уурын зуухыг шинээр барьж ашиглалтанд оруулснаар хүчин чадал 3 дахин өсч, одоогийн байдлаар хэрэглэгчдийн тоо 24%-иар өссөн
 - Малын эрүүл мэндийн цогц үйлчилгээг нэвтрүүлсэн
 - 2020 онд Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга барьж байна
 - 2020 онд Даланзадгад сумын төвөөс зайтай гэр хороололд 200 хүүхдийн цэцэрлэг барихаар санхүүжүүлсэн
- ✓ Иргэдэд үзүүлэх шинэ, сайжруулсан үйлчилгээг нэвтрүүлсэн -6 төсөл
 - 2017 онд Гашуунсухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж, Нийтийн тээврийн үйлчилгээ, Ханбогд сумын сургуулийн нийтийн ариун цэврийн барилгыг барьж ашиглалтанд оруулж, Гашуунсухайт боомт орчмын хүмүүсийг шүүж цэвэршүүлсэн усны нөөцтэй болгож, Ханбогд, Манлай сумдыг хоногийн 24 цаг дулаан байж болохуйц халаалттай болгон, Даланзадгад сумын иргэдийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ сайжирсан.
 - 2018 онд Ханбогд суманд Сум дундын малын эрүүл мэндийн төвийг барьж ашиглалтанд оруулж, малын эмч нарыг бэлтгэж байгаа бөгөөд Даланзадгад сумын төвийн хэсэгт ус зайлуулах шугам тавьсан.
 - 2019 онд Өмнөговь аймагт махны үйлдвэрийн барилга барьж, чанартай мах, махан бүтээгдэхүүнээр Өмнөговь аймгийн иргэдийн хүнсний хангамж чанар сайжирсан
 - 2020 онд Гашуунсухайт боомтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр барих ажил санхүүжүүлэхээр баталсан

Асуудал/Зөвлөмж

- ✓ Барилгын ажил гүйцэтгэх хугацааг тооцож, тендерийг төлөвлөж шуурхай зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж шийдвэрлэж байх.
- ✓ Зураг төслийн гүйцэтгэлийн чанарт анхаарах, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах

N	Төслийн нэр	Ерөнхий мэдээлэл					ОТ-и хөрөнгө оруулалт		Ашиглалтын үзүүлэлт				Биелэлтийг хэмжих үзүүлэлт				
		Ашиглалтанд орсон огноо	Ашиглагч	Захиалагч	Байгууллагын төрөл	Төсөв	Эх үүсвэр	Санхүүжилт (₮)	Даац багтаамж	2019 оны байдлаарх ашиглалт	Хувь	Асуудал	Үзүүлэлт	Төлөөс өмнөх үзүүлэлт	2020 оны үзүүлэлт	Өөрчлөлт	Бий болсон/болох ажлын байр
1	ДЗ 25-р цэцэрлэг	2016	ДЗ 25-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1,8 тэрбум	200	327	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	327	+59%	31
2	ДЗ 26-р цэцэрлэг	2016	ДЗ 26-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	2,2 тэрбум	200	288	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	288	+35%	34
3	БО ЭМТ	2017	БО эрүүл мэндийн төв	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	1,1 тэрбум	10 ортой	15 ортой	100%	байхгүй	Эмчлүүлж буй өвчтний орны тоо	10	15	+50%	
4	ДЗ 2-р сургуулийн заал	2017	ДЗ 2-р сургууль	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	796,9 сая	768	830	100%	байхгүй	Байгууламжийг ашиглаж байгаа хүүхдийн тоо	0	830	+8%	-
5	Манлай сумын уурын зуух (3.2 МВатт)	2017	Манлай сумын уурын зуух	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	929,1 сая	3.2МВ (2 зуух тус бүр 1.6МВ)	3.2мв (2 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	5 барилга	29628м2 5 барилга, 67 өрх	+100%	8
6	Ханбогд сумын уурын зуух (1.8 МВатт)	2017	Хандизель ХХК	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС, Сумын ЗДТГ	365,7 сая	5МВ (3 зуух тус бүр 1.8МВ)	1.8мв (1 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	6 барилга (38000м3)	10 барилга	+40%	6
7	ХБ сумын сургуулийн бие засах газар	2017	ХБ сумын сургууль	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС	39,6 сая	9 тасалгаатай	9 тасалгаатай	100%	байхгүй	Бие засах газрын тасалгааны тоо	0	9	+7%	-
8	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолбор	2018	Ханбогд сумын сургууль, цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	7,2 тэрбум	360 сурагч 300 хүүхэд	1070 сурагч	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	660	1070	+127%	92
9	Сум дундын малын эрүүл мэндийн төв	2018	Мал аж ахуй хариуцсан нэгж	Улсын	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1,4 тэрбум	4 тасагтай, бүрэн тоноглогдсон малын ЭМТ		100%	байхгүй	Үйлчилгээ үзүүлж буй тасгийн тоо	0	4	+100%	5
10	ДЗ эко автобус	2018	ДЗ захирагчийн алба	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС, Аймгийн ЗДТГ	396 сая	80 суудалтай (8 автобусанд тус бүр 10 хүн зорчино)	60 хүн 6 автобусанд тус бүр 10 хүн зорчиж байна	75%	Засвар үйлчилгээ хийж байна	Эко автобусны тоо	0	8	+100%	15
11	ДЗ сумын төвийн ус зайлуулах шугам	2018	ӨМ ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС, ӨМ ЗДТГ	2,7 тэрбум	Даланзадгад сумын төвд 6.5 км ус зайлуулах шугам татсан		100%	байхгүй	Ус зайлуулах шугамны урт	0	6,5 км	+100%	-
12	ДЗ 11-р цэцэрлэгийн өргөтгөл	2018	ДЗ сумын 11-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1,4 тэрбум	100		100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	273	+100%	7
13	Гашуун сухайт боомтын ундны ус цэвэршүүлэх байгууламж	2018	Гашуунсу-хайт боомт	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	109,9 сая	3 шүүлтүүр		100%	байхгүй	Цагт шүүх усны хэмжээ	0	2тн/цаг	+100%	1
14	Мах жижиглэн ангилах, хиамны үйлдвэр	2019	Гүүд Рүүт Итер Трейдинг	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүжнэ	ХДС, Гүүд Рүүт Итер Трейдинг	4,8 тэрбум	3000м 2-2 давхар үйлдвэрийн барилга, 400 тонн мах хадгалах агуулах		100%	байхгүй	Мах боловсруулах, хадгалах хэмжээ	0	400тн	+100%	25



15	Жаргалтай хүүхдүүд	2018	Ханбогд сумын цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	14.5 сая	24 хүүхдийн 2 анги	2 анги нээсэн	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	24	20%	5
16	Усан халаагуурын тоого, тоног төхөөрөмж	2018	Баяндалай сумын уурын зуух	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС, Орон нутаг	ХДС 69.4 сая	1400 кВ хүчин чадалтай 1 зуух	1 зуух	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	5 байгуулага, 23 айл өрх	5 байгуулага, 23 айл өрх		
17	Эко автобусны цахим систем	2018	Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС		1500 ш карт, карт уншигч	1500 ш карт, карт уншигч	100%	байхгүй	Цахим картны тоо	0	1500	+100%	
18	Халуун ус	2018	Манлай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	29.8 сая	Халуун усны газар		100%	байхгүй	Халуун усны ерөөний тоо	0	1	+100%	
19	Соёл, спортын хөгжил	2018	Манлай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	58.6 сая	Орчин нөхцөл сайжруулсан		100%	байхгүй	Ашиглалт сайжирсан			+100%	
20	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2018	Номгон ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	56 сая	Олон нийтийн амралт, зугаалгын газар		100%	байхгүй	Амьдрах орчин нөхцөл сайжирсан			+100%	
21	Баян-Овоо сумын уурын зуух (2 МВатт)	2019	7 шар цаг ОНӨТҮГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	901.8 сая	4МВ (2 зуух тус бүр 2МВ)	2мв (2 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	29 айл өрх, 12 байгуулага	36 айл өрх, 12 байгуулага,		+17%
22	Манлай сумын цэцэрлэг, тоног төхөөрөмж	2019	Манлай сумын цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1,7 тэрбум	100 хүүхдийн цэцэрлэг	100 хүүхдийн цэцэрлэг	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	100	+100%	13
23	Баяндалай гэрэлтүүлгийн ажил	2019	Баяндалай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	52.9 сая	60 ш гудамжны гэрэлтүүлэг, 5 ш цамхагт гэрэлтүүлэг		100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	65	+100%	
24	Гэрлэн дохио	2019	Даланзадгад ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	70 сая	Уулзварын 4 ш гэрлэн дохио		100%	байхгүй	Суурилуулсан гэрлэн дохионы тоо	0	4	+100%	
25	Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв	2019	Мандал-Овоо эмнэлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.2 тэрбум	10 ортой эрүүл мэндийн төвийн барилга		100%	байхгүй	ЭМТ-ийн орны тоо	0	10	100%	
26	Ханбогд сумын өвс тэжээлийн агуулах	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	370.1 сая	Өвс тэжээл агуулах байр		100%	байхгүй	Өвс тэжээл хадгалах хэмжээ	0	7500м3	100%	
27	Ханбогд сумын цахилгаан шугамын өргөтгөл	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	50 сая	Цахилгааны шугам татсан		100%	байхгүй	Дулаанд холбогдсон айлын тоо	0	278 иргэн	100%	
28	Ханбогд сумын хог хаягдлын менежмент	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	591.4 сая	Хог хаягдал булшлах байгууламж		100%	байхгүй	Хаягдал буулгах сан	0	21,120 м3	100%	
29	Ханбогд сумын үерийн далан, суваг	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.3 тэрбум	Үерийн далан, сувгийн ажил		100%	байхгүй	Үерийн далангийн урт	0	1.5 км	100%	
30	Хөрс эрдэнэ	2018	Баян-Овоо сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	104.5 сая	Цахилгааны шугам татсан		100%	байхгүй	Цахилгааны шугам	0	3.2 км	100%	
31	Номгон гэрэлтүүлэг	2019	Номгон сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	30 сая	6 ш цамхагт гэрэлтүүлэг		100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	6	100%	
32	Нэгдсэн гудамжны гэрэлтүүлэг	2020	Булган сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	39.5 сая	Гудамжны гэрэлтүүлэг		100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	13	100%	
33	Амгалан орчин	2020	Баяндалай сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	38.2 сая	Цахилгааны шугам татсан		100%	байхгүй	10кв цахилгаан шугам	0	620 м	100%	

ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТОМООХОН ХӨТӨЛБӨРҮҮД

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Хүрэх үр дүн	Хөтөлбөрийн явц	Хяналт шинжилгээ үнэлгээ
1	Оюу хүлэмж	2016-2026 оны хооронд Өмнөговь аймгийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр хүлэмж олгох	2016-2020 оны хооронд хүлэмж хөнгөлөлттэй үнээр өгсөн	4 удаагийн хяналт, үнэлгээ хийсэн
2	Чадварлаг эмч	БОЭТ-д 32 ширхэг хяналтын камер суурилуулж мэс засал, гэмтлийн тасаг, цусны амбулаторийн хэсгийн тохижилтын ажил, нярайн тасагт тоног төхөөрөмж суурилуулж Дорноговь аймгийн эмч нараас туршлага судлах ажил явуулж 332 эмч мэргэжилтнүүдэд сургалт явуулах	Гэрээний дагуу ажлаа хийж байна.	3 удаагийн хяналт, үнэлгээний ажил хийсэн
3	Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	4 жилийн хугацаанд 6 зорилтын хүрээнд Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ	2020 оны ажлыг гүйцэтгэж ажлаа дүгнэж байна	2-р үе шатны хяналт хийж байна.
4	Үндэсний өв соёл, мэдлэг ухааныг хүүхэд залууст өвлүүлэн үлдээх сургалт	Ханбогд сумын ахмадууд тус сумын 6-9-р ангийн давхардсан тоогоор 2606 хүүхдэд өв соёлын талаар сургалт явуулах	Гүйцэтгэл 90%-тай байна	2-р үе шатны хяналт хийсэн
5	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Зорилтот сумдын үл хөдлөх 42 дурсгалт газрыг хамгаалалтанд авч хаягжуулан гэрээт хамгаалагчдыг үнэмлэхжүүлэх ажил хийх	Сүүлийн үе шатны ажил хийж байгаа	Үе шат болгонд хяналт хийсэн
6	Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр	Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих төвтэй болж сургалт явуулах	Жижиг дунд бизнесийг дэмжих төв байгуулах ажил хийж байна	2020 оны үйл ажиллагаанд хяналт хийсэн
7	Батмөнх Даян хааныг алдаршуулах-Магтаал	Батмөнх Даян хааны үеийн Монголыг магтан дуулсан 5 минутын клип хийнэ	Гүйцэтгэл 70%-тай байна	1-р үе шатны хяналт хийсэн
8	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат, хөрөг нэвтрүүлэг	20-30 минутын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат, хөрөг нэвтрүүлэг хийж олны хүртээл болгоно	Гүйцэтгэл 50%-тай байна	1-р үе шатны хяналт хийсэн
9	Дизайн технологийн кабинетийн тохижилт	Манлай сумын сургуульд дизайн технологийн кабинет байгуулж 36 төрлийн 270 багаж хэрэгсэл нийлүүлнэ	Баталгааны хугацаанд байна	1-р үе шатны хяналт хийсэн



ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД - 2020

№	Харилцагч байгууллагын нэр	Холбоо хамаарал
1	Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал
2	Ханбогд сумын Засаг даргын тамгын газар	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал, түншлэгч сум
3	“Оюу толгой” компани	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал, хөрөнгө оруулагч байгууллага
4	Даланзадгад сумын Засаг даргын тамгын газар	Даланзадгад суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
5	Манлай сумын Засаг даргын тамгын газар	Манлай суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
6	Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Баян-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
7	Баяндалай сумын Засаг даргын тамгын газар	Баяндалай суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
8	Сэврэй сумын Засаг даргын тамгын газар	Сэврэй суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
9	Номгон сумын Засаг даргын тамгын газар	Номгон суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
10	Булган сумын Засаг даргын тамгын газар	Булган суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
11	Цогт-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Цогт-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
12	Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Мандал-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
13	Хүрмэнд сумын Засаг даргын тамгын газар	Хүрмэн суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
14	Т.Энхтуул	“Шинэ сургууль, шинэ орчин, шинэ санаачилга” төслийг хэрэгжүүлэгч
15	Э.Мөнхсоёл	“Зан үйлийн өргөө” төслийг хэрэгжүүлэгч
16	Д.Отгончулуу	“Эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлт” төслийг хэрэгжүүлэгч
17	Н.Пунцагболд	“Дулаан байр тухтай орчин” төслийг хэрэгжүүлэгч
18	М.Мөнх-Од	“Цэвэр орчин цэмцгэр байгууллага” төслийг хэрэгжүүлэгч
19	Ц.Сайнзаяа	“Насан туршийн боловсрол Насан туршийн баталгаа” төслийг хэрэгжүүлэгч
20	О.Өрнөх	“Англи хэлтэй Сэврэйн багачууд” төслийг хэрэгжүүлэгч
21	Нүдэн булагийн өгөөж	“Ёслол хүндэтгэлийн өргөө” төслийг хэрэгжүүлэгч
22	Ч.Наранцэцэг	“Багийн хөгжлөөс сумын хөгжил” төслийг хэрэгжүүлэгч
23	Ургац капитал ХХК	“Түргэн тусламжийн автомашин нийлүүлэх” төслийг хэрэгжүүлэгч

24	Говийн дөрвөн хайрхан ХХК	“Аюулгүй орчин-Амьдралын баталгаа” төслийг хэрэгжүүлэгч
25	Ш.Гэрэлмаа	“Монтессорын сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан хөгжүүлэх арга зүй хөтөлбөр” төслийг хэрэгжүүлэгч
26	А.Жамъяндэлгэр	“Шинэ зууны хот соёлтой иргэн” төслийг хэрэгжүүлэгч
27	Сэврэй бэлчээр ашиглагчдын холбоо ТББ	“Сэврэй сумын бэлчээр усжуулалтын ажил” төслийг хэрэгжүүлэгч
28	Цамхагт өргөө ХХК	“Усан спортоор хичээллэж биеэ чийрэгжүүлье” төслийг хэрэгжүүлэгч
29	Хүннүгийн говь ХХК	“Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга” төслийн Гүйцэтгэгч
30	Т.Ууганбаяр	“Эрүүл бие-Амжилтын үндэс” төслийг хэрэгжүүлэгч
31	Ч.Дүүрэнжаргал	“Эрүүл хүнс-Эрүүл бие” төслийг хэрэгжүүлэгч
32	Н.Тайван-Ертөнц	“Ультмах” төслийг хэрэгжүүлэгч
33	А.Байгальхүү	“Тоглоом-Хүүхдийн хөгжил” төслийг хэрэгжүүлэгч
34	А.Ганцэцэг	“Цаг уурын мэдээг цагт нь” төслийг хэрэгжүүлэгч
35	Эрхэт рай ХХК	“Иргэнээ дээдэлсэн ээлтэй үйлчилгээ” төслийг хэрэгжүүлэгч
36	Ч.Эрдэнэтогтох	“Өнөд дээдлэх өв соёл” төслийг хэрэгжүүлэгч
37	Ивээлт тал ХХК	“Өөдлөх айлын өнгө” төслийг хэрэгжүүлэгч
38	Товон Очир ХХК	“Хамтдаа сурч, хамтдаа хөгжье” төслийг хэрэгжүүлэгч
39	Ай ти Эс Өү ххк	“Амар тайван амьдралын орчин” төслийг хэрэгжүүлэгч
40	Б.Азбилэг	“Стандарт хаяг” төслийг хэрэгжүүлэгч
41	Д.Ганболд	“Сургуулийн хашаа” төслийг хэрэгжүүлэгч
42	Б.Алтантуяа	“Хүүхэд хөгжил” төслийг хэрэгжүүлэгч
43	Т.Мөнхзул	“Малын эмч нарын цахим систем” төслийг хэрэгжүүлэгч
44	Х.Бат-Эрдэнэ	“Тоглоомын талбай” төслийг хэрэгжүүлэгч
45	Хас бат мөнх ХХК	“Ногоон сургууль” төслийг хэрэгжүүлэгч
46	Балж хөмөлийн ундарга ХХК	“ЭМТ-ийн гал тогооны тоног төхөөрөмж” төслийг хэрэгжүүлэгч
47	Анхсан хоршоо	“Булган фитнес төхөөрөмж” төслийг хэрэгжүүлэгч
48	Ц.Батцэнгэл	“Дотуур байрны хүүхдийн ор” төслийг хэрэгжүүлэгч
49	Логмон ХХК	“Монгол бичгийн кабинет тохижуулах” төслийг хэрэгжүүлэгч
50	Алтанговийн ширээ хоршоо	“Арьс шир боловсруулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэгч
51	Нэмэхт суурь ХХК	“Шуудан үйлчилгээ” төслийг хэрэгжүүлэгч
52	Нэмэхт суурь ХХК	“Амжилт” төслийг хэрэгжүүлэгч
53	Монгол мэргэд ХХК	“Шинэ технологи, багшийн хөгжил, хүүхдийн хөгжил” төслийг хэрэгжүүлэгч
54	Ц.Мөнхчулуу	“Элбэг чацаргана” төслийг хэрэгжүүлэгч
55	Галбын говийн гэрэлт ирээдүй ТББ	“Хүүхдийн төлөө за гэж хэлцгээе” төслийг хэрэгжүүлэгч



56	М.Чүлтэмсүрэн	“Ханбогд хайрхан” төслийг хэрэгжүүлэгч
57	Д.Ганчимэг	“Тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн хөгжил” төслийг хэрэгжүүлэгч
58	Э.Ундрахнаран	“Тамхийг биш эрүүл мэндээ сонгоё” төслийг хэрэгжүүлэгч
59	Мед буян ХХК	“Шүдний кабинет” төслийг хэрэгжүүлэгч
60	Б.Төмөрбаатар	“Түүхэн замнал” төслийг хэрэгжүүлэгч
61	Хандизель ОНӨААТҮГ	“Ухаалаг худаг” төслийг хэрэгжүүлэгч
62	О.Төрболд	“Чавхдаст хөгжмөө тоглоё” төслийг хэрэгжүүлэгч
63	А.Цэцэг	“Мянган мод” төслийг хэрэгжүүлэгч
64	Б.Өлзийтогтох	“Тусгай ротын хүүхдийн талбай” төслийг хэрэгжүүлэгч
65	С.Батсайхан	“Хоггүй сум-Хүрмэн сум” төслийг хэрэгжүүлэгч
66	Б.Баяраа	“Зөөлөн эдлэл” төслийг хэрэгжүүлэгч
67	Ө.Хандсүрэн	“Хүрмэн гоёл” төслийг хэрэгжүүлэгч
68	Ц.Сүнжидмаа	“Дотуур байр - Бидний хөгжлийн орчин” төслийг хэрэгжүүлэгч
69	Г.Оюунцэцэг	“Ногоон Хүрмэн” төслийг хэрэгжүүлэгч
70	Ундрага Өмнөговь ХХК	“Соёлын төвийн дотор тохижилт” төслийг хэрэгжүүлэгч
71	Гал мөнх бахархал констракшн ХХК	“Ухаалаг худаг” төслийг хэрэгжүүлэгч
72	Нуган ХХК	“Эрүүл мэндийн төвийн анализатор нийлүүлэх хөтөлбөр” төслийг хэрэгжүүлэгч
73	Аз билэгтэй ХХК	“Эко орчинг хамтдаа бүтээцгээе” төслийг хэрэгжүүлэгч
74	Ч.Мөнхбазар	“Эрүүл хүнс хадгалалт” төслийг хэрэгжүүлэгч
75	Булган лус ХХК	“Дуу хөгжмийн кабинет” төслийг хэрэгжүүлэгч
76	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэгч байгууллага
77	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч байгууллага
78	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч байгууллага
79	Авсралийн засгийн газар	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч
80	Монгол улсын засгийн газар	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч
81	Жи Ай Зэт	“Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч
82	Далайван аудит ХХК	Аудитын үйлчилгээ
83	Сэтгэшгүй хойч ХХК	Хэвлэлийн үйлчилгээ
84	Өнөөдөр сонин	Зар мэдээ нийтлэлийн үйлчилгээ
85	Өдрийн сонин	Хэвлэлийн үйлчилгээ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

БАЛАНС

2020 оны 12-р сарын 31
(мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,378,787.70	7,004,135.74
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,130,315.87	1,559,255.96
Авлага	0.00	1.66
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,509,103.58	8,563,393.36
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	79,197.87	75,296.27
Үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	32,003.01	22,504.27
Биет бус хөрөнгө	1,790.00	0.00
Биет бус хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	1,326.55	0.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	47,658.31	52,792.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,556,761.88	8,616,185.35
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө		
Дансны өглөг	2,973,962.26	2,599,953.77
Цалингийн өглөг	0.00	0.72
Богино хугацаат өглөгийн дүн	2,973,962.26	2,599,953.77
Өр төлбөрийн нийт дүн	2,973,962.26	2,599,953.77
Хуримтлагдсан үр дүн	3,582,799.62	6,016,231.58
Цэвэр хөрөнгийн дүн	3,582,799.62	6,016,231.58
Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн	6,556,761.88	8,616,185.35



ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31
(мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Бэлэг, хандив, тусламжийн орлого	13,162,600.00	14,629,916.04
Бусад орлого	517,779.91	503,711.35
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	13,680,379.91	15,133,627.39
Үндсэн үйл ажиллагааны зардал		
Бэлэг, хандив ба тусламж	349,088.70	322,595.92
Байгууллагад өгсөн хандив, тусламж	349,088.70	322,595.92
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	155,557.77	138,650.02
Төсөл хэрэгжүүлсний зардал	9,637,287.45	11,639,467.33
Ерөнхий удирдлагын зардал	491,125.49	599,315.65
Цалин хөлс, шагнал	201,829.65	202,520.30
Нийгмийн даатгалын шимтгэл	25,131.91	25,406.24
Засвар үйлчилгээний зардал	1,952.79	439.50
Ашиглалтын зардал	13,839.59	24,973.04
Түрээсийн зардал	17,038.20	16,988.40
Албан томилолтын зардал	1,600.00	1,414.26
Тээврийн зардал	0.00	0.00
Элэгдлийн зардал	14,538.56	14,213.07
Зар сурталчилгааны зардал	106,167.25	218,813.76
Шуудан, холбооны зардал	4,260.81	5,357.93
Шатахууны зардал	10,883.91	6,023.55
Бусад зардал	93,882.83	83,165.60
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	10,633,059.40	12,700,028.92
Үндсэн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	3,047,320.51	2,433,598.46
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал	0.00	166.50
Бусад	0.00	166.50
Тайлант үеийн цэвэр үр дүн	3,047,320.51	2,433,431.96

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31
(мян. төгрөгөөр)

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	535,479.11	535,479.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
Залруулсан үлдэгдэл	535,479.11	535,479.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.	0.
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.	0.
Тайлант үеийн цэвэр үр дүн	3,047,320.51	3,047,320.51
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,582,799.62	3,582,799.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
Залруулсан үлдэгдэл	3,582,799.62	3,582,799.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.	0.
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.	0.
Тайлант үеийн цэвэр үр дүн	2,433,431.96	2,433,431.96
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,016,231.58	6,016,231.58

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31
(мян. төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үйл ажиллагааны мөнгөн орлого	14,446,439.86	14,761,955.70
Бэлэг, хандив, тусламж	13,162,600.00	14,616,773.75
Бусад	1,283,839.86	145,181.95
Үйл ажиллагааны мөнгөн зарлага (-)	15,576,008.17	13,193,741.03
Ажиллагчдад олгосон мөнгө	167,162.15	183,750.23
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	42,379.96	21,649.67
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	0.00	0.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	0.00	0.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	12,840.66	11,030.89
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	15,335,549.74	12,934,933.68
Төлсөн татвар	17,959.83	42,280.04
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	115.83	96.53
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-1,129,568.31	1,568,214.67
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	4,399.90	0.00
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	256,885.00	270,299.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-261,284.90	-270,299.00
Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүү ба урамшууллын орлого	391,384.35	327,432.36
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	391,384.35	327,432.36
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-999,468.86	1,625,348.03
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,378,256.57	5,378,787.70
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,378,787.70	7,004,135.74

